

ТАВАНТОЛГОЙ-ЗҮҮНБАЯН ЧИГЛЭЛИЙН  
ТӨМӨР ЗАМЫН ТӨСӨЛ

**ИЛ БОЛСОН**

"МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

болон

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБ

нарын хооронд байгуулсан

---

ТАВАНТОЛГОЙ-ЗҮҮНБАЯН ЧИГЛЭЛИЙН ТӨМӨР ЗАМЫН  
ШУГАМЫН ДООД БҮТЦИЙН БАРИЛГЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ  
ГЭРЭЭ

---

Огноо:

2019 оны 06 сарын ...-ны өдөр


*Гүндэн 65 хуудас*

"МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ" ТӨХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.ЦЭНГЭЛ

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБЫН  
ДАРГА, ХОШУУЧ ГЕНЕРАЛ



АГАНБАТ

ТАВАНТОЛГОЙ-ЗҮҮНБАЯН ЧИГЛЭЛИЙН  
ТӨМӨР ЗАМЫН ШУГАМЫН ДООД БҮТЦИЙН  
БАРИЛГЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

Дугаар ..... АГТ-Н /1901 ..... Улаанбаатар хот

11357

ЭНЭХҮҮ ГЭРЭЭГ Монгол Улсын Иргэний хуулийн 189 дугаар зүйл, 343-358 дугаар зүйл, Зэвсэгт хүчний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т заасныг удирдлага болгон дор дурдсан Талууд харилцан тохиролцож 2019 оны 06 дугаар сарын 12-ны өдөр байгуулав.

Талууд:

ИЛ БОЛСОН

Нэр

МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ ТӨХК (цаашид "МТЗ" гэх);

Нэр

Монгол Улсын тохируулагч агентлаг ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ  
ЖАНЖИН ШТАБ (цаашид "ЗХЖШ" гэх)

1. Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолоор баталсан Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогод заасан Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төсөл (цаашид "Төсөл" гэх)-ийн хүрээнд энэхүү Гэрээний хавсралт-6 (Ажлын техникийн даалгавар ба Захиалагчийн шаардлага)-д заасан ажлыг гүйцэтгэхтэй холбоотой Захиалагч, Гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү Гэрээний ач холбогдол оршино.
2. Талууд Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын шугамын доод бүтцийг барих ажил (цаашид "ажил" гэх)-ыг Гэрээний 14.1-д заасан үнэ (цаашид "Гэрээний үнэ" гэх)-ээр гүйцэтгэхийг хүлээн зөвшөөрч байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Гүйцэтгэгч нь Гэрээний хавсралт-6 (Ажлын техникийн даалгавар ба Захиалагчийн шаардлага)-д заасан ажлыг холбогдох хууль тогтоомж, стандарт, норм, нормативын бусад баримт бичигт заасан шаардлагад нийцүүлэн зохих ёсоор, чанартай гүйцэтгэж, Гэрээний хавсралт дахь барилгын календарчилсан төлөвлөгөөнд заасан хугацааны дотор Захиалагч (түүний техникийн хяналтын зөвлөх байж болно)-д зохих журмын дагуу хүлээлгэн өгнө.
4. Захиалагч, Гүйцэтгэгч нь энэ гэрээ болон Гэрээний баримт бичгүүдэд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.
5. Гүйцэтгэгч нь энэхүү Гэрээний бүх нөхцөл, шаардлагад нийцүүлэн Гэрээнд заасан ажлыг гүйцэтгэж, илэрсэн зөрчил, доголдлыг арилгах үүрэг, хариуцлагыг хүлээж байна.
6. Захиалагч нь Гэрээний дагуу Гүйцэтгэгчийн хийх ажил, илэрсэн зөрчил, доголдлыг арилгасан ажлын гүйцэтгэлийг үндэслэн Гүйцэтгэгчид Гэрээний төлбөрийг төлөх үүрэг, хариуцлага хүлээж байна.
7. Гэрээнд холбогдох асуудлаар Талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

8. Гэрээний Хавсралт 2 ба 3-т заасан утга, агуулгыг бүрэн илэрхийлсэн шийдвэрүүд албан ёсоор гарсан өдөр, гэрээ байгуулах зөвшөөрөл олгох тухай "Монголын төмөр зам" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр гарсан өдрийн аль сүүлд тохиосон өдөр энэ Гэрээ хүчин төгөлдөр болно.
9. Дор дурдсан баримт бичгүүд Гэрээний хэсэг болно (цаашид "Гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:
- Хавсралт-1: Гэрээний нөхцөл
  - Хавсралт-2: Засгийн газар, эрх бүхий төрийн байгууллагын шийдвэр: (1) Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийг төрийн нууцад хамааруулах, (2) Зэвсэгт хүчний жанжин штабыг Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн бүтээн байгуулалтад оролцуулах асуудлыг тус тус шийдвэрлэсэн;
  - Хавсралт-3: Засгийн газар, эрх бүхий төрийн байгууллагын шийдвэр: (1) "МТЗ" ТӨХК-д олгосон Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын барилгын ажлын зөвшөөрөл (2) ЗХЖШ-д олгосон төмөр замын шугамын доод бүтцийн барилга угсралтын ажил эрхлэх зөвшөөрөл;
  - Хавсралт-4: Эрх бүхий байгууллагаар магадлагдсан Төслийн техник, эдийн засгийн үндэслэл, ажлын болон техникийн зураг төсөл, ажлын тоо хэмжээ;
  - Хавсралт-5: Техникийн шаардлага;
  - Хавсралт-6: Ажлын техникийн даалгавар ба Захиалагчийн шаардлага
  - Хавсралт-7: Барилгын үе шатны ажлын календарчилсан төлөвлөгөө;
  - Хавсралт-8: Барилгын ажил гүйцэтгэх талбайн болон үйлдвэрлэлийн зохион байгуулалтын төлөвлөгөө;
  - Хавсралт-9: Байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн болон нийгмийн менежментийн төлөвлөгөө;
  - Хавсралт-10: Ажлын төсөвт өртгийн товчоо;
  - Хавсралт-11: Ажлын гүйцэтгэлийг санхүүжүүлэх нөхцөл;
  - Хавсралт-12: Төслийн барилгын ажлын урьдчилгаа төлбөр олгох гэрээ;
  - Хавсралт-13: Төслийн барилгын үйл ажиллагаанд баримтлах норм, нормативын баримт бичиг (норм, дүрэм, журам, барилгын болон техникийн дүрэм, заавар цомог, аргачлал, стандарт)-ийн нэгдсэн жагсаалт;
10. Хэрэв Гэрээний баримт бичигт хоёрдмол утга, утгын зөрүүтэй байдал тогтоогдвол Инженер нь шаардлагатай тодруулга, зааврыг гаргаж өгнө. Гэрээний нөхцөлд тусгагдсан технологийн шинжтэй Талуудын хоорондын харилцаанд баримтлах хугацаа (хоног, өдөр заасан)-г Инженерийн саналыг үндэслэн Талууд харилцан зөвшилцөж өөрчлөн тогтоож болно.
11. Гэрээ нь энэ гэрээ, түүний хавсралтууд болон энэ гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой төмөр замын суурь бүтцийн барилгын ажлын Захиалагч, Гүйцэтгэгч нарын хооронд байгуулсан 2 ба 3 талт бусад гэрээнээс бүрдэнэ.


МАШ НУУН

**ИЛ БОЛСОН**


ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

 Д.ДАВААДОРЖ


ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ БҮТЭЭН  
БАЙГУУЛАЛТЫН ДЭМЖЛЭГИЙН  
ГАЗРЫН ДАРГА, ХУРАНДАА

 Г.БАТСУУРЬ  
2019.06.13/19

ХУУЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

 Р.БЯМБАА

ЗХЖШ-ЫН САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН  
ДАРГА, ХУРАНДАА

 Л.БААТАР  
2019.06.13/19

ИНЖЕНЕР, ТЕХНОЛОГИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

 Д.НЯМЛХАГВА

ЗХЖШ-ЫН ХУУЛИЙН ЗӨВЛӨХ-АХЛАХ  
МЭРГЭЖИЛТЭН, ДЭД ХУРАНДАА

 Б.БАЛЖИННЯМ

**ИЛ БОЛСОН**

<b>ХАВСРАЛТ-1. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ</b> .....	<b>10</b>
<b>1. Нэр томъёоны тодорхойлолт</b> .....	<b>10</b>
1.1. Тодорхойлолт .....	10
1.2. Хууль тогтоомж, гэрээг тайлбарлах.....	12
1.3. Мэдээлэл солилцох .....	13
1.4. Хууль ба хэл.....	14
1.5. Эрх шилжүүлэх .....	14
1.6. Баримт бичгийг хадгалах, хамгаалах.....	14
1.7. Ажлын зураг болон зааварчилгааг хугацаа алдаж танилцуулах .....	14
1.8. Гүйцэтгэгчийн баримт бичгийг Захиалагч ашиглах.....	15
1.9. Захиалагчийн баримт бичгийг Гүйцэтгэгч ашиглах.....	15
1.10. Нууцлал.....	15
1.11. Хуулийг дагаж мөрдөх.....	16
1.12. Хамтарсан болон хэсэгчилсэн үүрэг хариуцлага .....	16
<b>2. Захиалагч</b> .....	<b>16</b>
2.1. Ажлын талбайд нэвтрэх эрх.....	16
2.2. Холбогдох зөвшөөрлүүд.....	17
2.3. Захиалагчийн ажилтан.....	18
2.4. Захиалагчийн санхүүжилт.....	18
2.5. Захиалагчийн нэхэмжлэх.....	19
<b>3. Инженер</b> .....	<b>19</b>
3.1. Инженерийн эрх, үүрэг .....	19
3.2. Инженерийн төлөөлөгч .....	20
3.3. Инженерийн заавар, зөвлөмж .....	21
3.4. Инженерийг солих.....	21
3.5. Шийдвэр.....	21
<b>4. Гүйцэтгэгч</b> .....	<b>21</b>
4.1. Гүйцэтгэгчийн ерөнхий үүрэг.....	21
4.2. Гүйцэтгэлийн баталгаа .....	22
4.3. Гүйцэтгэгчийн төлөөлөгч.....	22
4.4. Туслан Гүйцэтгэгч .....	23
4.5. Туслан Гүйцэтгэгчийн үүргийг шилжүүлэх .....	23
4.6. Хамтран ажиллах.....	23
4.7. Ажлыг эхлүүлэх арга хэмжээг зохион байгуулах .....	24
4.8. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэг журам.....	25
4.9. Чанарын баталгаа .....	25
4.10. Ажлын талбайтай холбоотой мэдээлэл.....	25
4.11. Урьдчилан таамаглах боломжгүй нөхцөл, байдал .....	26
4.12. Талбайн зурваст нэвтрэх эрх.....	26
4.13. Хөндлөнгийн нөлөөлөл үзүүлэхээс зайлсхийх .....	26

4.14.	Нэвтрэх зам барих.....	27
4.15.	Бараа, материалыг тээвэрлэх.....	27
4.16.	Гүйцэтгэгчийн техник хэрэгсэл.....	27
4.17.	Байгаль орчныг хамгаалах.....	27
4.18.	Байгалийн нөөц, цахилгаан, ус, хийн ашиглалт.....	28
4.19.	Захиалагчийн техник, хэрэгсэл болон хөнгөлөлттэй үнээр ашиглах материал.....	28
4.20.	Ажлын явцын тайлан.....	28
4.21.	Талбай дээр ажиллах баталгаа.....	29
4.22.	Гүйцэтгэгчийн талбайн ашиглалт.....	29
4.23.	Эртний олдвор.....	29
<b>5.</b>	<b>Хүлээн зөвшөөрөгдсөн туслан гүйцэтгэгч.....</b>	<b>30</b>
5.1.	Хүлээн зөвшөөрөгдсөн туслан гүйцэтгэгчийн тодорхойлолт.....	30
5.2.	Туслан гүйцэтгүүлэхээс татгалзах.....	30
5.3.	Хүлээн зөвшөөрөгдсөн туслан гүйцэтгэгчид төлөх төлбөр.....	30
5.4.	Төлбөрийг нотлох баримт бичиг.....	30
<b>6.</b>	<b>Ажиллах хүч, ажилтан.....</b>	<b>30</b>
6.1.	Ажилтан хөлслөх.....	30
6.2.	Цалингийн үнэлгээ, ажиллуулах нөхцөл байдал.....	31
6.3.	Захиалагчийн үйлчилгээнд ажиллах ажилтан.....	31
6.4.	Хөдөлмөрийн тухай хууль.....	31
6.5.	Ажлын цаг.....	31
6.6.	Ажилтныг ажиллах нөхцөлөөр хангах.....	31
6.7.	Байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй болон нийгмийн менежмент.....	32
6.8.	Гүйцэтгэгчийн хяналт-шалгалт.....	33
6.9.	Гүйцэтгэгчийн ажилтан.....	34
6.10.	Гүйцэтгэгчийн ажилтан, техник хэрэгслийн бүртгэл.....	34
6.11.	Замбараагүй байдлыг цэгцлэх.....	34
6.12.	Гадаадын ажиллах хүч.....	34
6.13.	Хүнсний бүтээгдэхүүний хангалт.....	35
6.14.	Усны хангамж.....	35
6.15.	Хорхой шавьж болон халдварт өвчний эсрэг авах арга хэмжээ.....	35
6.16.	Согтууруулах ундаа болон мансууруулах бодис хэрэглэх.....	35
6.17.	Зэр зэвсэг хэрэглэх.....	35
6.18.	Баяр ёслол, шашны ёс заншил.....	35
6.19.	Гашуудлын арга хэмжээ.....	36
6.20.	Албадан ажил хийлгэхийг хориглох.....	36
6.21.	Хүүхдийг хөлслөн ажиллуулахыг хориглох.....	36
6.22.	Ажиллагсдын ажил эрхлэлтийн бүртгэл.....	36
<b>7.</b>	<b>Барилгын материал болон ажилчдын ур чадвар.....</b>	<b>36</b>
7.1.	Ажиллах чадвар.....	36
7.2.	Материалын сорьц.....	36
7.3.	Хяналт-Шалгалт.....	37

## ИЛ БОЛСОН

7.4.	Туршилт.....	37
7.5.	Ажлыг хүлээн авахаас татгалзах.....	38
7.6.	Засаж залруулах ажил.....	38
7.7.	Техник хэрэгсэл, материалын эзэмшил.....	38
7.8.	Ашиглалтын төлбөр.....	39
8.	<b>Ажил эхлүүлэх, хойшлуулах , түр зогсох.....</b>	<b>39</b>
8.1.	Ажлыг эхлүүлэх.....	39
8.2.	Ажил дуусгах хугацаа.....	39
8.3.	Ажлын хуваарь.....	39
8.4.	Ажил дуусах хугацааг сунгах.....	40
8.5.	Эрх бүхий байгууллагаас болж хугацаа хойшлогдох.....	40
8.6.	Ажлын явцын үнэлгээ.....	41
8.7.	Хугацаа хоцроосны хохирол нөхөн төлөх.....	41
8.8.	Ажлыг түр зогсоох.....	41
8.9.	Ажлыг түр зогсоосноос гарах үр дагавар.....	41
8.10.	Түр зогсолтын үеийн материалын төлбөр.....	42
8.11.	Түр зогсолтын хугацааг сунгах.....	42
8.12.	Ажлыг үргэлжлүүлэх.....	42
9.	<b>Ажлыг дуусгах үеийн туршилтууд.....</b>	<b>42</b>
9.1.	Гүйцэтгэгчийн үүрэг, хариуцлага.....	42
9.2.	Хугацаа хоцорч хийгдсэн туршилтууд.....	43
9.3.	Туршилтыг дахин хийх.....	43
9.4.	Ажлыг дуусгах үеийн туршилт хийгдээгүйн хохирол.....	43
10.	<b>Захиалагчийн зүгээс ажлыг хүлээн авах.....</b>	<b>43</b>
10.1.	Ажил болон ажлын тодорхой хэсгийг хүлээн авах.....	43
10.2.	Урьдчилсан байдлаар ажлыг хүлээн авсан тухай гэрчилгээ.....	44
10.3.	Урьдчилсан байдлаар хүлээн авсан байх эцсийн хугацааны дараах Гүйцэтгэгчийн хандалт.....	44
10.4.	Ажлын үр дүнг эцсийн байдлаар хүлээлгэн өгөх.....	44
	Гүйцэтгэгч ажлын үр дүнг хүлээлгэн өгөхдөө дараах баримт бичгүүдийг бүрдүүлсэн байна. Үүнд: 44	
	Энэ зүйлийн 10.4.1-д заасан баримт бичгийн иж бүрдэл бүрэн бус тохиолдолд Захиалагч ажлын үр дүнг хүлээн авахаас татгалзана.....	44
10.5.	Ажлыг дуусгах үеийн туршилтад нөлөөлөх хөндлөнгийн саад.....	44
10.6.	Засах шаардлагатай ажлууд.....	45
11.	<b>Баталгаат засвар.....</b>	<b>45</b>
11.1.	Хийгдээгүй ажлыг дуусгаж, доголдлыг засах.....	45
11.2.	Илэрсэн доголдлыг засах зардал.....	45
11.3.	Баталгаат засварын хугацааг сунгах.....	45
11.4.	Илэрсэн зөрчил, эвдрэл, гэмтлийг арилгаснаас үүсэх хохирол.....	46
11.5.	Эвдрэл, гэмтэлтэй ажлыг гаргах.....	46
11.6.	Дараагийн туршилтууд.....	46
11.7.	Нэвтрэх эрх.....	46



11.8.	Гүйцэтгэгчийн хайгуул, шинжилгээ.....	46
11.9.	Гүйцэтгэлийн акт.....	47
11.10.	Үүргээ бүрэн биелүүлээгүй байдал.....	47
11.11.	Талбайг цэвэрлэх.....	47
<b>12.</b>	<b>Хэмжилт ба үнэлгээ.....</b>	<b>47</b>
12.1.	Хэмжилт хийх ажил.....	47
12.2.	Хэмжилт хийх аргачлал.....	48
<b>13.</b>	<b>Өөрчлөлт болон тохируулга.....</b>	<b>48</b>
13.1.	Ажилд өөрчлөлт оруулах эрх.....	48
13.2.	Инженерийн үнэлгээ.....	48
13.3.	Өөрчлөлт хийх журам.....	49
13.4.	Хэрэглэж болох валютаар хийгдэх төлбөр.....	49
13.5.	Түр тооцсон дүн.....	49
13.6.	Ажил-өдөр.....	50
13.7.	Хууль, эрх зүйн орчинд орох өөрчлөлтийг тохируулах.....	50
13.8.	Зардлын өөрчлөлтийг тохируулах.....	51
<b>14.</b>	<b>Гэрээний үнэ, төлбөр.....</b>	<b>51</b>
14.1.	Гэрээний үнэ.....	51
14.2.	Урьдчилгаа төлбөр.....	51
14.3.	Явц дундын төлбөр авах хүсэлт.....	52
14.4.	Явц дундын төлбөр төлөх.....	52
14.5.	Төлбөр төлөх хугацаа.....	53
14.6.	Барьцаа хөрөнгө, түүнийг чөлөөлөх.....	53
14.7.	Ажил дууссан үеийн тайлан, мэдээ.....	54
14.8.	Эцсийн төлбөр авах хүсэлт.....	54
14.9.	Эцсийн төлбөр.....	54
14.10.	Захиалагчийн хариуцлагын хязгаарлалт.....	54
<b>15.</b>	<b>Захиалагчийн зүгээс гэрээг цуцлах.....</b>	<b>55</b>
15.1.	Зөрчил, доголдлыг засах.....	55
15.2.	Захиалагчийн зүгээс гэрээг цуцлах.....	55
15.3.	Гэрээг цуцлах өдөр гаргах үнэлгээ.....	56
15.4.	Гэрээг цуцалсаны дараах төлбөр.....	56
15.5.	Гэрээг цуцлах Захиалагчийн эрх.....	56
<b>16.</b>	<b>Гүйцэтгэгч гэрээг түр зогсоох болон цуцлах.....</b>	<b>57</b>
16.1.	Ажлыг түр зогсоох Гүйцэтгэгчийн эрх.....	57
16.2.	Гүйцэтгэгч гэрээг дуусгавар болгох.....	57
16.3.	Гүйцэтгэгчийн техник хэрэгслийн ашиглалт болон ажлыг зогсоох.....	58
16.4.	Цуцлах үед төлөх төлбөр.....	58
<b>17.</b>	<b>Эрсдэл ба хариуцлага.....</b>	<b>58</b>
<b>17.1.</b>	<b>Хохирлыг арилгах баталгаа.....</b>	<b>58</b>
17.2.	Ажилд Гүйцэтгэгч хариуцлагатай хандах.....	59
17.3.	Захиалагчийн эрсдэл.....	60



17.4.	Захиалагчийн эрсдлийн үр дагавар.....	60
17.5.	Оюуны болон үйлдвэрлэлийн өмчийн эрх .....	61
17.6.	Хариуцлагын хязгаарлалт.....	61
18.	Даатгал .....	62
18.1.	Даатгал .....	62
19.	Давагдашгүй хүчин зүйл.....	63
19.1.	Давагдашгүй хүчин зүйл .....	63
19.2.	Давагдашгүй хүчин зүйлийн мэдэгдэл.....	64
19.3.	Давагдашгүй хүчин зүйлийн үр дагавар.....	64
19.4.	Хүнд нөхцөл байдал .....	64
19.5.	Хүнд нөхцөл байдлын үр дагавар.....	65
20.	Нэхэмжлэл, маргаан болон шүүхийн ажиллагаа .....	65
20.1.	Гүйцэтгэгчийн нэхэмжлэл.....	65
20.2.	Маргааныг эвлэрлийн журмаар шийдвэрлэх.....	65
20.3.	Төрийн захиргааны байгууллага .....	65
20.4.	Шинжээчээр шийдвэрлүүлэх .....	65
20.5.	Шүүхээр шийдвэрлүүлэх.....	65

## ИЛ БОЛСОН

## ХАВСРАЛТ-1. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

## 1. Нэр томъёоны тодорхойлолт

## 1.1. Тодорхойлолт

## 1.1.1. Гэрээ

- (a) “Гэрээ” гэж Захиалагч, Гүйцэтгэгчийн хооронд байгуулсан Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын шугамын доод бүтцийн барилгын ажил гүйцэтгэх гэрээг, Гэрээний баримт бичгүүдийн бүрдлийн хамт хэлнэ.
- (b) “Гэрээний нөхцөл” гэж Гэрээний зүйл, хэсэг, заалт, дэд заалт, Гэрээний баримт бичгүүдэд тусгагдсан Талуудын баримтлах, дагаж мөрдөх, хэрэгжүүлэх нөхцөлийг хэлнэ.
- (c) “Гэрээ хүчин төгөлдөр болох огноо” гэж Гэрээний 8 дугаар зүйлд заасан огноог;
- (d) “Зураг төсөл” гэж Барилгын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.30-д тодорхойлсноор ойлгох бөгөөд Гэрээний 4, 5, 6, 7, 8 дугаар хавсралт дахь баримт бичгүүдийг хэлнэ.
- (e) “Эрх бүхий байгууллага” гэж Барилын ажлын зураг төсөл магадлах, холбогдох зөвшөөрөл, тусгай зөвшөөрлийг олгох, хяналт тавих, удирдлагаар хангаж чиглэл өгөх, барилгын ажлыг гүйцэтгэхтэй холбоотой аливаа асуудлаар шийдвэр гаргах эрх хуулиар олгогдсон төрийн болон орон нутгийн захиргааны (бүх шатны) байгууллагуудыг;

## 1.1.2. Талууд болон Төлөөлөл

- (a) “Тал, эсхүл Талууд” гэж Захиалагч болон Гүйцэтгэгчийг, эсхүл Хамтад;
- (b) “Захиалагч” гэж “Монголын төмөр зам” ТӨХК, түүний эрх, үүрэг, хариуцлагыг шилжүүлэн авсан этгээд;
- (c) “Гүйцэтгэгч” гэж Зэвсэгт хүчний жанжин штаб, түүний эрх, үүрэг, хариуцлагыг шилжүүлэн авсан этгээд;
- (d) “Инженер” гэж ажлын талбайд Захиалагчийг төлөөлөх эрх бүхий Захиалагчийн томилсон этгээд, эсхүл Захиалагч тодорхой хугацаагаар томилсон болон Гэрээний 3.4 (Инженерийг солих)-т заасны дагуу Гүйцэтгэгчид мэдэгдсэн этгээдийг;
- (e) “Гүйцэтгэгчийн төлөөлөгч” гэж Гэрээнд Гүйцэтгэгчийн төлөөлөгч гэж заасан этгээд эсхүл Гэрээний 4.3 (Гүйцэтгэгчийн төлөөлөгч)-т заасан тодорхой хугацаагаар Гүйцэтгэгчийг төлөөлөхөөр Гүйцэтгэгчийн томилсон этгээд байна.
- (f) “Захиалагчийн ажилтан” гэж Гэрээний 3.2 (Инженерийн төлөөлөгч)-т заасны дагуу ажиллах Захиалагчийн томилсон Инженер, Захиалагч болон Инженерийн зүгээс ажиллуулж байгаа бүх Зөвлөх, ажилтан, мөн Захиалагч, Инженерийн зүгээс Гүйцэтгэгчид мэдэгдсэн бусад ажилтнууд байна.
- (g) “Гүйцэтгэгчийн ажилтан” гэж Гүйцэтгэгчийн төлөөлөгч болон ажлын талбайд ажиллах цэргийн албан хаагчид, Гүйцэтгэгч, түүний туслан гүйцэтгэгч нарын гэрээт ажиллагсад, эдгээртэй адилтгах бусад ажиллах хүчийг бүгдийг хамааруулан ойлгоно.
- (h) “Туслан Гүйцэтгэгч” гэдэг нь Гэрээнд туслан гүйцэтгэгч гэж заагдсан аливаа этгээд, эсхүл ажлын нэг хэсгийг гүйцэтгэхээр Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан хуулийн этгээд байна.

**ИЛ БОЛСОН****1.1.3. Эхлэх, дуусгах хугацаа болон туршилтууд**

- (a) "Үндсэн хугацаа" гэж энэхүү Гэрээт ажлыг гүйцэтгэх ажлын хуваарьт заасан хугацааг.
- (b) "Ажил эхлэх хугацаа" гэж Гэрээний 8.1 (Ажил эхлүүлэх хугацаа)-д заасны дагуу Захиалагчаас Гүйцэтгэгчид мэдэгдэл өгсөн хугацааг хэлнэ.  
"Ажил дуусахын өмнөх туршилтууд" гэж Гэрээнд заагдсан, эсхүл хоёр тал зөвшөөрсөн, эсхүл өөрчлөхөөр зааварчилсан туршилт байх ба
- (c) Захиалагчийн хүлээн авах ажил, ажлын тодорхой хэсгийг дуусахын өмнө Гэрээний 9 (Ажил дуусгах туршилт)-д заасны дагуу хийгдсэн туршилтыг хэлнэ.
- (d) "Ажил хүлээн авах акт" гэж Гэрээний 10 (Захиалагчаас ажлыг хүлээн авах)-т заасан актыг хэлнэ.  
"Ажил дууссаны дараах туршилт" гэж (хэрэв байгаа бол) Гэрээнд заагдсан, Захиалагчийн хүлээн авах ажил болон ажлын тодорхой хэсгийг дууссаны дараа техникийн шаардлагын дагуу хийгдэх туршилтыг хэлнэ.
- (e) "Баталгаат засварын хугацаа" гэж Гэрээний 11.1 (Хийгдээгүй ажлыг дуусгах болон баталгаат хугацаанд доголдлыг засах), болон 4.9 (чанарын баталгаа)-т заасны дагуу Ажил болон Хэсэг ажилд гарсан доголдлыг засах чанарын баталгаат хугацааг хэлэх ба хэрэв Гэрээний нөхцөлд өөрөөр заагаагүй бол Гэрээний 10.1(Ажил болон хэсэг ажлыг хүлээн авах)-т заасны дагуу хүлээлгэн өгсөн ажил болон хэсэг ажлыг дуусгаж хүлээлгэн өгсөн хугацаанаас тооцно.
- (f) "Гүйцэтгэлийн акт" гэж Гэрээний 11.9 (Гүйцэтгэлийн акт)-д заасны дагуу гаргасан гэрчилгээг хэлнэ.
- (g) "Өдөр" гэж календарийн өдөр, "жил" гэдэг нь 365 хоногийг хэлнэ.

**1.1.4. Төлбөрийн нөхцөлүүд**

- (a) "Гэрээний үнэ" гэж Гэрээний 14.1 (Гэрээний дүн)-д заасан үнийг хэлнэ.
- (b) "Эцсийн төлбөр авах хүсэлт" гэж Гэрээний 14.13 (Эцсийн төлбөр авах хүсэлт)-т заасан хүсэлтийг хэлнэ.
- (c) "Ажил дууссан үеийн тайлан, мэдээ" гэж Гэрээний 14.7 (Эцсийн төлбөр авах хүсэлтний өргөдөл)-д заасан тайлан, мэдээг хэлнэ.  
"Явц дундын төлбөр авах хүсэлт" гэж Гэрээний 14 (Гэрээний үнэ болон төлбөр)-т заасан эцсийн төлбөр авах хүсэлтээс бусад төлбөрийн хүсэлтийг хэлнэ.
- (d) "Түр тооцсон дүн" гэж Гэрээний 13.5 (Түр тооцсон дүн)-д заасны дагуу материал, үйлчилгээ болон ажлын нэг хэсгийг гүйцэтгэхэд зарцуулах зорилгоор Гэрээнд түр тооцсон дүн гэдгээр тусгасан "дүн"-г хэлнэ.
- (e) "Барьцаа хөрөнгө" гэж Захиалагч Гэрээний 14.6 (Барьцаа хөрөнгө, түүнийг чөлөөлөх)-д заасны дагуу ажлын гүйцэтгэлийн төлбөрөөс тогтоосон хувиар суутгасан мөнгөн хөрөнгийг хэлнэ.

**1.1.5. Ажил болон бараа**

- (a) "Гүйцэтгэгчийн техник хэрэгсэл" гэж ажил гүйцэтгэх болон доголдлыг засахад шаардлагатай бүх тоног төхөөрөмж, машин, механизм, авто машин, бусад зүйлсийг хэлнэ. Гэхдээ, энэ тоног төхөөрөмжид түр ажил гүйцэтгэх болон Захиалагчийн техник хэрэгсэл, материал, бусад зүйлс орохгүй.

**ИЛ БОЛСОН**

МАШ НУУД

- (b) **“Бараа”** гэж Гүйцэтгэгчийн техник хэрэгсэл, материал, түр ажил, түүнтэй холбоотой бусад зүйлс орно.
- (c) **“Материал”** гэж Гэрээний дагуу байнгын ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай Гүйцэтгэгчийн техник хэрэгслээс бусад бүх төрлийн материалыг хэлнэ.
- (d) **“Байнгын ажил”** гэж Гэрээний дагуу Гүйцэтгэгчийн тогтмол гүйцэтгэх ажлыг хэлнэ.
- (e) **“Техник хэрэгсэл”** гэж Гэрээний дагуу барилгын ажлыг гүйцэтгэхээр худалдан авсан автомашиныг оруулаад байнгын ажил гүйцэтгэхэд шаардагдах техник, тоног төхөөрөмж, машин, механизм болон бусад багаж хэрэгслийг хэлнэ.
- (f) **“Хэсэг ажил”** гэж Барилгын ажлыг хэсэгчлэн гүйцэтгэхтэй холбоотойгоор Гэрээний нөхцөлд тусгагдсан дараа, дараагийн үе шатанд хэсэгчлэн гүйцэтгэх ажлын тодорхой хэсэг, хэсгүүдийг хэлнэ.
- (g) **“Түр ажил”** гэж байнгын ажлыг гүйцэтгэх, дуусгах болон доголдлыг засахад ажлын талбай дээр шаардлагатай Гүйцэтгэгчийн техник хэрэгслээс бусад түр гүйцэтгэх бүх ажлыг хэлнэ.

**1.1.6. Бусад тодорхойлолт**

- (a) **“Захиалагчийн баримт бичиг”** гэж энэ Гэрээнд Захиалагч хадгалахаар тусгасан баримт бичгүүд, захиалагчийн нэр дээр эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл, төрийн захиргааны болон орон нутгийн байгууллагатай байгуулсан гэрээ, энэ Гэрээ, Хамтран ажиллах ерөнхий гэрээнд заасны дагуу Гүйцэтгэгчийн хүлээлгэн өгсөн ажлын гүйцэтгэл, үр дүнгийн баримт бичгүүдийг хэлнэ;
- (b) **“Гүйцэтгэгчийн баримт бичиг”** гэж Гэрээний дагуу Гүйцэтгэгчийн ашиглах тайлан тооцоо, компьютерийн программ, Инженерийн зургууд, гарын авлага, зааварчилгаа, аргачлал болон техникийн бусад баримт бичгүүд, энэ Гэрээ болон Хамтран ажиллах ерөнхий гэрээнд заасны дагуу ажлын гүйцэтгэл, үр дүнг хүлээлгэн өгөхөд бүрдүүлбэл зохих баримт бичгүүд, мөн эдгээр гэрээнд Гүйцэтгэгчийн баримт бичиг гэж нэрлэсэн бусад баримт бичгийг хэлнэ.
- (c) **“Ажлын талбай”** гэж байнгын болон түр ажил явагдаж байгаа, бараа, материалыг тээвэрлэх, хадгалах, ашиглах газрууд, ажлын талбайн нэг хэсэг гэж үзсэн Гэрээнд заасан бусад бүхий л газрыг ойлгоно.
- (d) **“Захиалагчийн техник хэрэгсэл”** гэж техникийн шаардлагад заасан ажлыг гүйцэтгэх ашиглах зориулалтаар Гүйцэтгэгчид гэрээнд заасан нөхцөлөөр ашиглуулж байгаа Захиалагчийн эзэмшил, өмчлөлийн техник хэрэгсэл, машин механизм, автомашиныг хэлнэ (Үүний ашиглалттай холбоотой харилцааг тусдаа гэрээгээр зохицуулах бөгөөд харин ийнхүү ашигласны төлбөрийг энэ Гэрээний төлбөрийг төлөхөд харилцан суутгаж болно).
- (e) **“Давагдашгүй хүчин зүйл”** гэж Гэрээний 19 (*Давагдашгүй хүчин зүйл*)-д тодорхойлсноор байна.
- (f) **“Урьдчилан таамаглах боломжгүй хүчин зүйл”** гэж үндсэн хугацаанд Гүйцэтгэгч Захиалагч нь боломжит зүйлийг урьдчилан таамаглаж чадаагүйг хэлнэ.
- (g) **“Өөрчлөлт”** гэж Гэрээний 13 (*Өөрчлөлт болон тохируулга*)-т заасан өөрчлөлт гэдгээр эсхүл ямар нэгэн зааварчилгаагаар ажилд өөрчлөлт оруулахыг хэлнэ.

**1.2. Хууль тогтоомж, гэрээг тайлбарлах**

**ИЛ БОЛСОН**

Гэрээнд өөрөөр заагаагүй бол үг хэллэгийг дараах байдлаар ойлгоно.

- (a) Нэг хүйс заасан үгийг бүх хүйсийг багтаасан гэж;
- (b) Нэг тоог заасан үгэнд олон тоог багтааж, олон тоог заасан үгэнд нэг тоог багтаасан гэж;
- (c) "бичигдсэн" болон "бичгээр" гэсэн үгнүүдэд гараар бичигдсэн, машинаар бичигдсэн, хэвлэн бичигдсэн эсхүл цахим хэлбэрээр бичигдсэн. үр дүн нь байнгын тэмдэглэл болсон гэж;
- (d) Гэрээ байгуулахад бичгээр тэмдэглэгдэх "зөвшөөрөх", "зөвшөөрсөн" болон "зөвшилцөл" гэдэг үгнүүдийг Гэрээний нөхцөлд багтаасан гэж ойлгох.

Гэрээний зүйл, хэсэг, заалт, үг, өгүүлбэрийг энэ Гэрээнд заасан нэр томъёог үндэслэн тайлбарлах бөгөөд хэрэв энэ Гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд Гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв Гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлах боломжгүй тохиолдолд Гэрээ байгуулах үед хүчин төгөлдөр үйлчилж байсан Монгол Улсын хуульд заасныг баримтлана.

Захиалагч, Гүйцэтгэгч болон аливаа бусад этгээдийн хооронд байгуулсан Гэрээ гэх ойлголтод тухайн үед орсон нэмэлт, өөрчлөлт, хавсралт, орчуулга эсхүл эрх нь шилжсэн тэдгээр Гэрээг ойлгоно.

**1.3. Мэдээлэл солилцох**

1.3.1. Гэрээний талууд үйл ажиллагаа явуулахад шаардлагатай мэдээллийг харилцан солилцож байна.

1.3.2. "Монголын төмөр зам" ТӨХК

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 13 хороолол /14230/, Нарны зам-62 Юнион бюлдинг А блок 7 давхар

Утас: 7000-6622, 7010-6655

Имэйл: [info@mtz.mn](mailto:info@mtz.mn)

1.3.3. Зэвсэгт хүчний жанжин штаб

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 5-р хороо, Энхтайваны өргөн чөлөө-51,

Утас: 51 265914, 11 452933;

Имэйл: [maba@mil.gov.mn](mailto:maba@mil.gov.mn)

1.3.4. Мэдээлэл, бичиг баримт, албан бичгийг биечлэн хүлээлгэн өгсөн бол баримт авах бөгөөд цахим шуудан, факс зэрэг электрон дамжуулах аргаар хүргүүлж болно.

Гэрээнд заасан хүлээн авагчийн хаягаар мэдээлэл, албан бичиг, баримт бичиг хүргүүлэх, явуулах, дамжуулах үед:

- (a) хэрэв хүлээн авагч нь өөр хаяг руу явуулж байх тухай мэдэгдэл өгсөн бол тухайн мэдэгдэл авснаас хойш мэдэгдсэн хаяг руу нь явуулна;
- (b) Хэрэв хүлээн авагч нь зөвшөөрөл, баталгаа хүсэхдээ өөрөөр тусгайлан заагаагүй бол хариуг тухайн хүсэлт ирүүлсэн хаяг руу нь явуулж болно.

Талууд мэдээллийг цахим шуудангаар харилцан хүргүүлсэн бол цаасан баримтаар давхар хүргүүлнэ.

**ИЛ БОЛСОН**

- 1.3.5. ~~Захиалагч нь Ажил~~ гүйцэтгэхэд шаардлагатай мэдээ, баримт, зааварчилгааг Гүйцэтгэгчийн хүсэлтийн дагуу боломжит хугацаанд гаргаж өгнө.
- 1.3.6. Аливаа зөвшөөрөл, гэрчилгээ, тодорхойлолтыг шалтгаангүйгээр дарах, хугацаа алдан хойшлуулж болохгүй. Аливаа зөвшөөрөл, баримт бичгийг Гэрээний нэг Талд гаргасан бол тэр даруй нөгөө Талд хуулбарыг хүргүүлнэ. Аливаа мэдэгдлийг Гэрээний нэг Талд гаргасан бол тэр даруй нөгөө Талд болон Инженерт хуулбарыг хүргүүлнэ.

**1.4. Хууль ба хэл**

Гэрээ нь Монгол Улсын хууль тогтоомж, стандарт, норм, дүрэм, журмын дагуу хэрэгжинэ.

Барилгын ажилд ашиглаж байгаа стандарт өөр хоорондоо зөрчилдөх тохиолдолд хамгийн үр ашигтай, тохиромжтой стандартыг хэрэглэнэ.

**1.5. Эрх шилжүүлэх**

Гүйцэтгэгч нь Гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг, хариуцлагыг Захиалагчийн зөвшөөрөлгүйгээр бүхэлд нь буюу хэсэгчлэн бусдад шилжүүлэхгүй.

Захиалагч нь Засгийн газар, эрх бүхий төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр гарснаас бусад тохиолдолд Гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг, хариуцлагыг бусдад шилжүүлэхгүй.

**1.6. Баримт бичгийг хадгалах, хамгаалах**

Гэрээний хавсралт 2 ба 3-т заасан баримт бичгийн эх хувиудыг Талууд (өөрт хамаарах шийдвэр) тус тусдаа, хавсралт 4, 5, 6-д заасан баримт бичгийн эх хувийг Захиалагч хадгалж хамгаалах бөгөөд энэхүү Гэрээнд Талуудын "хуулбар үнэн" дардас бүхий хувийг хавсаргана. Гэрээнд өөрөөр заагаагүй бол ажлын болон техникийн зураг төсөл, техникийн шаардлагын хуулбарыг Гүйцэтгэгчид 2 хувь өгөх ба хэрэв цаашид нэмэлт хувь шаардлагатай бол Гүйцэтгэгчийн зардлаар хувилж өгнө.

Гүйцэтгэгч өөрийн баримт бичгүүдийг Захиалагчид хүлээлгэн өгөх хүртэлх хугацаанд хадгалж хамгаална. Гэрээнд өөрөөр заагаагүй бол Гүйцэтгэгч нь Гүйцэтгэгчийн баримт бичиг тус бүрийн гурван хувийг (2 эх хувь цаасаар 1 электрон хувь) Захиалагчид хүлээлгэн өгнө.

Гүйцэтгэгч нь ажлын талбай дээр үндсэн гэрээ, техникийн шаардлага, ажлын зургууд болон өөрчлөлттэй холбоотой баримт бичиг, Гэрээний бусад баримт бичгүүдийг ашиглаж, зохих журмын дагуу хадгалж хамгаална. Захиалагчийн ажилтан нь шаардлагатай тохиолдолд ажлын талбай дээр эдгээр баримт бичгүүдтэй танилцах, ашиглах эрхтэй.

Хэрэв Гэрээний нэг Тал ажлыг гүйцэтгэхтэй холбоотой баримт бичгүүдэд алдаа, зөрчил, доголдол гаргах тохиолдолд даруй нөгөө Талд мэдэгдэж залруулна.

Гүйцэтгэгч нь шилжүүлэн авсан баримт бичгийг оролцуулан Гэрээгээр хүлээсэн үүрэгтэй холбоотойгоор олж авсан, өөрөө бий болгосон, эсхүл өөрийн нэрийн өмнөөс хийлгэсэн бичгээр үйлдсэн бүх баримт бичиг, зураг, график, материал, гэрэл зураг болон бусад бүх мэдээлэлд нэвтрэх, ашиглах, хуулбарлах боломжийг Захиалагчид олгоно.

**1.7. Ажлын зураг болон зааварчилгааг хугацаа алдаж танилцуулах**

Ажлын зураг болон зааварчилгааг заасан хугацаанд эсхүл боломжит хугацаанд танилцуулаагүй, үүнээс болж ажил хойшлогдох түр зогсоход хүрвэл Гүйцэтгэгч энэ тухай Инженерт мэдэгдэл хүргүүлнэ.



Энэхүү мэдэгдлийг эцээн авсаны дараа Инженер эдгээр асуудлаар Гүйцэтгэгчтэй зөвшилцөж шийдвэрлэх зорилгоор Гэрээний 3.5 (Шийдвэр)-д заасны дагуу холбогдох арга хэмжээг авна.

Инженерийн хугацаа хоцроосон буруутай үйлдэл нь Гүйцэтгэгчийн танилцуулсан баримт бичиг алдаатай, хугацаа хоцроож танилцуулагдсан зэрэг Гүйцэтгэгчийн буруугаас шалтгаалсан бол Гүйцэтгэгч гэрээний хугацааг сунгах, холбогдон гарах зардал, хохирлыг Захиалагчаас шаардах эрхгүй. Мөн Захиалагчаас үл хамаарах шалтгаан (гуравдагч этгээд)-аар ажлын зураг, зааварчилгаа хугацаа хоцорч танилцуулагдсан бол 1.7 дахь заалт хамаарахгүй.

#### 1.8. Гүйцэтгэгчийн баримт бичгийг Захиалагч ашиглах

Талууд харилцан тохиролцсоноор, Гүйцэтгэгч нь өөрийн боловсруулсан оюуны өмч болох баримт бичгүүд, мөн Гүйцэтгэгчийн гаргасан техникийн зураг, бусад баримт бичгүүдийг өөртөө хадгална.

Гүйцэтгэгч нь (гарын үсэг зурсан гэрээгээр) тодорхой хугацаанд зохиогчийн зөвшөөрлөөр аливаа өөрчлөлт оруулж шинэчилсэн Гүйцэтгэгчийн баримт бичгийг хувилах болон ашиглахыг Захиалагчид зөвшөөрнө. Үүнд:

- (a) Ажлын тодорхой хэсгийг гүйцэтгэхээр төлөвлөсөн хугацаанд ашиглах;
- (b) Ажлын тодорхой хэсгийг гүйцэтгэх, дуусгах, үйлчилгээ явуулах, тохируулга хийх, засварлах, нураах, эвдэх зорилгоор хэн нэгэнд хувилах, ашиглах, дамжуулах эрх олгох;

Гүйцэтгэгчийн баримт бичиг нь компьютерын програм хэлбэрээр бол ажлын талбай дээр компьютер ашиглан хэрэглэхийг зөвшөөрнө.

Гүйцэтгэгчийн боловсруулсан баримт бичиг, бусад шаардлагатай зургуудыг Гүйцэтгэгчийн зөвшөөрөлгүйгээр ашиглахгүй бөгөөд Захиалагч нь бусад зорилгоор гуравдагч талд ашиглуулахгүй, аливаа хэлбэрээр дамжуулахгүй, зөвхөн энэ заалтыг мөрдөнө.

#### 1.9. Захиалагчийн баримт бичгийг Гүйцэтгэгч ашиглах

Талууд харилцан тохиролцсоноор, Захиалагч нь өөрийн боловсруулсан техникийн шаардлага, ажлын болон техникийн зураг, бусад оюуны өмч болох баримт бичгүүдийг өөртөө хадгална.

Гүйцэтгэгч нь өөрийн зардлаар гэрээг хэрэгжүүлэх зорилгоор эдгээр баримт бичгүүдийг хуулбарлах, ашиглах буюу олж авч болно.

Гүйцэтгэгч нь Захиалагчийн зөвшөөрөлгүйгээр эдгээр баримт бичгүүдийг хувилах, ашиглах болон гэрээнээс өөр зорилгоор гуравдагч талд дамжуулахгүй.

#### 1.10. Нууцлал

- 1.10.1. Талууд, тэдгээрийн ажилтан Гэрээний хэрэгжилттэй холбоотой аливаа баримт бичиг, мэдээллийг харилцан дамжуулах, солилцох, хадгалах, хамгаалахдаа Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомж, эдгээрт нийцүүлэн гаргасан бусад дүрэм, журмыг чанд мөрдөх үүрэгтэй.

Гэрээний хэрэгжилттэй холбоотой аливаа асуудлаар Талууд гуравдагч этгээдтэй гэрээ, хэлэлцээр байгуулахдаа тухайн гэрээний оролцогч талуудад энэхүү хууль тогтоомж, дүрэм, журмыг чанд мөрдөж ажиллах үүргийг гэрээний нөхцөл болгон заавал тусгана.

- 1.10.2. Талууд энэхүү Гэрээний нөхцөл, барилгын ажлыг гүйцэтгэхтэй холбоотойгоор нөгөө Талын шууд ба шууд бусаар олж авсан (үүнд гэрээ байгуулахаас өмнө

**ИЛ БОЛСОН**

эсхүл хойно гэрээ цуцлагдсаны дараа) аливаа мэдээллийг нөгөө Талын (шаардлагатай тохиолдолд Тагнуулын ерөнхий газрын) бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд задруулахыг хориглоно.

1.10.3. Төслийн баримт материалтай Талуудын зөвхөн нууцын материалтай танилцах эрх бүхий ажилтан, албан тушаалтан танилцана. Талууд нууцын материалтай танилцах эрх бүхий ажилтан, албан тушаалтны жагсаалтыг харилцан бичгээр мэдэгдэнэ. Уг жагсаалтад өөрчлөлт орсон даруй нөгөө Талд энэ тухай бичгээр мэдэгдэнэ.

1.10.4. Барилгын ажилд хамааралтай бусад Гүйцэтгэгч нарт тухайн ажлыг нь уг барилгын ажлыг гүйцэтгэхэд шаардагдах хүрээ, хязгаар дотор мэдээллийг өгч болно. Мэдээлэл задруулж буй Тал нь нууц хадгалах гэрээ, эсхүл нууцын баталгааг тухайн этгээдтэй заавал байгуулна.

Гүйцэтгэгч задруулах гэж буй мэдээллийн тухай мэдэгдлийг нөгөө Талд, шаардлагатай бол Тагнуулын ерөнхий газарт урьдчилан хүргүүлж, задруулах мэдээллийн хэмжээг аль болох бага байлгах, нууцлалыг хамгаалах талаар бүх талын арга хэмжээ авна.

Мэдээлэл задруулагч Талын хүлээх үүрэгт дараах баримт бичиг хамаарахгүй:

- (a) Талуудын буруугүйгээр нийтэд ил тод болсон мэдээлэл, баримт бичиг;
- (b) гуравдагч талаас ямар ч нууцлах үүрэг хүлээлгэхгүйгээр тухайн Талд хууль ёсны дагуу өгсөн мэдээлэл, баримт бичиг.

Энэхүү Гэрээний дагуу Гүйцэтгэгчийн оролцох оролцоо ямар нэгэн байдлаар цуцлагдах, дуусгавар болсон ч цаг хугацааны хязгааргүйгээр мэдээллийг хадгалах үүрэг хүчинтэй хэвээр хадгалагдан үлдэнэ.

### 1.11. Хуулийг дагаж мөрдөх

Гүйцэтгэгч нь гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Барилгын тухай хууль, Төмөр замын тээврийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, норм, дүрэм, журмыг дагаж мөрдөнө.

Гэрээний тусгай нөхцөлд өөрөөр заагаагүй бол:

Захиалагч нь төлөвлөлт болон барилгын зөвшөөрөл, байнгын ажил гүйцэтгэхтэй холбогдуулан техникийн шаардлагад заасан бусад зөвшөөрлийг гаргаж өгөх бөгөөд Захиалагч нь хуулийг дагаж мөрдөхтэй холбоотой аливаа алдаа, дутагдал гаргахаас Гүйцэтгэгчийг хамгаална.

Гүйцэтгэгч нь холбогдох бүх мэдэгдэл, татвар, хураамжийн төлбөрийг гаргаж өгөх ба ажлыг гүйцэтгэж, дуусгах болон ажлын доголдлыг засахтай холбогдуулан хуулийн дагуу бүх зөвшөөрөл, эрхийг олж авсан байна.

### 1.12. Хамтарсан болон хэсэгчилсэн үүрэг хариуцлага

Гүйцэтгэгч нь Гэрээний хавсралт 7-д заасан Ажлын техникийн даалгаварт заасан ажлыг түншлэл хэлбэрээр бусадтай хамтран гүйцэтгэхгүй.

## 2. Захиалагч

### 2.1. Ажлын талбайд нэвтрэх эрх

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын шугамын доод бүтцийн барилгын ажил эхлүүлэх зөвшөөрлийг олгосон эрх бүхий төрийн байгууллагын шийдвэрийг үндэслэн Захиалагч Гэрээний нөхцөлд заасан хугацаанд ажлын талбайд нэвтрэх болон түр ашиглах эрхийг Гүйцэтгэгчид бичгээр өгнө.

Захиалагч өөрийн буруугаас эдгээр эрхийг Гүйцэтгэгчид хугацаанд нь өгөөгүйгээс Гүйцэтгэгчид нэмэлт зардал гарсан, ажил гүйцэтгэх хугацаа



**ИЛ БОЛСОН**

хойшлогдохоор болсон бол Гүйцэтгэгч Гэрээний 20.1 (Гүйцэтгэгчийн нэхэмжлэх)-д заасны дагуу Инженерт мэдэгдэл өгнө. Үүнд:

- (a) Дээрх шалтгааны улмаас ажил хугацаандаа дуусах боломжгүй болж хугацааг сунгахад хүрсэн бол Гэрээний 8.4 (Ажил дуусах хугацааг сунгах)-т заасны дагуу Гэрээний хугацааг сунгах талаар;
- (b) холбогдон гарсан үндэслэл бүхий зардлыг санхүүгийн анхан шатны баримтад үндэслэн Гэрээний үнэд нэмж тооцуулах талаар.

Энэхүү мэдэгдлийг хүлээн авсаны дараа Инженер нь эдгээр асуудлыг шийдвэрлэх болон зөвшилцөх үүднээс Гэрээний 3.5 (Шийдвэр)-д заасны дагуу арга хэмжээ авна.

Захиалагч эрхийг заасан хугацаанд олгоогүй нь Гүйцэтгэгчийн танилцуулсан баримт бичиг алдаатай, хугацаа хоцроож танилцуулагдсан зэрэг Гүйцэтгэгчийн буруугаас шалтгаалсан бол Гүйцэтгэгч гэрээт хугацааг сунгах, зардал, хохирлыг нэхэмжлэх эрхгүй.

## 2.2. Холбогдох зөвшөөрлүүд

Захиалагч өөрийн болон Гүйцэтгэгчийн нэр дээр дараах тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгуулах асуудлыг Зам, тээврийн хөгжлийн ямаар дамжуулан Засгийн газарт тавьж шийдвэрлүүлнэ. Үүнд:

- (a) суурь бүтэц барих тусгай зөвшөөрөл;
- (b) төмөр зам барилгын ажлын зөвшөөрөл /барилгын ажил эхлэх, үргэлжлүүлэх/;
- (c) барилгын ажлын явцад урьдчилан төлөвлөх боломжгүй нөхцөл байдлын улмаас шаардлагатай болсон хуульд заасан бусад тусгай зөвшөөрөл;
- (d) барилгын ажлын зөвшөөрлийг барилгын ажил гүйцэтгэх талбайн болон үйлдвэрлэлийн зохион байгуулалтын зураг төсөлд заасан графикт хугацаагаар олгоно.

Захиалагч нь дараах зөвшөөрлийг өөрийн нэр дээр авна.

- (a) ус ашиглах зөвшөөрөл;
- (b) түгээмэл тархацтай ашигт малтмалын зөвшөөрөл;
- (c) газрын зөвшөөрөл.

Гүйцэтгэгч нь дараах зөвшөөрлийг өөрийн нэр дээр авна.

- (a) ажиллагсдын түр хотхоны газрын зөвшөөрөл;
- (b) нэвтрэх зам барих зөвшөөрөл;
- (c) баригдах барилгын техникийн нөхцөл (дулаан, уур, хий, цэвэр, бохир ус, цахилгаан, харилцаа холбоо, дохиолол зэрэг эх үүсвэрт холбох зөвшөөрөл) авах;
- (d) барилга барих үеийн инженерийн шугам, сүлжээнд түр хангах зөвшөөрлийг авч инженерийн шугам, сүлжээний холбох, салгах зөвшөөрөл;
- (e) ажлын талбайд ажиллах хүчинд үйлчлэх захиргаа, аж ахуй болон үйлдвэрлэл, ахуйн үйлчилгээ, түр сууцны барилга барих;
- (f) барилгын ажлыг гүйцэтгэх, дуусах болон Гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхэд нь зайлшгүй шаардлагатай бусад зөвшөөрөл;

## (г) Шаардлагатай бол аюулгүй байдлын гэрчилгээ авах;

Барилгын ажлыг гүйцэтгэх явцад шаардагдах ус, бохир ус, хий, цахилгаан болон холбоо зэрэг хангамж, ашиглалтын асуудлыг Гүйцэтгэгч өөрөө зохион байгуулах ба Захиалагч үүрэг, хариуцлага хүлээхгүй.

Гүйцэтгэгч нь зохих зөвшөөрөл тус бүрийг тогтоосон хугацаанд эсхүл түүнээс өмнө авах, мөн барилгын ажлын явцад аливаа саатал гаргахаас урьдчилан сэргийлэх боломжит хугацаанд багтаан авна.

Гүйцэтгэгч нь үүгээр хязгаарлагдахгүй ажил гүйцэтгэхэд шаардлагатай бусад бүх зөвшөөрлийг авна.

Барилгын ажил гүйцэтгэх үед харилцаа холбоо, цахилгааны шугам, цэвэр бохир усны хоолой, бусад барилга байгууламжийн үйл ажиллагааг түр зогсоох зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагын зөвшөөрлийг авсан байна.

### 2.3. Захиалагчийн ажилтан

Захиалагч нь ажлын талбай дээр ажиллах Захиалагчийн ажилтан болон Захиалагчийн гэрээт бусад гүйцэтгэгчид ажиллах баталгаа гаргаж өгнө. Үүнд

- (a) Гэрээний 4.6 (Хамтран ажиллах)-д заасны дагуу Гүйцэтгэгчтэй хамтран ажиллах;
- (b) Дээрхтэй адил Гүйцэтгэгчид шаардлагатай Гэрээний 4.8 (a), (b), (c), Гэрээний 4.17 (Байгаль орчныг хамгаалах)-д заасны дагуу холбогдох арга хэмжээ авах.

### 2.4. Захиалагчийн санхүүжилт

Захиалагч нь Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 135 дугаар тогтоолд заасан эх үүсвэрээс төвлөрүүлсэн хөрөнгөөс ажлын гүйцэтгэлийн хөлсийг цаг тухайд нь төлөх үүрэгтэй.

Захиалагч нь эхний ээлжинд хөрөнгийн эх үүсвэртэй холбоотой өөрөөс хамаарах дор дурдсан арга хэмжээг авч, энэхүү хөрөнгийн хэмжээнд ажлыг санхүүжүүлж гүйцэтгүүлнэ:

- (a) Захиалагч Засгийн газрын 2019 оны 135 дугаар тогтоолд заасны дагуу 750,0 тэрбум төгрөгийн үнэт цаас гаргана. Гаргасан үнэт цаасыг "Эрдэнэс-Тавантолгой" ХК-д худалдах, худалдан авах гэрээ байгуулна.
- (b) Захиалагч нь Тавантолгой-Зүүнбаян төслийн зориулалтаар татан төвлөрүүлсэн хөрөнгийг зөвхөн Тавантолгой-Зүүнбаян төслийн дансанд байршуулж, зориулалтын дагуу захиран зарцуулна.

Захиалагч нь барилгын ажил эхлэхээс өмнө Ерөнхий сайдын 2019 оны 53 дугаар захирамжаар байгуулсан Ажлын хэсгээс өгсөн удирдамж, чиглэлийг үндэслэн Гүйцэтгэгчийн хүсэлтийн дагуу Гүйцэтгэгчид энэ Гэрээнд заасны дагуу урьдчилгаа төлбөр олгож болно.

Гэрээний хавсралт 9-д заасан Ажлын гүйцэтгэлийг санхүүжүүлэх нөхцөл, санхүүжилтийн хуваарийн дагуу явцын төлбөр, эцсийн төлбөрийг санхүүжүүлнэ.

Захиалагч нь Гүйцэтгэгчийн хүсэлт бүхий санхүүжилтэд өөрчлөлт хийх тохиолдолд энэ талаар урьдчилан мэдэгдэл хүргүүлнэ.

Захиалагч нь Засгийн газрын 2019 оны 153 тогтоолын дагуу Төслийн зориулалтаар бэлэн төвлөрсөн хөрөнгийн хэмжээгээр ажлыг гүйцэтгүүлж, дараагийн хөрөнгө дансанд бэлэн орж иртэл ажлыг түр зогсоох арга хэмжээ авна.

**ИЛ БОЛСОН**

Захиалагчийн төлбөр төлөх үүрэг уг Төслийн зориулалтаар татан төвлөрүүлсэн Тавантолгой-Зүүнбаян төслийн данс дахь хөрөнгөөр хязгаарлагдана.

**2.5. Захиалагчийн нэхэмжлэх**

Хэрэв Захиалагч нь Гэрээний нөхцөлийн дагуу төлбөр нэхэмжлэх эрхтэй бол энэ тухай Гүйцэтгэгчид мэдэгдэл өгнө.

Энэхүү төлбөр авах нэхэмжлэх нь Гэрээний 4.18 (*Цахилгаан, ус, хийн ашиглалт*), 4.19 (*Захиалагчийн техник хэрэгсэл болон хөнгөлөлттэй үнээр ашиглах материал*)-д заасан төлөгдөх, эсхүл Гүйцэтгэгчээс хүссэн бусад үйлчилгээний дагуу төлөгдөх төлбөрт байж болохгүй.

Төлбөр авах нэхэмжлэхийг тухайн нөхцөл байдлыг Захиалагч мэдсэнээс хойш 28 хоногийн дотор Гүйцэтгэгчид мэдэгдэнэ. Ажлын эвдрэл, гэмтэл, доголдлыг засах хугацааг сунгахтай холбоотой мэдэгдэл бол баталгаат засварын хүчинтэй хугацааг дуусахаас өмнө өгсөн байна.

Гэрээтэй холбогдуулан Захиалагч нэхэмжлэх эрхтэй гэж үзэж байгаа бол мэдэгдэлдээ холбогдох заалт, нэхэмжлэх үндэслэл, нэхэмжилж буй дүнг тодорхой тусгаж оруулна. Үүний дараа Захиалагч нь Гэрээний 3.5 (*Шийдвэр*)-д заасныг үндэслэн (i) Гүйцэтгэгчээс нэхэмжилж буй төлбөрийн хэмжээ, (ii) Гэрээний 11.3 (*Баталгаат засварын хугацааг сунгах*)-т заасны дагуу хугацаа сунгах эсэх зэрэг асуудлыг шийдвэрлэнэ.

Энэхүү нэхэмжилж буй дүнг Гэрээний үнэ болон Төлбөрийн хүсэлтэд тусгасан үнэд суутгал хийж болно. Захиалагч нь зөвхөн Төлбөрийн хүсэлтэд заасан дүнгээс суутгал хийх байдлаар нөхөн төлбөр авах, эсхүл энэ заалтын дагуу Гүйцэтгэгчийн бусад нэхэмжлэхээс суутгах эрхтэй.

Захиалагч нь барилгын ажлын болон техникийн зургийг хэсэгчлэн боловсруулж, магадлагдсан хэсэгчилсэн ажлын болон техникийн зургийг Гүйцэтгэгч Гэрээний 1.9-д заасны дагуу ашиглана. Энэхүү хэсэгчилсэн ажлын болон техникийн зургууд нь хамтдаа Гэрээний Хавсралт 4-ийн бүрдэл болно. Захиалагч ийнхүү ажлын болон техникийн зургийг хэсэгчлэн гаргахдаа Гүйцэтгэгчийн барилгын ажил тасралтгүй, хэвийн үргэлжлэхэд саад болохгүй байх нөхцөлийг хангана.

**3. Инженер****3.1. Инженерийн эрх, үүрэг**

Захиалагч нь гэрээг хэрэгжүүлэхэд өөрийг нь төлөөлөх Инженерийг томилно.

Инженерийн ажилтан гэдэгт эдгээр ажлуудыг гүйцэтгэх эрх мэдэл бүхий ур чадвар, туршлагатай Инженерүүд болон бусад мэргэжлийн ажилтнуудыг авч үзнэ.

Инженер нь Гэрээнд өөрчлөлт оруулах, аль нэг Талын Гэрээний дагуу хүлээсэн үүрэг, хариуцлага, эрх мэдлийг өөрчлөх эрхгүй.

Инженер нь энэ Гэрээнд Захиалагчид урьдчилан мэдэгдэж зөвшөөрөл авна гэж заасан, эсхүл Захиалагч гэж нэрлэн зааснаас бусад, инженерийн мэдлэг, ур чадвар шаардагдсан бүх асуудлаар Захиалагчийг ажлын талбайд төлөөлж, Захиалагчийн эрх ашгийг хамгаалж, удирдан зохион байгуулна.

Гэрээнд заагаагүй асуудлаар шаардах эрх эдлэхээр бол Захиалагчаас урьдчилан зөвшөөрөл авна. Захиалагч нь Инженерийн эрх, үүрэгт өөрчлөлт оруулбал энэ тухай Гүйцэтгэгчид даруй мэдэгдэнэ.

Шалгах, нягтлах, гэрчлэх, хянах, зааварчлах, мэдэгдэх, санал тавих, хүсэлт гаргах, туршилт явуулах, зөвшөөрөл өгөхтэй холбоотой Инженерийн үүрэг нь



**ИЛ БОЛСОН**

Гэрээнд зааснаар Гүйцэтгэгчийг аливаа үүрэг, хариуцлагаас чөлөөлөхгүй.

Инженер нь Гүйцэтгэгчээс тавьсан хүсэлтийг хүлээн авсанаас хойш 28 хоногийн дотор тодорхой хариуг бичгээр өгөх үүрэгтэй.

Түүнчлэн, дараах нөхцөлүүдийг дагаж мөрдөнө. Үүнд:

Инженер нь дор дурдсан арга хэмжээ авахаас өмнө Захиалагчаас албан ёсоор зөвшөөрөл авсан байна. Үүнд:

- (a) Гэрээний 4.11-д заасны дагуу: хугацаа сунгах эсхүл нэмэлт зардлыг зөвшөөрөх болон шийдвэрлэхдээ;
- (b) Гэрээний 13.1-т заасны дагуу: дор дурдсанаас бусад тохиолдолд өөрчлөлтийн талаар зааварчлах
  - (i) Инженерийн тодорхойлсон онцгой нөхцөл байдал хэрэв энэ өөрчлөлт нь Гэрээний нөхцөлд заасан хувиас бага хэмжээгээр зөвшөөрөгдсөн Гэрээний дүнг нэмэгдүүлэх;
  - (ii) Гэрээний 13.3-т заасны дагуу: Гэрээний 13.1 болон 13.2-т заасны дагуу Гүйцэтгэгчийн танилцуулсан ажлын өөрчлөлтийн талаарх саналыг зөвшөөрөх.

Гэвч, Инженер нь ажлын болон амьдрах орчны аюулгүй байдалд нөлөөлөх онцгой нөхцөл үүссэн гэж үзсэн бол, Инженер нь гэрээгээр хүлээсэн Гүйцэтгэгчийн үүрэг, хариуцлагыг хөндөхгүйгээр эрсдэлийг багасгах үүднээс тодорхой ажлыг гүйцэтгэх эсхүл тодорхой үйлдэл хийхийг Гүйцэтгэгчид зааварчилж болно.

Энэ тохиолдолд Гүйцэтгэгч нь Захиалагчийн зөвшөөрөөгүйг үл харгалзан Инженерийн зааварчилгааг нэн даруй мөрдөнө. Зааварчилгаатай холбоотой гарах нэмэлт зардлыг Инженер нь Гэрээний 13-т заасны дагуу тодорхойлох ба энэ тухай мэдэгдлийг Гүйцэтгэгчид, хувийг Захиалагчид хүргүүлсэн байна.

### 3.2. Инженерийн төлөөлөгч

Инженер нь тодорхой хугацаанд үүргээ биелүүлэхэд туслалцаа авах зорилгоор мэдлэг, туршлагатай хүнийг туслуулахаар төлөөлөгчөөр томилох эрхтэй.

Төлөөлөгчөөр техник, хэрэгсэл болон материалын төрлийн туршилт явуулах, шалгуулахаар томилох суурин Инженер, эсхүл бие даасан хянан шалгагч орно.

Төлөөлөгчийг томилох эсхүл түүнээс татгалзах асуудлыг бичгээр үйлдэх бөгөөд хоёр Тал үүнтэй холбоотой мэдэгдлийг хүлээн авах хүртэл хүчин төгөлдөр бус байна. Гэхдээ, хоёр Тал зөвшөөрөөгүй бол, Инженер нь Гэрээний 3.5 (Шийдвэр)-д заасны дагуу ямар нэгэн асуудлыг шийдвэрлэх эрхтэй төлөөлөгчийг томилохгүй.

Туслалцаа үзүүлэх хүн нь ур чадвар, туршлагатай төдийгүй Гэрээний дагуу үүргээ биелүүлэх эрх мэдэлтэй байна.

Инженерийн төлөөлөгч нь өөрийн эрх мэдлийн хүрээнд Гүйцэтгэгчид зөвлөмж, зааварчилгаа гаргана.

Ямар нэг зөвшөөрөл өгөх, шалгах, гэрчлэх, нягтлах, хянах, зааварчлах, мэдэгдэл өгөх, санал өгөх, хүсэлт тавих, туршилт хийх түүнтэй ижил төстэй ажлыг гүйцэтгэхэд Инженерийн төлөөлөгчийн тавих шаардлага нь Инженерийн шаардлагатай адил байна.

Гэхдээ, ямар нэгэн ажил, техник хэрэгсэл, материалын асуудлаар зөвшөөрөл өгөөгүйгээс гарах алдаа нь зөвшөөрөл авах үндэслэл болохгүй тул Инженер нь ажил, техник хэрэгсэл, материалаас татгалзах Инженерийн төлөөлөгчийн

**ИЛ БОЛСОН**

эрхийг хасахгүй.

Хэрэв Гүйцэтгэгч нь ямар нэгэн шийдвэр, заавар, зөвлөмж хүссэн бол Гүйцэтгэгч нь энэ асуудлаар шуурхай шийдэх боломжтой Захиалагчийн ажилтан, төлөөлөгчид хандана.

### 3.3. Инженерийн заавар, зөвлөмж

Инженер нь Гэрээний дагуу ажил гүйцэтгэхэд (доголдлыг засах) шаардлагатай ажлын зураг, аливаа нэмэлт болон зөвлөмж, зааварчилгааг Гүйцэтгэгчид гаргаж өгнө.

Гүйцэтгэгч нь зөвхөн Инженер, эсхүл Захиалагчаас томилсон эрх бүхий төлөөлөгчөөс зааварчилгаа авсан байна. Хэрэв Инженерийн зөвлөмж, зааварчилгаа нь Гэрээний 13 (Өөрчлөлт болон тохируулга)-т заасны дагуу ажилд өөрчлөлт оруулах үндэслэл болбол:

Гүйцэтгэгч нь гэрээтэй холбоотой асуудлаар Инженер, эсхүл Инженерийн төлөөлөгчөөс өгсөн зааварчилгааг дагаж мөрдөнө.

Ямар ч тохиолдолд Захиалагчийн заавар, зөвлөмж нь бичгээр өгөгдсөн байна. Хэрэв Инженер, эсхүл Инженерийн төлөөлөгч нь:

- a. амаар зааварчилгаа өгсөн зааварчилгаа өгсөн бол ийнхүү өгснөөс хойш ажлын 2 хоногийн дотор Гүйцэтгэгчээс зааварчилгааг хүлээн авсаныг бичгээр баталгаажуулан авна;
- b. ийнхүү баталгаажуулсан бичгийг хүлээн авсанаас хойш ажлын 2 өдрийн дотор зааварчилгааг авсан эсхүл татгалзсан тухайгаа бичгээр хариу өгөхгүй бол

Баталгаажсан албан бичиг нь Инженер, эсхүл Инженерийн төлөөлөгчөөс өгсөн бичгийн зааварчилгааны үндэслэл болно.

### 3.4. Инженерийг солих

Хэрэв Захиалагч нь Инженерийг солих тохиолдолд ийнхүү солихоос 21-ээс доошгүй хоногийн өмнө шинээр томилогдох Инженерийн нэр, хаяг, ажлын туршлага, Захиалагчаас олгосон эрхийн талаарх албан мэдэгдлийг Гүйцэтгэгчид өгнө.

### 3.5. Шийдвэр

Инженер нь Гэрээний 3.1-д заасан асуудлыг зөвшөөрөх, шийдвэрлэх эрхтэй бөгөөд Инженер нь Гэрээний аль ч Талыг зөвшилцөлд хүрэх талаар зөвлөнө. Хэрэв зөвшилцөл үр дүнд хүрэхгүй бол Инженер Гэрээний дагуу холбогдох нөхцөл байдлын хүрээнд шударга шийдвэр гаргана.

Инженер нь нэхэмжлэх, хүсэлт хүлээн авсанаас хойш 28 хоногийн дотор зөвшилцөл, шийдвэрийн талаар хоёр Талд мэдэгдэл өгнө. Аль ч Тал Гэрээний 20 (Нэхэмжлэл, маргаан болон шүүхийн ажиллагаа)-д заасны дагуу асуудлыг шийдэх, зөвшилцөхөд нөлөөлнө.

## 4. Гүйцэтгэгч

### 4.1. Гүйцэтгэгчийн ерөнхий үүрэг

- 4.1.1. Гүйцэтгэгч нь Гэрээнд заасан тоо, хэмжээний ажлыг зохих ёсоор гүйцэтгэж хүлээлгэн өгөх ба ажлын доголдол, эвдрэл, гэмтлийг өөрийн зардлаар засварлана.

Гүйцэтгэгч нь Гэрээнд заасан түр болон байнгын ажилд шаардлагатай техник хэрэгсэл, Гүйцэтгэгчийн баримт бичиг, бүх ажилтан, бараа, ашиглаж болох бусад зүйлсийг хариуцна.

- Барилгын ажлын талбайд ашиглагдах техник хэрэгсэл, барилгын материал,
- 4.1.2. түүхий эд нь холбогдох хууль тогтоомж, норм, дүрэм, журам, стандартад нийцсэн, тохирлын гэрчилгээтэй байна.
- 4.1.3. Гүйцэтгэгч нь барилгын ажлын төлөвлөгөө, аргачлал, талбайн бүх зохион байгуулалт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, даатгалын асуудлыг хариуцна.
- 4.1.4. Гүйцэтгэгч нь ямар ч үед Инженерийн шаардсаны дагуу ажил гүйцэтгэхэд шаардлагатай Гүйцэтгэгчийн санал болгосон арга хэмжээ, аргачлалын талаар нарийвчилсан мэдээллийг танилцуулна. Эдгээр арга хэмжээ, аргачлалыг Инженерт урьдчилан мэдэгдэлгүйгээр өөрчилж болохгүй.

Хэрэв Гэрээнд Гүйцэтгэгч нь байнгын ажлын аль нэг хэсгийн зургийг гаргахаар заасан бол Гэрээний тусгай нөхцөлд өөрөөр заагаагүй бол:

- a) Гүйцэтгэгч Гэрээнд заасан журмын дагуу ажлын энэ хэсэгт зориулсан Гүйцэтгэгчийн баримт бичгийг Инженерт танилцуулсан байх;
- b) Гүйцэтгэгчийн эдгээр баримт бичгүүд нь техникийн шаардлага болон зургийн дагуу байна. Мөн баримт бичгүүдэд Инженерийн шаардсан нэмэлт мэдээллийн дагуу холбогдох нэмэлтийг Талуудын хамтран гаргасан зургуудад оруулсан байна.
- c) Гүйцэтгэгч нь ажлын энэ хэсгийг хариуцаж ажлыг дуусгана.
- 4.1.5. Гүйцэтгэгч нь хэсэг ажил бүрийн өмнө Гэрээнд заасан хугацааны дотор тухайн хэсэг ажлын календарчилсан төлөвлөгөөг энэ зүйлийн 4.7-д заасан зарчмаар боловсруулж батлуулна. Энэхүү төлөвлөгөө нь Гэрээний 7 дугаар хавсралтын салшгүй хэсэг байна.
- 4.1.6. Ажил дуусгахтай холбогдуулан туршилт явуулж эхлэхээс өмнө Гүйцэтгэгч нь ажлын гүйцэтгэлтэй холбоотой баримт бичгүүдийг Инженерт танилцуулах ба хэрэв шаардлагатай бол техникийн шаардлагын дагуу ажлын тухайн хэсэгт шаардлагатай ашиглах, засварлах, задлах, угсрах, тохируулах, засахад зориулсан ашиглалтын болон засвар үйлчилгээний гарын авлагуудыг Захиалагчид зориулан танилцуулна. Эдгээр баримт бичгүүд, гарын авлагуудыг Инженерт танилцуулах хүртэл ажлын тухайн хэсгийг Гэрээний 10.1 (Ажил болон ажлын тодорхой хэсгийг хүлээн авах)-т заасны дагуу хүлээн авсанд тооцохгүй.

#### 4.2. Гүйцэтгэлийн баталгаа

Гүйцэтгэгчээс гүйцэтгэлийн баталгаа шаардахгүй.

#### 4.3. Гүйцэтгэгчийн төлөөлөгч

Гүйцэтгэгч нь Гүйцэтгэгчийн төлөөлөгчийг томилох бөгөөд Гэрээний дагуу Гүйцэтгэгчийг төлөөлөх бүх эрх мэдлийг түүнд өгнө.

Гэрээнд Гүйцэтгэгчийн төлөөлөгчийг нэрлээгүй бол, Гүйцэтгэгч нь ажил эхлэхээс өмнө Гүйцэтгэгчийн төлөөлөгчөөр томилогдсон хүний нэр, тодорхойлолтыг Захиалагчид танилцуулсан байна. Хэрэв Гэрээний 6.9 (Гүйцэтгэгчийн ажилтан)-д зааснаар Гүйцэтгэгчийн томилсон төлөөлөгчийг солихыг шаардах, эсхүл төлөөлөгч ажлын алдаа гаргасан бол Гүйцэтгэгч түүнийг орлохуйц ур чадвартай хүнийг шинээр томилон нэр, тодорхойлолтыг Захиалагчид танилцуулна.

Гүйцэтгэгч нь Инженерийн зөвшөөрөлгүйгээр Гүйцэтгэгчийн төлөөлөгчийг томилохгүй, солихгүй.

Гэрээнд зааснаар Гүйцэтгэгчийн ажлын гүйцэтгэлд чиглэл өгөх ажлыг төлөөлөгч бүтэн цагаар хариуцна. Хэрэв Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь ажил

**ИЛ БОЛСОН**

Гүйцэтгэх хугацаанд ажлын талбайгаас түр хугацаагаар явах бол орондоо ажиллах мэргэжлийн хүнийг томилох бөгөөд Инженерт урьдчилан мэдэгдэж зөвшөөрөл авсан байна.

Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь Гүйцэтгэгчийн нэрийн өмнөөс Гэрээний 3.3 (Инженерийн заавар, зөвлөмж)-т заасны дагуу зааварчилгааг хүлээн авч, хэрэгжилтийг хариуцан ажиллана.

**4.4. Туслан Гүйцэтгэгч**

Гүйцэтгэгч нь өөрийн хүчээр гүйцэтгэх боломжгүй ажлын тодорхой хэсгийг Захиалагчтай зөвшилцсөний үндсэн дээр мэргэжлийн туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж болно. Энэ тохиолдолд ажил Гүйцэтгэгч нь Захиалагчийн хувьд ерөнхий Гүйцэтгэгч, туслан Гүйцэтгэгчийн хувьд Захиалагч болно.

Гүйцэтгэгч ажлыг бүхэлд нь туслан Гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхгүй.

Захиалагчийн бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр ажлын тодорхой хэсгийг туслан гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулахыг хориглоно.

Гүйцэтгэгч нь туслан гүйцэтгэгчийн ажлын үр дүн, эрсдэлийг Захиалагчийн өмнө бүрэн хариуцна. Захиалагч туслан гүйцэтгэгчийн өмнө гэрээний болон гэрээний бус аливаа үүрэг хүлээхгүй.

Гүйцэтгэгч нь туслан гүйцэтгэгч авах шаардлагатай хэсэг ажлын жагсаалтыг Захиалагчид урьдчилан танилцуулж, хэсэг ажил тус бүрээр туслан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах шалгуур үзүүлэлтэд Захиалагчийн саналыг авсан байна.

Гүйцэтгэгч туслан гүйцэтгэгчийг сонгохын өмнө дараах агуулга бүхий мэдэгдлийг 14 хоногийн өмнө Захиалагчид ирүүлнэ. Үүнд:

- a) туслан гүйцэтгэгч, түүний талаарх дэлгэрэнгүй танилцуулга (уг танилцуулгад түүний ажлын туршлага, ажиллах хүч, техник хэрэгслийн нөөц, гүйцэтгэсэн ажил, санхүүгийн чадавхийн мэдээллийг заавал тусгах);
- b) туслан гүйцэтгэгчийн ажил эхлүүлэх хугацаа;
- c) туслан гүйцэтгэгчтэй байгуулах гэрээний нөхцөл;
- d) холбогдох бусад мэдээлэл.

Туслан гүйцэтгэгчтэй байгуулах гэрээнд Гэрээний 4.5 (Туслан Гүйцэтгэгчийн үүргийг шилжүүлэх), Гэрээний 15.2 (Захиалагчийн зүгээс гэрээг цуцлах)-т заасны дагуу Захиалагч түүнд шаардлага тавих эрхтэй байх нөхцөлийг заавал оруулна.

Гүйцэтгэгч нь Гэрээний 1.10 (Нууцлал)-т заасан шаардлагыг мөрдөх баталгаа гаргах ба туслан гүйцэтгэгч бүр нэгэн адил энэ шаардлагыг мөрдөн хэрэгжүүлэх үүрэгтэй.

Туслан Гүйцэтгэгч нь хуульд заасан тусгай зөвшөөрөлтэй, тухайн ажлыг гүйцэтгэхэд хүрэлцэхүйц ажиллах хүч, техник хэрэгслийн нөөцтэй, эрсдэл даах санхүүгийн чадавхитай хуулийн этгээд байна. Шаардлагатай тохиолдолд туслан гүйцэтгэгч нь аюулгүй байдлын гэрчилгээтэй этгээд байна.

**4.5. Туслан Гүйцэтгэгчийн үүргийг шилжүүлэх**

Туслан Гүйцэтгэгчийн үүргийг Захиалагчид шилжүүлэхгүй.

**4.6. Хамтран ажиллах**

Гүйцэтгэгч нь Гэрээнд заасны дагуу эсхүл Инженерийн зөвлөж зааварласнаар

дараах нөхцөлийг хүлээн зөвшөөрнө:

- (a) Захиалагчийн ажилтан;
- (b) Захиалагчаас ажиллуулах өөр Гүйцэтгэгч;
- (c) Эрх бүхий байгууллагаас албан ёсоор томилсон ажилтнуудыг.

Өөрөөр хэлбэл, Гэрээнд заагаагүй эдгээр хүмүүсийг тодорхой ажил гүйцэтгэхэд талбайн ойролцоо, эсхүл талбай дээр ажиллуулна.

Хэрэв ийм зөвлөмж, зааврын дүнд Гүйцэтгэгч ажлыг хойшлуулах, төлөвлөгдөөгүй зардал гарахаар бол Гэрээний нөхцөлд өөрчлөлт оруулах үндэслэл болно.

Гэрээнд зааснаар Захиалагч ямар нэгэн барилгын суурь хийц, техник, хэрэгслийн холбогдолтой Гүйцэтгэгчийн баримт бичгийг шаардвал, Гүйцэтгэгч нь техникийн шаардлагад заасан төрлөөр цаг тухайд нь эдгээр баримт бичгүүдийг Инженерт танилцуулна.

#### 4.7. Ажлыг эхлүүлэх арга хэмжээг зохион байгуулах

4.7.1. Талууд магадлагдсан зураг төсөл (хэсэгчилсэн)-д үндэслэн Ерөнхий сайдын 2019 оны 53 дугаар захирамжаар байгуулсан Ажлын хэсгээс өгсөн удирдамж, чиглэлийн дагуу Төслийн барилгын ажлыг хэсэгчлэн, үе шаттай гүйцэтгэнэ.

4.7.2. Талууд барилгын ажлыг эхлүүлэхийн өмнө дор дурдсан бэлтгэл ажлыг хангасан байна. Үүнд:

- (a) барилгын ажлын эхний хэсэг (10 км)-ийн магадлагдсан ажлын болон техникийн зураг, техникийн шаардлага, ажлын техникийн даалгавар, ажлын төсвийг Гүйцэтгэгчид хүлээлгэн өгч, Гүйцэтгэгч хүлээн авсан байх;
- (b) Талууд Гэрээний 2.2-т заасан барилгын ажлыг гүйцэтгэхэд шаардагдах зөвшөөрөл, тусгай зөвшөөрлийг бүрэн авсан байх;
- (c) Гүйцэтгэгч хөрсний материалын иж бүрэн лаборатори, шаардлагатай техник хэрэгслийг ажлын талбайд бэлэн байлгах;

Гүйцэтгэгч Гэрээ байгуулагдсан өдрөөс хойш 7 хоногийн дотор Гэрээний хавсралт 7 (Барилгын ажлын үе шатны календарчилсан төлөвлөгөө), хавсралт 8 (Барилгын ажил гүйцэтгэх талбайн болон үйлдвэрлэлийн зохион байгуулалтын төлөвлөгөө), хавсралт 9 (Байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн болон нийгмийн менежментийн төлөвлөгөө)-д заасан баримт бичгүүдийг боловсруулж, Захиалагчийн саналыг тусгасан байдлаар Захиалагчид ирүүлэх ба Захиалагч батална.

4.7.3. Захиалагч, эсхүл түүний сонгосон мэргэжлийн эрх бүхий этгээд ажлын талбайн тэг тэнхлэг (улаан шугам) тавина. Тэг тэнхлэг тавьсан талаар Инженер Гүйцэтгэгчид мэдэгдэл хүргүүлнэ.

Талууд барилгын ажлыг эхлүүлэхийн өмнө барилгын улаан шугамыг шалгаж, тэг, тэнхлэг тавьсан акт үйлдэнэ. Ажлын талбар дээр байгаа газрын түвшиний түр реперүүдийг Гүйцэтгэгчид хүлээлгэн өгнө.

Гүйцэтгэгч нь тэг, тэнхлэг тавьсан актад заасан цэг, зурвас түвшинд ажлыг эхлүүлэхээр бэлтгэнэ. Гүйцэтгэгч ажлын бүх хэсгийн байршлыг засахыг хариуцах ба байршил, түвшин, хэмжээс, эсхүл ажлын трассын алдааг залруулна.

Захиалагч нь заасан цэг, зурвас, түвшний болон мэдэгдэлд заасан нөхцөлд гарсан алдааг хариуцах боловч Гүйцэтгэгч ажлаа эхлэхээс өмнө нарийвчлан



баталгаажуулах арга хэмжээ авна.

- 4.7.4. Дараа, дараагийн Хэсэг ажлуудыг гүйцэтгэхийн өмнө Захиалагч 4.7.2 (а)-д заасан баримт бичгүүд болон ажлын талбайн тэг тэнхлэгийг Гүйцэтгэгчид хүлээлгэн өгсөн байна.
- 4.7.5. Ажлыг Засгийн газрын 2019 оны 135 дугаар тогтоолд заасан хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжүүлэх бөгөөд барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, түр зогсолт хийх асуудлыг Засгийн газрын тогтоолын хэрэгжилт, санхүүжилттэй уялдуулж зохион байгуулна.

#### 4.8. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэг журам

Гүйцэтгэгч нь:

- (а) Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйтай холбоотой бүх журмыг мөрдөх;
- (б) Ажлын талбай дээр ажиллах бүх хүмүүсийн аюулгүй байдлыг хангах;
- (с) талбай дээр ажиллах хүмүүсийг аюулгүй байлгахын тулд саад, тотгорыг зайлуулж ажлын талбайг цэвэрлэх бүх боломжит арга хэмжээ авах;
- (д) ажлыг дууссаны дараа, эсхүл Гэрээний 10 (Захиалагчийн зүгээс ажлыг хүлээн авах)-т заасны дагуу хүлээн авах хүртэл ажил гүйцэтгэхдээ хамгаалалтын хашаа, гэрэл, хамгаалалтын тэмдэг зэргийг ашиглах;
- (е) гэрээт ажлыг гүйцэтгэхтэй холбогдуулан олон нийтийг хамгаалах зорилгоор шаардлагатай байж болох замын хажуу, хамгаалалтын хашаа барих гэх мэт түр зуурын ажлуудыг гүйцэтгэх.

#### 4.9. Чанарын баталгаа

Гүйцэтгэгчийн чанарын баталгаат хугацаа 3 жил байна.

Тодорхой үе шат, хэсгийн ажлыг гүйцэтгэж эхлэхээс өмнө холбогдох журам, баримт бичгийг мэдээлэл болгож Инженерт танилцуулна. Техникийн шинж чанартай баримт бичгийг Инженерт гаргаж өгөхдөө холбогдох нотолгоог ил тод байлгана.

Чанарын баталгааны журмыг мөрдөх нь Гүйцэтгэгчийг Гэрээнд заасан аливаа үүрэг, хариуцлагаас чөлөөлөхгүй.

#### 4.10. Ажлын талбайтай холбоотой мэдээлэл


Үндсэн хугацаанаас өмнө Захиалагч нь Гүйцэтгэгчид шаардлагатай мэдээлэл, түүнчлэн ажлын талбай дээрх ус зүйн болон бусад мэдээллийг байгаль орчны мэдээлэлтэй хамт гаргаж өгнө. Захиалагч нь үндсэн хугацааны дараа Захиалагчийн ажлын талбайтай холбоотой бүх мэдээллийг Гүйцэтгэгчид гаргаж өгнө.

Гүйцэтгэгчийг ажилд гарах болзошгүй эрсдэл, магадлашгүй зардал, бусад нөхцөл байдалтай холбоотой мэдээллийг олж авсан гэж үзнэ. Гүйцэтгэгчийг ажлын талбайтай танилцаж орчин байдлыг судалсан гэж үзэх бөгөөд дээрх бүх мэдээ, мэдээлэл нь дараах мэдээллийг багтаасан гэж үзнэ. Үүнд:

- (а) Газрын гадаргуун нөхцөлийг багтаасан ажлын талбайн орчин байдал;
- (б) Ус зүйн болон цаг агаарын нөхцөл байдал;
- (с) Ажлыг гүйцэтгэх болон дуусгах, баталгаат засварын хугацаанд шаардлагатай ажил болон материалын хэмжээ;
- (д) Орон байр, хүн хүч, цахилгаан эрчим хүч, усны хангамж, бусад



үйвчилгээтэй холбоотой туйцэтгэгчийн шаардлага.



#### 4.11. Урьдчилан таамаглах боломжгүй нөхцөл, байдал

Урьдчилан таамаглах боломжгүй нөхцөл байдал гэдэг нь Гүйцэтгэгч ажлыг гүйцэтгэх үед талбай дээр тулгарах байгалийн гамшиг, хүний үйлдэл, бусад саад тотгорыг хэлэх бөгөөд үүнд цаг агаарын нөхцөл байдал хамаарахгүй.

Хэрэв Гүйцэтгэгч урьдчилан таамаглах боломжгүй гэж үзэх хор хөнөөлтэй нөхцөл байдалтай тулгарвал тэр даруй Инженерт мэдэгдэл өгнө.

Энэ мэдэгдэлд бодит нөхцөл байдал, Гүйцэтгэгч яагаад урьдчилан таамаглах боломжгүй нөхцөл байдал гэж үзсэн шалтгааныг тодорхой бичнэ. Гүйцэтгэгч нь бодит нөхцөл байдлын шинж чанар, боломжит хэмжигдэхүүнийг ашиглан Инженерийн заавар, зөвлөмжийн дагуу гүйцэтгэх ажлаа үргэлжлүүлнэ. Хэрэв заавар, зөвлөмжийн дагуу өөрчлөлт орохоор бол Гэрээний 13 (*Өөрчлөлт болон тохируулга*)-т заасныг мөрдөнө.

Хэрэв Гүйцэтгэгч урьдчилан таамаглах боломжгүй нөхцөл байдал бодитой үүссэнээс шалтгаалан ажил хойшлогдох, зардал нэмэгдэхээр бол Гүйцэтгэгч нь Гэрээний 20.1 (*Гүйцэтгэгчийн нэхэмжлэх*)-д заасны дагуу мэдэгдэл өгөх эрхтэй.

- (a) Дээрх шалтгааны улмаас ажил хугацаандаа дуусах боломжгүй болж хугацааг сунгахад хүрсэн бол Гэрээний 8.4 (*Ажил дуусах хугацааг сунгах*)-т заасны дагуу гэрээт ажлын хугацааг сунгах;
- (b) Үүнтэй холбоотой зайлшгүй нэмэгдэх зардлыг Талууд харилцан тохиролцож Гэрээний үнэд оруулах.

Энэхүү мэдэгдлийг хүлээн авсаны дараа Инженер нь үүссэн нөхцөл байдлыг шалгаж, нарийвчлан судалж асуудлыг шийдвэрлэх, зөвшилцөх үүднээс Гэрээний 3.5-д заасны дагуу (i) ямар хэмжээний нөхцөл байдал үүссэн, (ii) дээр дурдсан (a) болон (b) дэд заалтад хамаатай эсэхийг тодорхойлж холбогдох арга хэмжээ авна.

Гэхдээ, нэмэгдэх зардлын хэмжээг эцсийн байдлаар тогтоох болон шийдэхээс өмнө Инженер нь ажлын ижил төстэй хэсгүүдэд үүссэн иймэрхүү нөхцөл байдлыг Гүйцэтгэгч ажлыг гүйцэтгэхээс өмнө урьдчилан мэдэх боломжтой байсан эсэхийг хянан үзэж тодорхойлно. Хэрэв нөхцөл байдлыг тааламжтай байдлаар шийдэх боломжтой бол Захиалагч нь Гэрээний 3.5 (*Шийдвэр*)-д заасны дагуу энэ нөхцөлөөс үүдэлтэй зардлыг суутгах асуудлыг тодорхойлж зөвшөөрөх ба энэ зардлыг Гэрээний үнэ болон Төлбөрийн хүсэлтэд суутгал хэлбэрээр багтааж оруулна.

Гэхдээ, эдгээр бодит нөхцөл байдлаас шалтгаалсан дээрх (b)-д заасны дагуу хийгдэх тохируулга, суутгалын дүн нь Гэрээний дүнд байгаа суутгалд хамаарахгүй.

#### 4.12. Талбайн зурваст нэвтрэх эрх

Гэрээнд өөрөөр заагаагүй бол Захиалагч нь ажилд шаардлагатай тусгайлан эсхүл тур зуурын ажлын зурвас бүхий талбайд нэвтрэх, эзэмшихийг зөвшөөрнө. Гүйцэтгэгч өөрийн эрсдэл, зардлыг тооцон ажлыг гүйцэтгэх зорилгоор талбайн гадна ямар нэгэн нэмэлт техник хэрэгслийг байрлуулж болно.

#### 4.13. Хөндлөнгийн нөлөөлөл үзүүлэхээс зайлсхийх

Гүйцэтгэгч нь олон нийтийн амгалан тайван байдалд, эсхүл Захиалагч болон бусдын эзэмшлийн байхаас үл хамааран бүх төрлийн зам, бусдын эзэмшил, өмчлөлд нэвтрэх, тэдгээрийг ашиглах, эзэмшихэд шаардлагагүйгээр эсхүл



зохисгүйгээр хөндлөнгөөс саад учруулахгүй байна.

#### 4.14. Нэвтрэх зам барих

Гүйцэтгэгч үндсэн хугацаанд ажлын талбай руу явах шаардлагад нийцсэн нэвтрэх зам барина гэдгийг тооцсон байна. Гүйцэтгэгч ямар нэгэн зам, гүүрийг өөрийн ашиглаж буй тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, эсхүл Гүйцэтгэгчийн ажилтнуудын буруутай үйлдлээс болж эвдрэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна. Энэ арга хэмжээ нь тээврийн хэрэгсэл болон түр замыг ашиглахад шаардлагад нийцсэн байна.

Эдгээр нөхцөлүүдэд өөрөөр заагаагүй бол:

- (a) Гүйцэтгэгч өөрийн ашиглах нэвтрэх замд шаардлагатай ямар нэгэн засвар арчлалтыг хариуцна.
- (b) Гүйцэтгэгч нэвтрэх замын дагууд шаардлагатай тэмдэг тэмдэглэгээгээр хангах ба нэвтрэх зам, тэмдэг тэмдэглэгээг тавихдаа холбогдох байгууллагаас зөвшөөрөл авсан байна.
- (c) Захиалагч нэвтрэх замын ашиглалтаас үүдэлтэй ямар нэгэн нэхэмжлэлийг хариуцахгүй.
- (d) Захиалагч нэвтрэх замын шаардлагад нийцсэн эсэхэд баталгаа өгөхгүй.
- (e) Гүйцэтгэгчид шаардлагатай нэвтрэх замд гарах зардлыг Гүйцэтгэгч өөрөө даана.

#### 4.15. Бараа, материалыг тээвэрлэх

Гэрээнд өөрөөр заагаагүй бол:

Гүйцэтгэгч ямар нэгэн голлох бараа материалыг ажлын талбай руу хүргэгдэхээс 21-ээс доошгүй хоногийн өмнө Захиалагчид мэдэгдэл өгсөн байна.

Гүйцэтгэгч барилгын ажилд шаардлагатай бүх бараа материал болон бусад зүйлсийн баглаа боодол, ачлага, тээвэрлэлт, хүлээн авах, хадгалах, хамгаалах асуудлыг хариуцна.

Гүйцэтгэгч бараа, материалын тээвэрлэлтээс болсон аливаа эвдрэл, гэмтэл, алдагдал, хохирлыг Захиалагчид учруулахгүй ба тэдгээрийн тээвэрлэлттэй холбоотой бүх нэхэмжлэлийг тохиролцож өөрсдөө төлнө.

Худалдан авах ажиллагааг хариуцсан Тал тээвэрлэлтийг хариуцна. Бараа, материалыг хүлээн авсан Тал хадгалалт, хамгаалалтыг хариуцна.

#### 4.16. Гүйцэтгэгчийн техник хэрэгсэл

Гүйцэтгэгч ажлын техникийн даалгаварт заасан ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай бүх техник, хэрэгслийг хариуцна. Ажлын талбай дээр авчирсан Гүйцэтгэгчийн техник, хэрэгслийг зөвхөн ажил гүйцэтгэх зориулалтаар ашиглана. Гүйцэтгэгч ажлын талбайгаас ямар нэгэн техник, хэрэгслийг Инженерийн зөвшөөрөлгүйгээр зөөвөрлөхгүй. Гэхдээ, ажлын талбайн гаднах бараа, материалыг тээвэрлэх тээврийн хэрэгсэл, Гүйцэтгэгчийн хүмүүст зөвшөөрөл авах шаардлагагүй.

#### 4.17. Байгаль орчныг хамгаалах

Гүйцэтгэгч ажлын талбайд болон гадна талд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх /түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласан талбай гэх мэт шаардлагатай газруудад/ арга хэмжээг авна.

Гүйцэтгэгч нь өөрийн үйл ажиллагаанаас болж хэт дулаан ялгаруулалт үүсэх, хөрсний гадаргуу, голын сав газрыг гэмтээх нь холбогдох хууль эсхүл шаардлагад заасан үнэлгээнээс хэтрүүлэхгүй байлгах үүрэг хүлээнэ.

#### 4.18. Байгалийн нөөц, цахилгаан, ус, хийн ашиглалт

- 4.18.1. Талууд гэрээний үнэд байгалийн нөөц ашиглалт (түгээмэл тархацтай ашигт малтмал, ус)-ын зардлыг оруулахгүй байхаар тохиролцов.
- 4.18.2. Захиалагч төмөр замын барилгын нийт ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулыг хийх бөгөөд Гүйцэтгэгчийн сар бүрийн баталгаажсан ажлын гүйцэтгэлд үндэслэн байгалийн нөөц ашигласны төлбөрийг Төслийн зориулалтын хөрөнгөөс холбогдох байгууллагад шууд төлнө.
- 4.18.3. Гүйцэтгэгч ажлын болон гадна талбайд шаардагдах энэ хэсгийн 4.18.2-т зааснаас бусад цахилгаан, эрчим хүч, хий, харилцаа холбоо, бусад үйлчилгээ зэрэг асуудал, тэдгээрийн аюулгүй ажиллагааг өөрийн зардлаар хариуцна.

#### 4.19. Захиалагчийн техник, хэрэгсэл болон хөнгөлөлттэй үнээр ашиглах материал

Захиалагч техникийн шаардлагад заасан заавар болон үнийн зардлаар ажлыг гүйцэтгэхэд ашиглаж болох өөрийн техник, хэрэгслийг Гүйцэтгэгчид түрээсээр ашиглуулж болно. Талууд холбогдох гэрээг тусад нь байгуулах бөгөөд үнийг хоорондын тооцоогоор харилцан суутгаж барагдуулна.

Гүйцэтгэгч нь Захиалагчийн орон нутгийн захиргааны байгууллагатай байгуулсан гэрээний дагуу түгээмэл тархацтай ашигт малтмалыг ашиглана.

Захиалагчийн техник, хэрэгслийг ашиглах тоо хэмжээ, зардал, түгээмэл тархацтай ашигт малмал ашигласны болон усны төлбөрийг Гэрээний 2.5 (Захиалагчийн нэхэмжлэх), 13.5 (Шийдвэр)-д заасны дагуу Инженер тодорхойлж зөвшөөрсөн байна.

#### 4.20. Ажлын явцын тайлан

Гэрээнд өөрөөр заагаагүй бол, Гүйцэтгэгч нь ажлын явцын тайланг сар бүр гаргах бөгөөд тайланг цаасаар 3 (гурав) хувь бэлтгэж Захиалагчид цахим хувийн хамт өгнө. Ажлын явцын эхний тайлан Ажил эхлэх өдрөөс хойшх эхний хуанлийн сарын сүүлийн өдөр дуусталх хугацааг хамарна. Түүнээс хойшх ажлын явцын тайланг тухайн тайлант хугацааг хамруулан сүүлчийн өдрөөс хойш 7 хоногийн дотор өгнө.

Барилгын ажлыг хүлээн авсан баримтад заасан хийгдээгүй үлдсэн бүх ажлыг Гүйцэтгэгч хийж дуустал тайлагнал үргэлжилнэ. Тайлан бүр дараах агуулгыг багтаасан байна. Үүнд:

- (a) Гүйцэтгэгчийн баримт бичиг, худалдан авалт, үйлдвэрлэл, барилга угсралтын ажил, туршилтын талаар оруулж ажлын гүйцэтгэлийн бүдүүвчийг хавсаргах, мөн 5 дугаар зүйлд тодорхойлсны дагуу хүлээн зөвшөөрөгдсөн Туслан гүйцэтгэгчийн ажил тус бүрийг;
- (b) Талбай дээрх ажлын явц, үйлдвэрлэлийн байдлыг харуулсан гэрэл зургууд;
- (c) Техник болон материалын нэр төрөл тус бүр, материалын бүтээмж, үйлдвэрлэлийн байдал, үйлдвэрлэгчийн нэр, үйлдвэрлэлийн байршил, гүйцэтгэлийн хувь, материалын үйлдвэрлэлийн бодит болон төлөвлөж буй огноо: Үүнд:
  - (i) Үйлдвэрлэж эхэлсэн огноо;

- (ii) Гүйцэтгэгчийн шалгалт;
- (iii) Туршилт;
- (iv) Талбай дээр авчрах болон зөөх;
- (d) Гэрээний 6.10 (Гүйцэтгэгчийн ажилтан, техник хэрэгслийн бүртгэл)-т тусгасан дэлгэрэнгүй мэдээлэл;
- (e) Чанарын баталгаажуулалтын баримт бичиг, материалын туршилтын үр дүн, материалын гэрчилгээний хуулбар;
- (f) Гэрээний 2.5 (Захиалагчийн нэхэмжлэх)-д заасны дагуу гаргах мэдэгдэл болон 20.1(Гүйцэтгэгчийн нэхэмжлэх)-д заасны дагуу гаргах мэдэгдлүүдийн жагсаалт;
- (g) Аюултай үйлдэл, байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаа, олон нийтийн харилцааны талаарх аюулгүй байдалтай холбоотой мэдээлэл;
- (h) Төлөвлөгдсөн болон бодит ажлын гүйцэтгэлийн харьцуулалт, онцлог үйл явдал, Гэрээний дагуу ажлыг дуусгахад үүсч буй бэрхшээл, нөхцөл байдал, хоцорч буй ажлуудыг дуусгах арга хэмжээ.

#### 4.21. Талбай дээр ажиллах баталгаа

Гэрээнд өөрөөр заагаагүй бол:

- (a) Гүйцэтгэгч талбайн гадна талд ажиллах эрх бүхий хүмүүсийг хамгаалах хариуцлага хүлээнэ.
- (b) Эрх бүхий хүмүүс гэдэг нь Гүйцэтгэгч болон Захиалагчийн ажилтнууд, зочид байх бөгөөд талбай дээр ажиллахаар Захиалагч, Инженерээс мэдэгдсэн бусад хүмүүсийг хэлнэ.

#### 4.22. Гүйцэтгэгчийн талбайн ашиглалт

Гүйцэтгэгч ажлын талбай болон Захиалагчаас зөвшөөрсөн нэмэлт талбайд үйл ажиллагаа явуулна. Гүйцэтгэгч ажлын талбай болон эдгээр нэмэлт талбай дээр Гүйцэтгэгчийн техник хэрэгсэл, мөн ажилтнуудыг хамгаалах бүхий л арга хэмжээг авна.

Барилгын ажлыг гүйцэтгэх үед, Гүйцэтгэгч шаардлагагүй саад тотгорыг зайлуулж талбайг хамгаалах ба Гүйцэтгэгчийн техник хэрэгсэл болон илүүдэл материалыг эмх замбараатай байршуулж хадгалан хамгаална. Гүйцэтгэгч эвдэрхий, хэрэггүй хог хаягдалыг талбайгаас зөөн зайлуулж цэвэрлэнэ

Ажил хүлээн авах акт гармагц, Гүйцэтгэгч тухайн актад заасан ажлын талбайгаас Гүйцэтгэгчийн бүх техник хэрэгсэл, илүүдэл материал, эвдэрхий зүйл, хог хаягдлыг зөөн зайлуулж талбайг цэвэрлэнэ. Гүйцэтгэгч хийсэн ажлаа болон ажлын талбайг цэвэрхэн, аюулгүй байдлыг хангана. Гэхдээ, Гүйцэтгэгч гэрээгээ бүрэн биелүүлтэл буюу баталгаат засварын хугацааны үед Гүйцэтгэгчид шаардлагатай гэж үзсэн материалаа талбай дээр үлдээж болно.

#### 4.23. Эртний олдвор

Ажлын талбайгаас илэрсэн эртний олдвор, зоос, гар урлал, үнэт зүйл, геологийн болон археологийн олдоц, эд зүйлсийг Захиалагчийн эрх бүхий этгээд хамгаалах газарт хүргэнэ. Гүйцэтгэгч эдгээр олдворуудыг өөрийнх нь ажилтнууд болон бусад ямар нэгэн хүн эвдлэх, зөөхөөс урьдчилан сэргийлэх бүхий л боломжит арга хэмжээг авсан байна.

Гүйцэтгэгч иймэрхүү олдворыг олж илрүүлсэн даруйдаа холбогдох заавар авахаар Инженерт мэдэгдэнэ. Хэрэв өгсөн зааврыг дагаж мөрдсөнөөр хугацаа

алдсан эсхүл ямар нэгэн зардал гарсан бол Гүйцэтгэгч Гэрээний 20.1 (Гүйцэтгэгчийн нэхэмжлэх)-д заасны дагуу дараагийн мэдэгдлийг Инженерт өгөх эрхтэй. Үүнд:

- a. Дээрх шалтгааны улмаас ажил хугацаандаа дуусах боломжгүй болж хугацааг сунгахад хүрсэн бол Гэрээний 8.4 (Ажил дуусах хугацааг сунгах)-т заасны дагуу гэрээний хугацааг сунгах;
- b. үүнтэй холбоотой гарах зардлыг Гэрээний үнэд оруулах.

Энэхүү мэдэгдлийг хүлээн авсаны дараа Инженер нь эдгээр асуудлыг шийдвэрлэх болон зөвшилцөх үүднээс Гэрээний 3.5 (Шийдвэр)-д заасны дагуу арга хэмжээ авна.

## 5. Хүлээн зөвшөөрөгдсөн туслан гүйцэтгэгч

### 5.1. Хүлээн зөвшөөрөгдсөн туслан гүйцэтгэгчийн тодорхойлолт

Энэ нь Захиалагчийн зүгээс Гүйцэтгэгчид туслан гүйцэтгэхийг бичгээр зөвшөөрсөн туслан гүйцэтгэгч байна. Ийнхүү зөвшөөрсөн нь туслан гүйцэтгэгчийн өмнө Захиалагч аливаа үүрэг, хариуцлага хүлээх үндэслэл болохгүй.

### 5.2. Туслан гүйцэтгүүлэхээс татгалзах

Захиалагч Гүйцэтгэгчийн санал болгосон туслан гүйцэтгэгчийг шаардлага хангаж байгаа эсэхэд үнэлэлт өгч, үндэслэл бүхий шалтгаанаар түүнийг туслан гүйцэтгэгчээр ажиллуулахаас татгалзаж болно.

### 5.3. Хүлээн зөвшөөрөгдсөн туслан гүйцэтгэгчид төлөх төлбөр

Гүйцэтгэгч нь Захиалагчийн хүлээн зөвшөөрсөн туслан гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний дагуу төлөх ёстой түүний нэхэмжлэхэд заасан дүнг туслан гүйцэтгэгчид төлнө.

Ийнхүү төлөх дүн дээр нэмэгдсэн төлбөр, хураамжийг Гэрээний 5.4 (Төлбөрийг нотлох баримт бичиг)-т зааснаас гадна 13.5 (Түр тооцсон дүн)-д заасны дагуу гэрээний дүнд оруулна.

### 5.4. Төлбөрийг нотлох баримт бичиг

Инженер нь хүлээн зөвшөөрөгдсөн туслан Гүйцэтгэгчид төлөх төлбөрийн гэрчилгээг гарахын өмнө өмнөх төлбөрийн гэрчилгээний дагуу авсан нийт дүн болон төлбөрөөс суутгах, хасах төлбөрийг харуулсан нотолгоог танилцуулахыг ерөнхий Гүйцэтгэгчээс шаардаж болно. Гүйцэтгэгч нь:

Инженерт холбогдох баримт нотолгоог танилцуулах, мөн

- 1) Гүйцэтгэгч эдгээр төлбөрийг төлөхөөс татгалзах, зөвшөөрөхгүй байх эрхтэй гэдгийг бичгээр мэдэгдэх;
- 2) Гүйцэтгэгчийн эрх, үүргийг албан ёсоор томилогдсон туслан Гүйцэтгэгчид мэдэгдсэн гэх боломжит нотлох баримтыг Инженерт танилцуулах;

Дээр дурдсан (1), (2)-т заасны дагуу Гүйцэтгэгч нотлох баримтыг танилцуулаагүй бол Захиалагч нь туслан Гүйцэтгэгчид төлөх ёстой өмнө нь гэрчилсэн бүх дүнг эсхүл хэсгийг нь туслан Гүйцэтгэгчид шууд төлнө. Энэ тохиолдолд Гүйцэтгэгч нь Захиалагчаас туслан гүйцэтгэгчид шууд төлсөн төлбөрийн дүнг Захиалагчид буцаан төлнө.

## 6. Ажиллах хүч, ажилтан

### 6.1. Ажилтан хөлслөх

Техникийн шаардлагад өөрөөр заагаагүй бол Гүйцэтгэгч нь орон нутаг, өөр бүс нутгаас мэргэжлийн болон мэргэжлийн бус ажилтан хөлсөөр ажиллуулж болох бөгөөд энэ тохиолдолд тэдгээрийн цалин хөлс, хоол, унаа, хоноглох байрыг хариуцаж ажиллах нөхцөлөөр хангана.

#### 6.2. Цалингийн үнэлгээ, ажиллуулах нөхцөл байдал

Гүйцэтгэгч нь энэ зүйлийн 6.1-д заасны дагуу хөлсөөр ажиллуулах ажилтнуудыг цалингийн үнэлгээгээр цалинжуулах бөгөөд ажил гүйцэтгэж буй үйлдвэрлэлийн орчин, нөхцөлийг харгалзан үзнэ.

Гүйцэтгэгч нь ажиллах хүчний цалин хөлс, тэтгэмж, ажлын хөлснөөс татвар, шимтгэл суутган төлөх асуудлыг холбогдох хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

#### 6.3. Захиалагчийн үйлчилгээнд ажиллах ажилтан

Гүйцэтгэгч нь Захиалагчийн ажилтныг аливаа хэлбэрээр өөртөө татан ажиллуулах, татан ажиллуулах оролдлого хийж болохгүй.

#### 6.4. Хөдөлмөрийн тухай хууль

Гүйцэтгэгч ажиллах хүчний хөдөлмөрийн зохион байгуулалт, байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн байдлыг хангахдаа холбогдох хууль тогтоомж, стандарт, норм, норматив, дүрэм, журмыг хангахдаа холбогдох хуулийг чанд дагаж мөрдөх бөгөөд ажиллагсдад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн аюулгүй ажиллагааны заавар, зааварчилгааг зохих журмын дагуу өгч урьдчилан сэргийлэх ажиллагааг тогтмол явуулна.

Гүйцэтгэгч нь ажиллах хүчний ажлын талбайд байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн холбогдох хууль тогтоомж, стандарт, норм, дүрэм, журмыг дээрээ аюулгүй байдалтай холбоотой холбогдох хуулийг дагаж мөрдөхийг шаардана.

#### 6.5. Ажлын цаг

Гүйцэтгэгч нь ажилтны ажлын цагийг Хөдөлмөрийн тухай хууль, Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нийцүүлэн зохион байгуулна.

#### 6.6. Ажилтныг ажиллах нөхцөлөөр хангах

Техникийн шаардлагад өөрөөр заагаагүй бол Гүйцэтгэгч нь өөрийн ажилтны эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хамгаалах урьдчилан сэргийлэхээс гадна шаардлагатай түр орон сууцаар хангасан байна. Гүйцэтгэгч техникийн шаардлагад заасны дагуу захиалагчийн ажилтанд шаардлагатай нөхцөлөөр хангана.

Гүйцэтгэгч нь ажиллах хүчний дагаж мөрдөх дотоод дэг журам, ажил амралтын дэглэм, зохион байгуулалт, засвар, үйлчилгээг хариуцна.

Гүйцэтгэгчийн ажилтан нь өөрийн мэргэжлийн чиглэлээр зохих мэдлэг ур чадвар, ажлын туршлагатай байна.

Гүйцэтгэгчийн төлөөлөгчийг оролцуулан дараах байдалтай аливаа этгээдийг Барилгын ажлын талбайд ажиллуулах болон оруулахыг хориглоно. Үүнд:

- a. Аливаа зүй бус үйлдэл байнга гаргадаг;
- b. Ажил үүргээ хийх чадваргүй эсхүл хайхрамжгүй ханддаг;
- c. Дүрэм, журам, заавар, Гэрээний аливаа заалтыг дагаж мөрдөөгүй;
- d. Бусдын эрүүл мэнд, аюулгүй байдал эсхүл байгаль орчинд хор хохирол учруулж болзошгүй этгээдийг;
- e. Согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн аливаа этгээд

Гүйцэтгэгч нь өөрийн ажиллагсдын дунд аливаа хууль бус, догшин ширүүн, ёс зүйгүй үйлдэл гарахаас сэрэмжлэх, урьдчилан сэргийлэх, амгалан тайван байдлыг хангах, ажлын талбай болон түүний ойр орчимд байгаа иргэд, бусдын эд хөрөнгийг хамгаалах зохих ёсны бүхий л арга хэмжээг үргэлж авна.

Гүйцэтгэгч нь ажлын талбайд ажиллагсдын ажил үүргийн хуваарь, ашиглаж байгаа техник хэрэгслийг нэр, төрөл бүрээр бүртгэж, энэ тухай дэлгэрэнгүй мэдээллийг Захиалагчид өгнө.

Гүйцэтгэгч нь барилгын ажлын явцад ашиглах түр барилгын хэмжээ хүрэлцээ нь барилгын ажлын цар хүрээг бүрэн хангах хэмжээнд байх бөгөөд ажил дууссаны дараа бүрэн нүүлгэн шилжүүлнэ.

Түр барилгыг дараах байдлаар ангилна. Үүнд:

- (i) үйлдвэрлэлийн (хэвний, арматурын, бетон хольцын, зуурмагийн, мужааны цех тасаг гэх зэрэг);
- (ii) агуулахын (ил ба цоожтой, саравч зэрэг);
- (iii) ахуйн (контор, ажилчдын хувцас солих өрөө, цайны газар, сууц, эмнэлгийн цэг, дулаацах байр зэрэг);
- (iv) инженерийн сүлжээ (түр ус, ариутгах татуурга, эрчим хүч, дулаан ба шахсан агаарын зэрэг);

Эдгээр түр барилга байгууламж нь тухайн барилгын төлөвлөлтийн норм ба дүрмийн шаардлагыг (барилгын галын аюулгүйн, эрүүл ахуйн) бүрэн хангасан байвал зохино.

#### **6.7. Байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй болон нийгмийн менежмент**

Гүйцэтгэгч нь Байгаль орчин, Хөдөлмөрийн аюулгүй байдал, Эрүүл ахуйн болон нийгмийн менежментийн төлөвлөгөө боловсруулан, Захиалагчийн саналыг тусган, батална.

Талууд шаардлагатай тохиолдолд Байгаль орчин, Хөдөлмөрийн аюулгүй байдал, Эрүүл ахуйн болон нийгмийн менежментийн төлөвлөгөөнд холбогдох хууль тогтоомж, стандарт, дүрэм, журмыг үндэслэн нэмэлт өөрчлөлт оруулж болно.

Гүйцэтгэгч нь Гэрээний хэрэгжилтийн хугацаанд Хавсралт 11-д заасан төлөвлөгөө болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийг мөрдөж, стандартын шаардлага, өөрийн ажиллах хүчний аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх бүх талын арга хэмжээг авах, ажлын байр, үйлдвэрлэлийн орчинд хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллана.

Гүйцэтгэгч нь барилгын ажил гүйцэтгэх хугацаанд үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гаргахаас урьдчилан сэргийлэх бүхий л арга хэмжээг авч ажиллах бөгөөд Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсан тохиолдолд түүний үр дагаврыг бүрэн хариуцна.

Гүйцэтгэгч нь өөрийн болон Туслан Гүйцэтгэгч, Гэрээт этгээдүүдийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд хор хохирол учруулахгүй байх бүхий л арга хэмжээг ажиллах бөгөөд байгаль орчинд хор хохирол учирсан тохиолдолд түүний үр дагаврыг бүрэн хариуцна.

Захиалагч болон Захиалагчийн төлөөлөгч төсөл хэрэгжиж байх хугацаанд хэдийд ч хяналт шалгалт хийж болно.

Захиалагч болон Захиалагчийн төлөөлөгчийн хийсэн хяналт шалгалт нь Гүйцэтгэгчийг энэхүү гэрээгээр хүлээсэн үндсэн үүрэг хариуцлагаас



чөлөөлөхгүй.

**ИЛ БОЛСОН**

Гүйцэтгэгч нь дараах үүрэгтэй: Үүнд:

- (i) байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журмыг өөрийн болон туслан Гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд мөрдүүлэн, хяналт тавьж ажиллах;
- (ii) барилгын ажлын талбайд ажиллах хүмүүсийн (ажиллагсад, иргэн, зочид) аюулгүй байдлыг хариуцах;
- (iii) барилгын ажлын талбайд аюул учрахаас сэргийлэх үүднээс барилгын ажлын талбай дахь шаардлагагүй саадуудыг цэвэрлэх, ажлын талбайн эмх цэгцтэй байдлыг хариуцах;
- (iv) Гэрээний хугацаанд Барилгын ажлын болон ахуйн байрны харуул хамгаалалтаар хангах;
- (v) барилгын ажлыг гүйцэтгэхтэй холбоотойгоор барилгын ажлын талбай болон зэргэлдээ газар ажиллаж буй хүмүүсийг хамгаалах болон тэдний ашиглахад шаардлагатай байж болох Түр байгууламжууд (зам, явган хүний зам, харуулын байр, хашаа зэрэг)-ыг байгуулах.

Гүйцэтгэгч нь байгаль орчныг хамгаалах (Ажлын талбай, түүний орчин) сөрөг нөлөөллийг бууруулах, нөхөн сэргээлт хийх, бохирдол, хэт өндөр дуу чимээ болон түүний үйл ажиллагааны улмаас иргэд ба бусдын өмч хөрөнгөд учруулж болзошгүй хохирол, хүндрэлийг хязгаарлах талаар шаардлагатай бүх арга хэмжээг авна.

Гүйцэтгэгч нь түүний үйл ажиллагааны улмаас хорт бодис, хий ялгаруулалт болон газрын гадаргуу дээр бохир усны урсгал нь холбогдох хуульд заасан хэм хэжээнээс хэтрэхгүй байх талаар анхаарна.

Гүйцэтгэгч нь төслийн үйл ажиллагаатай холбогдуулан барилга ажлын явцад ажиллагсдыг эрүүл, аюулгүй ажиллах нөхцөлөөр хангах, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн шаардлагатай дүрэм, журмыг баталж, мөрдүүлэн ажиллана.

Гүйцэтгэгч нь ажиллагсаддын эрүүл мэндийг хамгаалах, эрүүл мэндийн анхан шатны тусламж үзүүлэх нөхцөлөөр хангасан байна.

Гүйцэтгэгч нь төслийн үйл ажиллагаанд байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн байдал хариуцсан ажилтанг томилон ажиллуулна. Ажилтан нь шаардлага хангасан, мэргэжлийн болон мэргэшсэн этгээд байна.

Гүйцэтгэгч нь аливаа аваар осол гармагц нэн даруй болсон явдлийн дэлгэрэнгүй мэдээллийг Захиалагчид явуулна. Гүйцэтгэгч нь бүртгэл хөтөлж хүмүүсийн эрүүл мэнд, аюулгүй байдал, эд хөрөнгийн гэмтэл хохиролтой холбоотой тайланг Захиалагчийн шаардсан байдлаар гаргаж өгч байна.

Захиалагч нь БО, ХАБЭА-н ноцтой зөрчил гаргасан, Захиалагчийн хууль ёсны шаардлагыг удаа дараа биелүүлэхээс татгалзсан ажилтныг төслийн үйл ажиллагаанд оролцуулахгүй байх эрхтэй.

#### 6.8. Гүйцэтгэгчийн хяналт-шалгалт

Барилгын ажлыг гүйцэтгэх хугацаанд, түүнчлэн түүний дараа ч гэсэн Гүйцэтгэгч өөрийн үүрэг, хариуцлагын хүрээнд ажлыг төлөвлөх, чиглүүлэх, удирдах, үзлэг шалгалт хийх, ажлыг турших шаардлагатай бүх арга хэмжээг авсан байна.

Удирдлагын хяналтыг ажлын туршлагатай, шаардлага хангасан мэдлэг, ур чадвартай, хөдөлмөрийн аюулгүйн ажиллагааны хангалттай мэдлэг (шаардлагатай арга техник, учирч болох аюул болон аюул ослоос урьдчилан

сэргийлэх зэргийг (эрэлцүүлэн) тэй, хяналтыг хэрэгжүүлэхэд хүрэлцэхүйц хангалттай тооны мэргэжлийн хүмүүсээр гүйцэтгүүлнэ.

Гүйцэтгэгч нь Гэрээ байгуулагдсан өдрөөс хойш 21 (хорин нэг) хоногийн дотор удирдлагын хяналтыг хэрэгжүүлэх багийн бүрэлдэхүүнд ажиллах албан тушаалтнуудын нэрс, товч танилцуулгыг Гүйцэтгэгчийн санал болгож буй удирдлагын хяналтын зохион байгуулалтын бүтцийн хамт Захиалагчид ирүүлнэ. Гүйцэтгэгч нь энэхүү зохион байгуулалтын бүтцэд орсон аливаа өөрчлөлтийг цаг тухай бүр нь Захиалагчид бичгээр мэдэгдэж байна.

Гүйцэтгэгч нь удирдлагын хяналтын баг бүрэлдэхүүнд хяналтын үүргээ гүйцэтгэх хангалттай ажлын цаг гаргаж өгөх, Захиалагчийн урьдчилсан зөвшөөрөлгүй (тухайн хүн нас барсан, урт хугацаагаар өвчилсөн, тэтгэвэрт гарсан эсхүл цаашид ажиллахаа больсон зэрэг тодорхой шалтгааны үед Захиалагч зөвшөөрөл олгохоос татгалзахгүй, саатуулахгүй байх)-ээр ажил, үүргээс ажиллахаа больсон зэрэг тодорхой шалтгааны үед Захиалагч зөвшөөрөл олгохоос татгалзахгүй, саатуулахгүй байх)-ээр ажил, дчилсан зөвшөөрөлгүй (тухайн хүн нас бар

#### 6.9. Гүйцэтгэгчийн ажилтан

Гүйцэтгэгчийн ажилтан нь өөрийн мэргэжлээр туршлагажиж мэргэшсэн, ур чадвартай байна. Инженер нь ажлын талбай дээр болон ажил гүйцэтгэхэд ажиллуулж буй Гүйцэтгэгчийн төлөөлөгч, ажилтанг дараах тохиолдолд солихыг шаардаж болно.

- a. ажиллагдаас ямар нэгэн буруутай үйлдэл хийхийг шаарддаг;
- b. хариуцсан ажилдаа хайхрамжгүй хандаж, хангалтгүй гүйцэтгэдэг, ажлын ур чадвар хангалтгүй;
- c. Гэрээний үүргээ биелүүлдэггүй, хариуцлагаа ухамсарладаггүй, гэрээний заалтыг дагаж мөрддөггүй; эсхүл
- d. байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хамгаалахад нөлөөлөх аливаа зүй бус үйл, хандлагыг удаа дараа гаргасан.

Хэрэв зохистой гэж үзвэл, Гүйцэтгэгч тэрхүү ажилтныг сольж адил түвшний туршлагатай хүнийг оронд нь томилно.

#### 6.10. Гүйцэтгэгчийн ажилтан, техник хэрэгслийн бүртгэл

Гүйцэтгэгч нь ажлын талбай дээр ажиллах өөрийн ажилчид, албан хаагч болон техник хэрэгсэл тус бүрийн төрөл, тоог харуулсан нарийвчилсан мэдээллийг Инженерт танилцуулсан байна. Нарийвчилсан мэдээллийг Гүйцэтгэгч нь ажлыг гэрээт ажлыг хүлээн авах гүйцэтгэлийн актад заасан бүх ажлыг дуусгах хүртэл хуанлийн сар бүр Инженерийн баталсан маягтын дагуу танилцуулна.

#### 6.11. Замбараагүй байдлыг цэгцлэх

Гүйцэтгэгч нь ажлын талбайд үүссэн хууль бус, эмх замбараагүй үйлдэл, үйл явдлыг таслан зогсоох бүхий л боломжит арга хэмжээг авах ба ажлын талбайд болон талбайн ойролцоох өмч хөрөнгийг хариуцаж, ажилчдын эрх ашиг, тайван байдлыг сахин хамгаална.

#### 6.12. Гадаадын ажиллах хүч

Гүйцэтгэгч нь ажлыг гүйцэтгэх зорилгоор холбогдох хуулийн дагуу ямар нэгэн гадаадын ажиллах хүчийг тухайн оронд авчран ажиллуулж болно. Гүйцэтгэгч нь эдгээр ажилтнуудыг ажиллах болон оршин суух зөвшөөрөл, холбогдох виз гаргуулсан гэдэгт баталгаа өгнө. Хэрэв Гүйцэтгэгч хүсвэл Захиалагч нь өөрийн хүчин чармайлтаар Гүйцэтгэгчийн ажиллах хүчийг авчрахад шаардлагатай

орон нутгийн, төрийн болон засгийн газрын зөвшөөрлийг олж авахад цаг тухайд нь боломжит туслалцааг үзүүлнэ.

Гүйцэтгэгч нь эдгээр ажилтнуудыг оршин суудаг газар луу нь буцаах хариуцлагыг хүлээнэ. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэж байхдаа эдгээр ажилтнуудын хэн нэгэн, эсхүл тэдгээрийн гэр бүлийн хэн нэгэн байж байгаад нас барах тохиолдолд тэдгээрийг буцаах болон оршуулгатай холбоотой бүх арга хэмжээг авах хариуцлагыг хүлээнэ.

#### **6.13. Хүнсний бүтээгдэхүүний хангалт**

Гүйцэтгэгч нь гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан өөрийн ажилчдад зориулан шаардлагад нийцсэн хүнсийг боломжит үнээр хангах арга хэмжээг авна.

Гүйцэтгэгч нь орон нутгийн өөрөө удирдах байгууллага болон иргэдтэй хамтарч ажиллана.

Гүйцэтгэгч нь хоол хүнсний бүтээгдэхүүнийг худалдан авах, хадгалах, бэлтгэх, боловсруулахдаа холбогдох хууль тогтоомж, стандарт, дүрэм, журамд шаардлагыг чанд мөрдөнө.

#### **6.14. Усны хангамж**

Захиалагч нь Төслийн барилгын ажилд шаардагдах гүний усны хайгуулын судалгаа хийх, гүний худаг гаргах ажлыг хариуцаж, холбогдох эрх бүхий байгууллагатай ус ашиглалтын гэрээ байгуулна. Төслийн барилгын ажилд ашиглагдаж байгаа гүний худаг, худгийн тоног төхөөрөмж нь Захиалагчийн эзэмшил, өмчлөлд байна.

Гүйцэтгэгч нь Захиалагчийн байгуулсан ус ашиглалтын гэрээний дагуу ус ашиглах бөгөөд ус ашиглалтын тайлан, мэдээ (худаг бүрийн тоолуурын заалт)-г Гэрээнд заасны дагуу баталгаажуулж Захиалагчид сар бүр ирүүлнэ.

Төмөр замын доод бүтцийн барилгын ажлыг эхлүүлснээс хойш Захиалагчид ажлын үр дүнг бүрэн хүлээлгэн өгөх хүртэл хугацаанд Төслийн барилгын ажлын ашиглагдаж байгаа бүх гүний худаг, худгийн тоног төхөөрөмжийн ашиглалт, хамгаалалт, холбогдон гарах зардлыг Гүйцэтгэгч хариуцна.

#### **6.15. Хорхой шавьж болон халдварт өвчний эсрэг авах арга хэмжээ**

Гүйцэтгэгч нь гэрээний хугацаанд ажлын талбай дээр ажиллах өөрийн ажилчдыг хорт хорхой шавьж, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэдгээрийн эрүүл мэндэнд учрах аюулыг багасгах боломжит бүх арга хэмжээг авна. Гүйцэтгэгч нь хорхой шавьжийг хэрхэн устгах талаар орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын зааврыг дагаж мөрдөнө.

#### **6.16. Согтууруулах ундаа болон мансууруулах бодис хэрэглэх**

Гүйцэтгэгч нь согтууруулах ундаа, мансууруулах бодисыг ажлын талбай, түүний орчинд худалдах, өгөх, бараа солилцох зэрэг аливаа хэлбэрээр хэрэглэхгүй, ашиглахгүй байх, энэхүү журмыг өөрийн ажиллагсдад нэгэн адил мөрдүүлэх үүрэгтэй.

#### **6.17. Зэр зэвсэг хэрэглэх**

Гүйцэтгэгч нь цэргийн болон цэргийн бус аливаа этгээдэд зэр, зэвсэг, түүнтэй ижил төрлийн эд зүйлсийг өгөх, бараа солилцох хэлбэрээр ашиглахгүй бөгөөд энэхүү журмыг өөрийн ажиллагсдад нэгэн адил мөрдүүлэх үүрэгтэй.

#### **6.18. Баяр ёслол, шашны ёс заншил**

Гүйцэтгэгч нь тухайн нутгийн болон бүх нийтийн уламжлалт баяр ёслол, амралтын өдөр, шашны болон бусад ёс заншилд хүндэтгэлтэй хандана.

**6.19. Гашуудлын арга хэмжээ**

Гүйцэтгэгч нь ажлыг гүйцэтгэж буй орон нутгийн ажилчдын хэн нэгэн нас барвал орон нутагтай хамтран холбогдох арга хэмжээ авах хариуцлагыг хүлээнэ.

**6.20. Албадан ажил хийлгэхийг хориглох**

Гүйцэтгэгч нь бусад этгээдийг албадан ажил хийлгэхийг хориглоно. Аюул занал, ял шийтгэлийн хүрээнд бие даасан байдлаар "Албадан ажил хийлгэх, албадлагын ажилчид"-ыг сайн дураар ажил хийсэн гэж үзэхгүй.

**6.21. Хүүхдийг хөлслөн ажиллуулахыг хориглох**

Гүйцэтгэгч нь насанд хүрээгүй, иргэний эрх зүйн чадамжгүй этгээдийг ажиллуулахгүй.

**6.22. Ажиллагсдын ажил эрхлэлтийн бүртгэл**

Гүйцэтгэгч нь ажлын талбай дээр ажиллаж буй ажилчдын ажил эрхлэлтийн талаар нарийвчилсан, бүртгэл мэдээлэл хөтөлж, хадгалах үүрэгтэй. Энэхүү бүртгэл, мэдээлэлд ажилчдын нэр, нас, хүйс, ажилласан цаг, хөдөлмөрийн хөлсний талаарх мэдээлэл заавал орсон байна. Эдгээр бүртгэл, мэдээллийг сар бүр товчилсон байдлаар Инженерт танилцуулах бөгөөд ажлын үеэр гэнэтийн хяналт шалгалтад бэлэн байдалд байлгана. Эдгээр бүртгэл, мэдээлэлд Гэрээний 6.10 (Гүйцэтгэгчийн ажилтан, техник хэрэгслийн бүртгэл)-т заасны дагуу Гүйцэтгэгчийн танилцуулах нарийвчилсан мэдээлэл багтсан байна.

**7. Барилгын материал болон ажилчдын ур чадвар****7.1. Ажиллах чадвар**

Гүйцэтгэгч нь ажлыг гүйцэтгэхдээ:

- a. хууль тогтоомж, Гэрээнд заасан норм, нормативын баримт бичгүүд, стандарт, Захиалагч, Инженерийн зааварчилгаа, зөвлөмж, технологийн аргачлалыг чанд мөрдөх;
- b. мэргэжлийн ажиллах хүч, зориулалтын техник хэрэгсэлтэй байх, техник хэрэгслийн хэвийн ажиллагааг хангах урьдчилсан нөхцөлийг бүрдүүлсэн байх;
- c. дотоодын болон олон улсын зах зээлд ижил төрлийн ажлыг гүйцэтгэхэд голлон хэрэглэдэг инженерийн сайн туршлага, шилдэг технологи, нийтлэг жишгийг нэвтрүүлэх, мөрдөх;
- d. шаардлагатай нэмэлт ажиллах хүчийг орон нутгын иргэдээс бүрдүүлэх бодлого баримтлах.

**7.2. Материалын сорьц**

Гүйцэтгэгч нь ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай материалыг ашиглахаас өмнө зөвшөөрөл авах зорилгоор материалын дараах сорьц, дээж болон холбогдох мэдээллийг Инженерт танилцуулна.

Гүйцэтгэгчийн зардлаар үйлдвэрлэсэн материалын стандарт дээж болон Гэрээнд заасан дээж, сорьцыг хувилбарт байдлаар Инженерээс зааварчилсан нэмэлт дээж, сорьцыг Ажилд ашиглахаар төлөвлөсөн дээж тус бүрт гарал, үүсэл, хаяг шошго тавьсан байна.

Барилын ажилд ашиглаж буй материал, бүтээгдэхүүн нь Барилгын тухай хуулийн 13 дугаар зүйл, холбогдох стандарт, норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна.

**ИЛ БОЛСОН**

Барилгын материалыг

нэн тэргүүнд дотоодын зах зээлээс үндэсний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг худалдан авах бодлого баримтална.

**7.3. Хяналт-Шалгалт**

Захиалагчийн ажилтан дараах эрхтэй. Үүнд:

- a. Ажлын талбайн бүх хэсэгт болон байгалийн материал, түүхий эд авч буй аливаа газарт нэвтрэх;
- b. Барилгын ажил гүйцэтгэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх явцад материал болон хийцийг турших, хэмжих, шалгах, түүнчлэн материалын үйлдвэрлэлийн явцыг шалгах;
- c. Гүйцэтгэгч нь Захиалагчийн ажилтныг эдгээр үйл ажиллагааг шалгах, талбайд нэвтрэх, ашиглаж буй багаж хэрэгсэл болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хэрэгслийг шалгах бүхий л боломжоор хангасан байна.

Гүйцэтгэгч нь бэлэн болсон ажил, ажлыг далдлахаас өмнө, материалыг баглаж хадгалах, тээвэрлэхдээ тухай бүр Инженерт мэдэгдэл өгнө.

**7.4. Туршилт**

7.4.1. Энэхүү заалт нь Гэрээнд заасан бүх туршилтад хамаарна.

7.4.2. Энэхүү Гэрээний дагуу хийгдэх ёстой туршилт, шалгалтыг хийхгүйгээр Ажлын талбайд хийгдэх ажлын ямар ч хэсгийг орхигдуулж болохгүй. Хэрэв ийнхүү орхигдуулсан бол ажил гүйцэтгэх хугацааг сунгахгүйгээр Гүйцэтгэгчийн зөрдлаар ийнхүү орхигдуулсан хэсэг ажилд шаардлагатай туршилт, шалгалтыг хийхийг Захиалагч Гүйцэтгэгчээс шаардаж болно.

Гүйцэтгэгч нь заасан туршилтуудыг үр дүнтэй явуулахад шаардлагатай бүх техник хэрэгсэл, туслалцаа, баримт бичгүүд болон бусад мэдээллүүд, цахилгаан, тоног төхөөрөмж, түлш, багаж, ажиллах хүч, материалууд (Гэрээгээр Захиалагч нийлүүлнэ гэж зааснаас бусад) болон чадварлаг, туршлагатай ажилтнуудаар хангана. Гүйцэтгэгч нь Захиалагчтай туршилтын материал, хэсэг ажлуудад туршилт хийх хугацаа, газрыг тохиролцоно (хэрэв тохиролцож чадахгүй бол Захиалагч шууд удирдамж өгнө).

Захиалагч нь Гэрээний 13 (Өөрчлөлт болон тохируулга)-т заасны дагуу тухайн туршилтуудыг явуулах байршил, бусад нарийн зааварчилгаа бүхий зүйлсийг өөрчлөх, эсхүл нэмэлт туршилтууд явуулах удирдамжийг Гүйцэтгэгчид өгч болно. Хэрэв эдгээр өөрчлөгдсөн болон нэмэлт туршилтаар туршигдсан ажлын үр дүн, материал, хийцүүд нь Гэрээнд заасан шаардлагыг хангаагүй, эсхүл дахин өөр туршилт хийх шаардлагатай болсон бол үүнийг Гүйцэтгэгчийн зөрдлаар хийнэ.

7.4.3. Инженер нь Гүйцэтгэгчид туршилтыг очиж үзэх эсэх мэдэгдлийг 24 цагаас багагүй хугацааны өмнө мэдэгдэнэ. Хэрэв Инженер өөрийн зөвшөөрсөн хугацаа, байршилд гүйцэтгэсэн туршилтад очихгүй бол Гүйцэтгэгч Инженерийн зааварчилгаагүйгээр туршилтыг явуулж болох ба Инженерийг туршилтын үед байлцсан гэж үзнэ.

7.4.4. Хэрэв Гүйцэтгэгч эдгээр зааварчилгааг дагаж мөрдсөнөөр Захиалагчийн хариуцлагаас болж хугацаа алдахад хүрсэн, нэмэлт зардал гарсан бол Инженерт мэдэгдэл өгч, Гэрээний 20.1 (Гүйцэтгэгчийн нэхэмжлэх)-д заасны дагуу нэхэмжлэх гаргах эрхтэй.

- a. Дээрх шалтгааны улмаас ажил хугацаандаа дуусах боломжгүй болж хугацааг сунгахад хүрсэн бол гэрээний 8.4 (Ажил дуусах хугацааг

**ИЛ БОЛСОН**

сунгах)-т заасны дагуу гэрээт ажлын хугацааг сунгах;

- b. үүнтэй холбоотой зардлыг Гэрээний үнэд оруулах.

Энэхүү мэдэгдлийг хүлээн авсаны дараа Инженер эдгээр асуудлыг шийдвэрлэх болон зөвшилцөх үүднээс Гэрээний 3.5 (*Шийдвэр*)-д заасны дагуу холбогдох арга хэмжээг авна.

- 7.4.5. Гүйцэтгэгч тэр даруй зохих ёсоор баталгаажсан туршилтуудын тайланг Инженерт хүргүүлнэ. Инженер заасан туршилтуудыг гүйцэтгэсэн даруйд Гүйцэтгэгчид туршилтыг баталгаажуулсан гэрчилгээ олгоно. Хэрэв Инженер туршилтад байлцаагүй бол хэмжилтийн заалт, нарийвчлалыг Инженер зөвшөөрсөн гэж үзнэ.

#### 7.5. Ажлыг хүлээн авахаас татгалзах

Хэрэв үзлэг шалгалт, туршилт, хэмжилтээр ажлын үр дүнд зөрчил, доголдол илэрч Гэрээнд заасан шаардлага хангаагүй тохиолдолд Захиалагч нь шалтгааныг тодорхой дурдсан мэдэгдлийг Гүйцэтгэгчид өгч, ажлын үр дүн, материал, хийцийг ашиглахаас татгалзана.

Хэрэв Инженер нь эдгээр материал, хийцийг дахин туршихыг шаардвал ижил нөхцөлөөр туршилтыг давтан гүйцэтгэнэ. Хэрэв татгалзсан байдал, дахин туршилт явуулах нь Захиалагчид нэмэлт зардал гаргах шалтгаан болсон бол Гүйцэтгэгч эдгээр зардлыг Гэрээний 2.5 (*Захиалагчийн нэхэмжлэл*)-д заасны дагуу Захиалагчид төлнө.

#### 7.6. Засаж залруулах ажил

- 7.6.1. Өмнөх туршилт, олгосон гэрчилгээг үл харгалзан Захиалагч нь Гүйцэтгэгчид дараах зааварчилгааг өгч болно. Үүнд:

- Гэрээнд заасан шаардлага хангахгүй байгаа материал, бусад зүйлсийн байршлыг өөрчилж, шаардлагатай бол талбайгаас шилжүүлэх;
- Гэрээний дагуу хийгдээгүй, доголдолтой ажлын үр дүнг дахин гүйцэтгүүлэх;
- Аваар осол, урьдчилан таамаглах боломжгүй үйл явдлаас үүдэлтэй, аюулгүй байдлыг хангах үүднээс яаралтай шаардлагатай аливаа ажлыг гүйцэтгэх.

Гүйцэтгэгч заасан хугацаанд зааварчилгааг дагаж мөрдөн ажлыг хийх бөгөөд хэрэв дээр дурдсан "с"-д заасан байдал үүсвэл яаралтай гүйцэтгэнэ.

- 7.6.2. Хэрэв Гүйцэтгэгч зааварчилгааг мөрдөхгүй бол, Захиалагч ажлыг өөр бусад этгээдийг хөлслөн гүйцэтгүүлж болно. Ийнхүү Захиалагчийн зааварчилгааг мөрдөөгүйн улмаас ажлыг бусдаар гүйцэтгүүлсний төлбөр, холбогдон гарсан бусад зардлыг Гүйцэтгэгч Гэрээний 2.5 (*Захиалагчийн нэхэмжлэл*)-д заасны дагуу Захиалагчид нөхөн төлнө.

#### 7.7. Техник хэрэгсэл, материалын эзэмшил

Гүйцэтгэгч, түүний туслан гүйцэтгэгчийн техник хэрэгслүүд нь зөвхөн уг ажлыг гүйцэтгэхэд зориулагдсан гэж тооцох бөгөөд эдгээр техник хэрэгсэл цаашид хэрэглэгдэхгүй, ашиглагдахгүй болох нь нэгэнт тодорхой болох хүртэл Гүйцэтгэгч Захиалагчийн зөвшөөрөлгүйгээр техник хэрэгслийг ажлын талбайгаас авч явахгүй, Захиалагч зөвшөөрөл олгохгүй. Гүйцэтгэгчийн ажилтан, Гүйцэтгэгчийн техник хэрэгсэл, материалыг ажлын талбай руу эсхүл ажлын талбайгаас тээвэрлэхэд ашиглагддаг тээврийн хэрэгслийн хувьд Захиалагчийн зөвшөөрөл шаардлагагүй.

**ИЛ БОЛСОН**

Гэрээнд өөрөөр заагаагүй бол, Гүйцэтгэгч төлбөрийг Гэрээний 8.10 (Түр зогсолтын үеийн материалын төлбөр)-т заасны дагуу төлөгдөөгүй аливаа материал, техник, хэрэгсэл нь Захиалагчийн өмч байна.

**7.8. Ашиглалтын төлбөр**

Гүйцэтгэгч дор дурдсан зориулалтаар орон нутгаас ашигласан түгээмэл тархацтай ашигт малтмал, ус ашиглалтын болон холбогдох бусад төлбөр, хураамжийг хариуцан төлнө. Үүнд:

- a. Эрх бүхий төрийн байгууллагатай байгуулсан гэрээний дагуу зөвшөөрөгдсөн газраас ашигласан усны төлбөр;
- b. Талбайн гаднаас олборлон ашиглаж байгаа, ашиглахаар бэлтгэсэн байгалийн түүхий эд;
- c. Гэрээнд заасан талбайн хэмжээнээс хэтэрч, эсхүл заасан талбайгаас өөр талбайгаас олборлосон, ашигласан, ашиглах гэж бэлтгэсэн байгалийн түүхий эд.

**8. Ажил эхлүүлэх, хойшлуулах, түр зогсох****8.1. Ажлыг эхлүүлэх**

Гэрээний 4.7-д заасан нөхцөл бүрдсэний дараа Захиалагчаас Гүйцэтгэгчид ажил эхлүүлэх мэдэгдэл өгнө. Энэхүү мэдэгдэлд заасан хугацаанд Гүйцэтгэгч ажлыг эхлүүлнэ.

Мөн Гэрээний 2.4 (Захиалагчийн санхүүжилт)-т заасны дагуу урьдчилгаа санхүүжилтийг Гүйцэтгэгчид олгож, Гүйцэтгэгч ажил эхлүүлэх бэлтгэлийг бүрэн хангасан байна.

Гүйцэтгэгч ажил эхлүүлэх мэдэгдлийг хүлээн авсан даруй аль болох хурдан хугацаанд ажлыг гүйцэтгэж эхэлнэ.

**8.2. Ажил дуусгах хугацаа**

Гүйцэтгэгч бүх ажлыг болон хэсэг ажил бүрийг Гэрээнд заасан хугацаанд дор дурдсаныг оруулаад хийж дуусгана. Үүнд:

- a. Ажил дууссаны дараах туршилтыг явуулах;
- b. Гэрээний 10.1 (Ажлыг болон ажлын тодорхой хэсгийг хүлээлгэн өгөх)-д заасны дагуу хийгдэх шаардлагатай ажил болон ажлын тодорхой хэсгийг Гэрээнд заасан бүх ажлын хамт дуусгах.

**8.3. Ажлын хуваарь**

Гүйцэтгэгч Гэрээний 8.1 (Ажлыг эхлүүлэх)-д заасны дагуу ажил эхлүүлэх мэдэгдлийг хүлээн авсаны дараа 7 хоногийн дотор, дараагийн хэсэг ажил бүрийг эхлэхээс 5 хоногийн өмнө үе шатны ажлын нарийвчилсан хуваарийг Гэрээний хавсралт 8-д заасан календарчилсан төлөвлөгөөнд нийцүүлэн гаргаж Талууд баталгаажуулна. Ажлын хуваарь тус бүр дараах агуулгыг багтаасан байна. Үүнд:

- a. Инженерийн ажлын зураг, гүйцэтгэгчийн баримт бичиг, худалдан авалт, үйлдвэрлэл, талбай дээр очих, барилга угсралтын ажлыг гүйцэтгэх, туршилт явуулах гэх мэт ажлын үе шат бүрээр хугацааг харуулсан гүйцэтгэхээр төлөвлөж буй ажлуудын дараалал;
- b. Гэрээний 5 дугаар (хүлээн зөвшөөрөгдсөн туслан гүйцэтгэгч) зүйлд заасны дагуу албан ёсоор томилогдсон туслан Гүйцэтгэгч тус бүрээр хийлгэх үе шатны ажлын хуваарь;
- c. Гэрээнд заасан туршилт болон хяналт, шалгалтын хугацаа.

Гэрээнд заасан туршилт болон хяналт, шалгалтын хугацаа, дараалал Дараах зүйлийг багтаасан дагалдах тайлан. Үүнд:

- a. ажлыг гүйцэтгэхэд зөвшөөрөл авахаар төлөвлөж буй Гүйцэтгэгчийн ажлын аргачлал, тодорхойлолт;
- b. ажил гүйцэтгэхэд шаардлагатай Гүйцэтгэгчийн ажилчдын мэргэжлийн төрөл, ангилал, түүнчлэн техник хэрэгслийн төрөл, тоог харуулсан нарийвчилсан мэдээлэл.

Ажлын хуваарийг хүлээн авсанаас хойш 21 хоногийн дотор Инженер нь Гүйцэтгэгчид гэрээг мөрдөх талаар ямар нэгэн мэдэгдлийг өгөөгүй байлаа ч Гүйцэтгэгч өөрийн үүрэг, хариуцлагын хүрээнд ажлын хуваарийн дагуу ажлаа үргэлжлүүлэн гүйцэтгэнэ.

Гүйцэтгэгч нь цаашдын ажлын гүйцэтгэлд сөргөөр нөлөөлөх, Гэрээний үнийг нэмэгдүүлэх, хугацаа алдах болон үүсч бий болох нөхцөл, байдлыг тэр даруй Инженерт мэдэгдэнэ. Инженер нь Гэрээний 13.3 (Өөрчлөх журам)-т заасны дагуу цаашдын нөхцөл байдалд нөлөөлөхийн эсрэг авах тооцоо, саналыг Гүйцэтгэгчээс шаардаж болно.

Хэрэв ажлын хуваарь нь Гэрээнд зааснаас өөр, буруу байгаа, ажлын бодит гүйцэтгэлтэй нийцэхгүй бол Инженер нь ямар ч үед Гүйцэтгэгчид мэдэгдэл өгөх эрхтэй ба Гүйцэтгэгч нь Гэрээний энэ заалтын дагуу шинэчилсэн хуваарийг Инженерт танилцуулна.

**8.4. Ажил дуусах хугацааг сунгах**

Гүйцэтгэгч нь Гэрээний 20.1, 10.1 (Ажил болон ажлын тодорхой хэсгийг хүлээн авах)-д, эсхүл дараах шалтгааны улмаас гэрээт хугацаа хойшлогдохоор бол Захиалагчид нэхэмжлэх гаргах эрхтэй. Үүнд:

- a. Гэрээний 13.3 (Өөрчлөлт хийх журам)-т заасны дагуу ажлыг өөрчлөхийг зөвшөөрсөн байтал ажил дуусах хугацааг тохируулан өөрчлөлт оруулаагүй, эсхүл Гэрээнд заасан ажлын төрлийн тоо хэмжээнд бодит өөрчлөлт гарсан;
- b. Энд дурдагдсан нөхцөлүүдийн дэд заалтын дагуу хугацаа сунгах эрхийг өгсөнөөр хугацаа хойшлогдох шалтгаан болсон;
- c. Байгаль, цаг уурын онцгой үзэгдэл болсон;
- d. Тахал, халдварт буюу голомтот өвчин болон Засгийн газрын хоорондын асуудлаас болж, бараа, материалын дутагдалд орж урьдчилан таамаглах боломжгүй нөхцөл үүссэн;
- e. Захиалагч, Захиалагчийн ажилтан, Захиалагчийн бусад Гүйцэтгэгчдийн шинжтэй, эсхүл эдгээрээс шалтгаалан бэрхшээл үүсч, хугацаа хоцрох болсон;

Хэрэв Гүйцэтгэгч ажлыг дуусах хугацааг сунгах эрхтэй гэж өөрсдөө үзэж байгаа бол Гэрээний 20.1 (Гүйцэтгэгчийн нэхэмжлэх)-д заасны дагуу Инженерт мэдэгдэл өгсөн байна. Гэрээний 20.1-д заасны дагуу хугацааны сунгалт бүрийг тодорхойлохдоо, Инженер нь өмнөх шийдвэрээ хянан үзэж хугацааг нэмж болох ба хугацааны нийт сунгалтыг хасахгүй.

**8.5. Эрх бүхий байгууллагаас болж хугацаа хойшлогдох**

Хэрэв дараах нөхцөл байдал үүсвэл:

- a. эрх бүхий байгууллагын үйл ажиллагаа, тушаал, шийдвэрээс шалтгаалан Гүйцэтгэгчийн ажлыг хойшлуулж, тасалдуулсан;
- b. урьдчилан таамаглах боломжгүй байдлаас болж ажил хойшлогдсон,



ИЛ БОЛСОН

тасарсан.

Дээр дурдсан хугацаа хойшлогдох, тасарсан шалтгааныг Гэрээний 8.4 (Ажил дуусгах хугацааг сунгах)-ийн "б" хэсгийн дагуу хугацаа хойшлогдох шалтгаан гэж үзнэ.

#### 8.6. Ажлын явцын үнэлгээ

Хэрэв,

- a. ажлыг дуусгах хугацаанд гүйцэтгэх ажлын бодит гүйцэтгэл маш удаан, эсхүл
- b. гүйцэтгэл нь Гэрээний 8.3 (Ажлын хуваарь)-т заасны дагуу танилцуулагдах төлөвлөгөөнөөс бага болсон, болох гэж байгаа бол

Гэрээний 8.4 (Ажил дуусгах хугацааг сунгах)-т заасны дагуу бичигдсэн шалтгаанаас бусад тохиолдолд, Инженер нь ажлыг хугацаанд нь багтаах, гүйцэтгэлийг эрчимжүүлэх үүднээс Гэрээний 8.3 (Ажлын хуваарь)-т заасан шинэчилсэн төлөвлөгөөг зөвшөөрөл авахаар санал болгож буй ажлын аргачлал бүхий тайлангийн хамт танилцуулахыг шаардаж болно.

#### 8.7. Хугацаа хоцроосны хохирол нөхөн төлөх

Хэрэв Гүйцэтгэгч нь Гэрээний 8.2 (Ажил дуусгах хугацаа)-т заасны дагуу ажлаа дуусгаагүй бол Гэрээний 2.5 (Захиалагчийн нэхэмжлэх)-д заасны дагуу Захиалагчид учирсан хохирлыг төлнө.

#### 8.8. Ажлыг түр зогсоох

Захиалагчийн зайлшгүй шаардлагын улмаас өгсөн зааварчилгаа болон Гүйцэтгэгчийн хүндэтгэн үзэх шалтгаанаар ажлыг бүхэлд нь буюу хэсэгчлэн түр зогсоож болох ба Талууд түр зогсолт хийх болсон үндэслэл, шалтгааны талаар харилцан мэдэгдэнэ.

Гүйцэтгэгч түр зогсолтын хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлын чанар, ажлыг бүхэлд нь эсхүл тодорхой хэсгээр нь арчлах, элэгдэл, гэмтлээс хамгаалах, материал, техник хэрэгслийн бүрэн бүтэн байдал, аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авч, хамгаалалтын горим тогтооно.

Инженер нь ажлыг түр зогсоох болсон шалтгаанаа Гүйцэтгэгчид мэдэгдсэн байна. Хэрэв, мэдэгдэх болсон шалтгаан нь Гүйцэтгэгчийн хариуцлагаас болсон бол Гэрээний 8.9, 8.10, 8.11 заалтыг мөрдөнө.

#### 8.9. Ажлыг түр зогсоосноос гарах үр дагавар

Хэрэв Гүйцэтгэгч нь Гэрээний 8.8 (Ажлыг түр зогсоох)-д заасны дагуу Инженерийн зааврыг мөрдсөнөөр нэмэлт зардал гарсан, ажлыг хойшлуулахад хүрсэн, ажлаа дахин үргэлжлүүлсэн бол Гүйцэтгэгч нь Гэрээний 20.1 (Гүйцэтгэгчийн нэхэмжлэх)-д заасны дагуу Инженерт мэдэгдэл өгч дараах зүйлийг нэхэмжлэх эрхтэй. Үүнд:

- a. Гэрээний хугацааг сунгах;
- b. үүнтэй холбоотой гарсан зардлыг Гэрээний үнэд оруулах

Энэхүү мэдэгдлийг хүлээн авсаны дараа Инженер нь эдгээр асуудлыг шийдвэрлэх болон зөвшилцөх үүднээс Гэрээний 3.5 дэд заалтын (Шийдвэр) дагуу арга хэмжээ авна.

Хэрэв Гүйцэтгэгчийн буруугаас болж төлөвлөлт, ур чадвар, материал муу байсан, түүнчлэн Гэрээний 8.8 (Ажлыг түр зогсоох)-д заасны дагуу хадгалалт, хамгаалалт буруу хийснээс болсон бол Гүйцэтгэгч нь үүнтэй холбоотой нэмэлт зардал нэхэмжлэх, хугацаа сунгах эрхгүй.

Түр зогсолтын үед Гүйцэтгэгч нь ажлын талбайгаас материал, техник хэрэгслийг Захиалагчийн зөвшөөрөлгүй нүүлгэн шилжүүлэхийн хориглоно.

Гүйцэтгэгчийн алдаатай үйл ажиллагааны улмаас ажлын гүйцэтгэл хангалтгүй гэж үзсэн, ажлыг дахин хийх шаардлага гарсан, ашиглах материал нь элэгдэл, доголдлыг илрүүлж солих, сайжруулах болсноор түр зогсолт хийсэн бол ажил гүйцэтгэлийн хугацааг сунгах, нэмэлт зардал гаргах үүргийг Захиалагч хүлээхгүй, энэ тухай Гүйцэтгэгч шаардах эрхгүй.

#### 8.10. Түр зогсолтын үеийн материалын төлбөр

Хэрэв дараах тохиолдолд ажлын талбай дээр хүргэгдээгүй барилгын материалын үнэлгээгээр түр зогсолт хийсэн өдрөөр Гүйцэтгэгчид төлбөр төлнө.

- a. Ажлын талбай дээр хүргэгдэх барилгын материалыг 28 хоногоос илүү хугацаагаар түр зогсоосон;
- b. Гүйцэтгэгч нь Инженерийн зааварчилгааны дагуу барилгын материалыг Захиалагчийн өмч хөрөнгө гэж тэмдэглэсэн.

Түр зогсолтын хугацаанд Гүйцэтгэгчийн буруутай үйл ажиллагааны улмаас барилгын ажлын чанар болон бараа, материалд элэгдэл, гэмтэл доголдлыг гарсан тохиолдолд сэргээн засах зардлыг Гүйцэтгэгч хариуцна.

#### 8.11. Түр зогсолтын хугацааг сунгах

Хэрэв Гэрээний 8.8 (Ажлыг түр зогсоох)-д заасан ажлын түр зогсолт нь 84 өдрөөс илүү хугацаагаар үргэлжилсэн бол Гүйцэтгэгч Инженерээс ажлыг үргэлжлүүлэх зөвшөөрлийг хүсч болно. Хэрэв Инженер хүсэлтийг хүлээн авсанаас хойш 28 хоногийн дотор зөвшөөрөл өгөхгүй бол Гүйцэтгэгч нь Инженерт мэдэгдэл өгч түр зогсолт нь ажлын тодорхой хэсэгт нөлөөлж байгаагаас Гэрээний 13 (Өөрчлөлт болон тохируулга)-т заасны дагуу шийдвэрлэхийг хүсч болно. Хэрэв түр зогсолт нь ажлын бүхэл хэсэгт нөлөөлж байгаа бол Гүйцэтгэгч нь Гэрээний 16.2 (Гүйцэтгэгчийн зүгээс гэрээг цуцлах)-т заасны дагуу гэрээг цуцлах мэдэгдлийг Инженерт өгч болно.

#### 8.12. Ажлыг үргэлжлүүлэх

Ажлаа үргэлжлүүлэх зөвшөөрөл буюу зааварчилгаа авсны дараа талууд хамтран түр зогсолтын нөлөөнд авсан ажил, материалуудыг шалгаж үзнэ. Гүйцэтгэгч түр зогсолтын хугацаанд элэгдсэн, доголдол гарсан, алдагдалд орсон ажил, материалын төлбөрийг хариуцна.

### 9. Ажлыг дуусгах үеийн туршилтууд

#### 9.1. Гүйцэтгэгчийн үүрэг, хариуцлага

Гэрээний 4.1 (Гүйцэтгэгчийн ерөнхий үүрэг)-д заасны дагуу баримт бичгийг бүрдүүлсэний дараа Гүйцэтгэгч нь Гэрээний 7.4 (Туршилт)-т заасны дагуу ажлыг дуусгах үеийн туршилтуудыг хийж гүйцэтгэнэ.

Гүйцэтгэгч нь ажлыг дуусгах үеийн туршилтыг хийхэд бэлэн болсноос хойш 21 хоногийн дотор Инженерт туршилт хийх мэдэгдлийг өгсөн байна. Инженер зааварчилгаа өгсөн өдрөөс 14 хоногийн дотор ажлыг дуусгах үеийн туршилтыг хийж гүйцэтгэнэ.

Ажлыг дуусгах үеийн туршилтын үр дүнгээс хамааран Инженерийн гаргасан ажлын гүйцэтгэл, бусад үзүүлэлтийн дүгнэлтийг үндэслэн Захиалагч гэрээт ажлыг хүлээн авах зөвшөөрлийг өгнө. Гэрээт ажил, хэсэг ажлын туршилтыг аль болох хурдан хугацаанд явуулсны дараа Гүйцэтгэгч нь эдгээр туршилтуудын үр дүнгийн тайланг Инженерт танилцуулна.

**ИЛ БОЛСОН**

Технологийн хувьд шаардлагагүй ажлын гүйцэтгэлд Инженерийн саналыг үндэслэн энэ зүйлд заасан туршилтыг хийхгүй байж болно.

## 9.2. Хугацаа хоцорч хийгдсэн туршилтууд

Хэрэв ажлыг дуусгах үеийн туршилтууд нь Захиалагчийн буруугаас болж хойшлогдсон бол Гэрээний 7.4 (Туршилт)-ийн 7.4.5, эсхүл Гэрээний 10.3 (Ажил дуусгах үеийн туршилт нөлөөлөх хөндлөнгийн саад)-т заасныг хэрэглэнэ.

Хэрэв туршилтууд нь Гүйцэтгэгчийн буруугаас болж хойшлогдсон бол Инженер нь Гүйцэтгэгчид мэдэгдэл өгч 21 хоногийн дотор туршилт хийхийг шаардаж болно. Гүйцэтгэгч нь Инженерт мэдэгдэл өгөх хугацааг тооцон энэ өдөр эсхүл заасан хугацаанд туршилтыг хийнэ.

Хэрэв Гүйцэтгэгч нь 21 хоногийн дотор ажлыг дуусгах туршилт хийхдээ алдаа гаргасан бол Захиалагчийн ажилтан нь Гүйцэтгэгчийн зардлаар туршилтыг шаардлагын хэмжээнд гүйцэтгэнэ. Энэ тохиолдолд ажлыг дуусгах үеийн туршилтад Гүйцэтгэгчийг биеэр оролцсон гэж үзэх бөгөөд туршилтын үр дүнг зөвшөөрнө.

## 9.3. Туршилтыг дахин хийх

Хэрэв гэрээт Ажил болон Хэсэг ажил нь дуусгах үеийн туршилтад тэнцээгүй бол Гэрээний 7.5 (Ажлыг хүлээн авахаас татгалзах) дахь заалтыг мөрдөх ба Инженер болон Гүйцэтгэгч нь ижил нөхцөл шаардлагын дагуу туршилтыг дахин гүйцэтгэнэ.

## 9.4. Ажлыг дуусгах үеийн туршилт хийгдээгүйн хохирол

Хэрэв гэрээт Ажил болон Хэсэг ажил нь ажлыг дуусгах үеийн туршилтад тэнцээгүй, Гэрээний 9.3 (Туршилтыг дахин хийх)-т заасны дагуу дахин хийгдэхээр бол Инженер дараах эрхтэй байна:

Гэрээний 9.3 (Туршилтыг дахин хийх)-т заасан хүрээнд туршилт хийх давталтын дарааллыг тогтооно.

Хэрэв туршилтаас үүдэлтэй аливаа хохирол нь Захиалагчийг алдагдалд оруулахаар бол, гэрээт ажил болон Хэсэг ажлаас татгалзах бөгөөд энэ тохиолдолд Захиалагч Гэрээний 11.4 (Илэрсэн зөрчил, эвдрэл, гэмтлийг арилгаснаас үүсэх хохирол)-ийн (b) хэсэгт заасны адил арга хэмжээ авна.

Хэрэв Захиалагч хүсвэл ажлыг хүлээн авах гэрчилгээг гаргах

Дээр дурдсан (b) хэсгийн хувьд, Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн бусад бүх үүргийнхээ дагуу хариуцлага хүлээх ба Гэрээний дүнг туршилтаас үүдэлтэй хохирлын дүнгээр Захиалагчийн үнэлгээгээр хасч бууруулна. Гэрээнд энэхүү гарз, хохирлоос үүдэлтэй холбогдох хасалтыг тодорхой заагаагүй бол Захиалагч нь 1/ хоёр тал зөвшөөрч, ажлыг хүлээн авах гэрчилгээг гарахаас өмнө төлбөрийг хийхээр, эсхүл 2/ Гэрээний 2.5 (Захиалагчийн нэхэмжлэх), мөн 3.5 (Шийдвэр)-д заасны дагуу асуудлыг шийдэж, төлбөрийг төлсөн байхаар Гүйцэтгэгчийн төлбөрөөс хасалт хийхийг шаардаж болно.

## 10. Захиалагчийн зүгээс ажлыг хүлээн авах

### 10.1. Ажил болон ажлын тодорхой хэсгийг хүлээн авах

Гэрээний 9.4 (Ажлыг дуусгах үеийн туршилт хийгдээгүйн хохирол)-т зааснаас бусад тохиолдолд

1) Гэрээний 8.2 (Ажил дуусах хугацаа)-т заасан ажлыг багтаагаад Гэрээнд заасан ажлыг бүрэн дуусгасан,

2) ажлыг хүлээн авсан акт гарсан болон энэ заалтын дагуу гарсан гэж үзсэн үед Захиалагч нь гэрээт ажлыг хүлээн авна.

#### 10.2. Урьдчилсан байдлаар ажлыг хүлээн авсан тухай гэрчилгээ

Захиалагч урьдчилсан байдлаар ажил хүлээн авсан байх эцсийн хугацаанд багтаан гүйцэтгэсэн ажлын дүнд 14 (арван дөрөв) хоногийн дотор Гүйцэтгэгч талд урьдчилсан байдлаар хүлээн авсан тухай гэрчилгээ олгоно.

#### 10.3. Урьдчилсан байдлаар хүлээн авсан байх эцсийн хугацааны дараах Гүйцэтгэгчийн хандалт

Ажилтай холбоотой урьдчилсан байдлаар хүлээн авсан байх эцсийн хугацаанаас эхлэн Захиалагчийн зүгээс Гэрээний 11-д заасан алдаа дутагдлыг залруулах шаардлагатай арга хэмжээг авах зөвшөөрөл олгоно.

Ажилтай холбоотой урьдчилсан байдлаар хүлээн авсан байх эцсийн хугацааны дараа ажил гүйцэтгэхдээ Гүйцэтгэгч тал бүх цаг хугацааны туршид (Захиалагч, Захиалагчийн ажилтантай хамтран)

- (a) Ажлын үйл явцыг зөрчлийг багасгах;
- (b) Захиалагч зааврын дагуу гүйцэтгэж дуусаагүй болон засаж сайжруулах ажлыг аль болох богино хугацаанд хийж дуусгах.

#### 10.4. Ажлын үр дүнг эцсийн байдлаар хүлээлгэн өгөх

10.4.1. Гүйцэтгэгч ажлын үр дүнг хүлээлгэн өгөхдөө дараах баримт бичгүүдийг бүрдүүлсэн байна. Үүнд:

- a) тэг тэнхлэг тавьсан акт, түүнийг тавихад гаргасан зай хэмжээний зураглал;
- b) ажлын иж бүрэн зураг, төсөв;
- c) ил, далд ажлын актууд;
- d) гадна шугам сүлжээний гүйцэтгэлийн зураг;
- e) барилга байгууламжийн хийц, бүтээцийн даацын бат бэхийг барилгын ажлын үе шат бүрд лабораторийн шинжилгээ хийлгэж, баталгаажуулсан дүгнэлтүүд;
- f) барилгын ажлын явцад захиалагч, зохиогч, улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын чанар, аюулгүй байдлын талаар гаргасан дүгнэлт;
- g) Захиалагч ба зураг төсвийн болон хяналтын байгууллагаас өгсөн шаардлага, акт, дүгнэлт тэдгээрийн биелэлт;
- h) норм, нормативын баримт бичигт заасан техникийн үзүүлэлт, шаардлагын дагуу гүйцэтгэсэн эсэх.

10.4.2. Энэ зүйлийн 10.4.1-д заасан баримт бичгийн иж бүрдэл бүрэн бус тохиолдолд Захиалагч ажлын үр дүнг хүлээн авахаас татгалзана.

#### 10.5. Ажлыг дуусгах үеийн туршилтад нөлөөлөх хөндлөнгийн саад

Хэрэв Захиалагчаас шалтгаалан ажлыг дуусгах үеийн туршилт 14 хоногоос илүү хугацаагаар саатаж байгаа бол Гүйцэтгэгч нь туршилтыг дуусгахаар төлөвлөж байсан тэр өдөр ажил болон ажлын тодорхой хэсгийг Захиалагчийн зүгээс хүлээн авсан гэж үзнэ.

Энэ тохиолдолд Инженер нь ажлыг хүлээн авсан актыг гаргах ба Гүйцэтгэгч нь баталгаат засварын хугацааг дуусахаас өмнө аль болох хурдан хугацаанд туршилтыг гүйцэтгэнэ. Инженер нь Гэрээний холбогдох заалтын дагуу 14 хоногийн мэдэгдлийн хүрээнд ажлыг дуусгах туршилт дахин хийхийг шаардана.

Хэрэв туршилтыг хийснээр Гэрээний хугацаа хойшлогдож, нэмэлт зардал

гарахаар бол Гүйцэтгэгч нь Инженерт мэдэгдэл өгч Гэрээний 20.1(Гүйцэтгэгчийн нэхэмжлэх)-д заалтын дагуу дараах зүйлийг нэхэмжлэх эрхтэй. Үүнд:

Дээрх шалтгааны улмаас ажил хугацаандаа дуусах боломжгүй болж хугацааг сунгахад хүрсэн бол Гэрээний 8.4 (Ажил дуусгах хугацааг сунгах)-т заасны дагуу гэрээт хугацааг сунгах

Үүнтэй холбоотой тарах ямар нэгэн зардлыг Гэрээний үнэд оруулах

Энэхүү мэдэгдлийг хүлээн авсаны дараа Инженер нь эдгээр асуудлыг шийдвэрлэх болон зөвшилцөх үүднээс Гэрээний 3.5 (Шийдвэр)-т заасны дагуу арга хэмжээ авна.

#### 10.6. Засах шаардлагатай ажлууд

Ажлыг хүлээн авах гэрчилгээнд өөрөөр заагаагүй бол, засах шаардлагатай ажлуудыг дуусгах үүднээс хэсэг ажил болон ажлын ямар нэгэн хэсгийн гэрчилгээгээр эдгээр ажлыг дуусгасан гэж үзэхгүй.

#### 11. Баталгаат засвар

##### 11.1. Хийгдээгүй ажлыг дуусгаж, доголдлыг засах

Гэрээт ажил, хэсэг ажил тус бүр болон Гүйцэтгэгчийн баримт бичиг нь чанарын баталгаат хугацаа дуусах хүртэл, эсхүл энэ хугацааг дууссанаас хойш гомдлын шаардлага гаргах хугацаанд Гэрээнд заасан нөхцөлийн дагуу байх бөгөөд Гүйцэтгэгч нь дараах үүрэгтэй. Үүнд:

А. Ажлыг хүлээн авах гэрчилгээнд дуусгахаар заасан хугацаанд Инженерээс зааварчилсны дагуу хийгдээгүй ажлаа дуусгах;

В. Гэрээт ажил, хэсэг ажлын чанарын баталгаат хугацаанд болон түүнээс өмнө Захиалагчаас мэдэгдсэний дагуу илэрсэн доголдлыг арилгах шаардлагатай бүх ажлыг дуусгах.

Хэрэв доголдол илэрч, түүнийг арилгах ажилллагаа хийх шаардлага гарвал Гүйцэтгэгч тэр даруй Захиалагчид мэдэгдэнэ.

##### 11.2. Илэрсэн доголдлыг засах зардал

Гэрээний 11.1 (Хийгдээгүй ажлыг дуусгаж, доголдлыг засах)-ын (В) заалтад хамаатай бүх ажлыг Гүйцэтгэгч өөрийн зардлаар хариуцан гүйцэтгэх ба мөн дараах шинж чанартай зүйл хамаарна. Үүнд:

Гүйцэтгэгч өөрөө хариуцаж ямар нэгэн зураг хийх;

Гэрээний дагуу бус материал болон хийц;

Гүйцэтгэгч нь бусад ямар нэгэн үүргээ дагаж мөрдөөгүй.

Хэрэв дээрх шинж чанараас бусад шинж чанартай бол Гүйцэтгэгч Захиалагчид мэдэгдэл гаргах ба Гэрээний 13.3 (Өөрчлөлт оруулах журам)-т заасныг мөрдөнө.

##### 11.3. Баталгаат засварын хугацааг сунгах

Хэрэв Гүйцэтгэгчийн буруутай үйлдлээс болж гэрээт ажил болон хэсэг ажилд илэрсэн доголдлын улмаас уг ажлын үр дүнг ашиглаж чадахааргүй болсон тохиолдолд Захиалагч нь Гэрээний 2.5 (Захиалагчийн нэхэмжлэх)-т заасны дагуу эдгээр ажил болон хэсэг ажлын баталгаат засварын хугацааг үндсэн хугацаагаар үргэлжлүүлэн сунгах эрхтэй.

Хэрэв үйлдвэрлэл болон материалын хүргэлт, угсралтын ажил нь Гэрээний 8.8 (Ажлыг түр зогсоох) эсхүл Гэрээний 16.1 (Ажлыг түр зогсоох

Гүйцэтгэгчийн эрх)-т заасны дагуу тур зогсох бол энэ хугацаагаар чанарын баталгаат хугацааг сунгагдсанд тооцно. Гүйцэтгэгч нь баталгаат засварын хугацаа дууссаны дараа илэрсэн аливаа зөрчил, доголдлыг арилгах үүрэг хүлээхгүй байна.

#### 11.4. Илэрсэн зөрчил, эвдрэл, гэмтлийг арилгаснаас үүсэх хохирол

Хэрэв Гүйцэтгэгч нь боломжит хугацаанд аливаа зөрчил, эвдрэл, гэмтлийг арилгахгүй бол ийнхүү арилгах өдрийг Захиалагчаас тогтооно. Гүйцэтгэгчид хүргүүлэх мэдэгдэлд энэхүү өдрийг заасан байна.

Хэрэв гүйцэтгэгч мэдэгдэлд заасан хугацаанд аливаа зөрчил, эвдрэл, гэмтлийг арилгаагүй бол гүйцэтгэгч гэрээний 11.2 (Илэрсэн доголдлыг засан зардал)-д заасны дагуу өөрийн зардлаар ажлын илэрсэн зөрчил, доголдлыг засах ба Захиалагч дараах арга хэмжээг авна. Үүнд:

- a) Захиалагч өөрөө болон хүн хөлслөн тэрхүү ажлыг Гүйцэтгэгчийн зардлаар хийх ба энэ ажилд Гүйцэтгэгч ямар нэгэн хариуцлага хүлээхгүй, түүнчлэн Гүйцэтгэгч нь гэрээний 2.5 (Захиалагчийн нэхэмжлэх)-д заасны дагуу ажлын доголдлыг засахад гарсан зардлыг төлнө.
- b) Гэрээний 3.5 (Шийдвэр)-д заасан хүрээнд Гүйцэтгэгчийн гэрээний дүнгээс хасалт хийхийг шийдэх болон зөвшөөрөхийг Инженерээс шаардана.

Хэрэв илэрсэн зөрчил, эвдрэл, гэмтэл нь гэрээт ажил, ажлын гол хэсгүүдээс илүү их зардал гарч Захиалагчийг алдагдалд оруулахаар бол ажлыг бүхэлд нь эсхүл ашиглаж болохооргүй тэр хэсгийн гэрээг цуцална. Гэрээний хүрээнд ямар нэгэн хохиролгүй байхын тулд Захиалагч нь ажил болон Хэсэг ажилд төлсөн бүх дүн дээр санхүүгийн зардлыг нэмсэн дүнг Гүйцэтгэгчээс эргүүлэн авах бөгөөд талбайг цэвэрлэж, үйлдвэрлэл болон материалыг Гүйцэтгэгчид өгнө.

#### 11.5. Эвдрэл, гэмтэлтэй ажлыг гаргах

Хэрэв Захиалагчийн өгсөн зөвшөөрлийн дагуу Гүйцэтгэгч нь ажлын талбай дээр гарсан эвдрэл, гэмтлийг хурдан засаж чадахгүй бол эвдрэл, гэмтлийг засах зорилгоор тэдгээрийг талбайгаас гаргаж болно.

#### 11.6. Дараагийн туршилтууд

Хэрэв илэрсэн доголдлыг засах ажил нь ажлын гүйцэтгэлд нөлөөлөхөөр бол Инженер нь гэрээнд заасан туршилтыг давтан хийлгэхийг шаардаж болно. Шаардлагыг доголдлыг засаж арилгаснаас хойш 28 хоногийн дотор мэдэгдлээр өгсөн байна. Эдгээр туршилтуудыг гэрээний 11.2 (Илэрсэн доголдлыг засах зардал)-т заасны дагуу хариуцагч талын зардлаар гүйцэтгэхээс бусад тохиолдолд өмнөх туршилттай ижил нөхцөлөөр гүйцэтгэнэ.

#### 11.7. Нэвтрэх эрх

Гүйцэтгэлийн баталгаа гарах хүртэл Гүйцэтгэгч нь Захиалагчийн шаардсан шаардлагад нийцээгүй баталгаа гаргахаас бусад тохиолдолд энэ заалтыг мөрдөх үүднээс ажил болон ажлын талбай руу нэвтрэх эрхтэй байна.

#### 11.8. Гүйцэтгэгчийн хайгуул, шинжилгээ

Хэрэв инженер шаардсан бол Гүйцэтгэгч инженерээс өгсөн зааварчилгааны дагуу ажилд гарсан аливаа эвдрэл, гэмтлийн шалтгааныг тогтоох хайгуул, шинжилгээг хийнэ. Гэрээний 11.2 (Илэрсэн доголдлыг засах зардал)-т заасны дагуу Гүйцэтгэгч доголдыг өөрийн зардлаар арилгахаас бусад тохиолдолд хайгуул, шинжилгээний зардлыг гэрээний дүнд оруулахаар гэрээний 3.5

(Шийдвэр)-д заасны дагуу Инженерээр тодорхойлуулж, зөвшөөрүүлсэн байна.

### 11.9. Гүйцэтгэлийн акт

Инженер нь гэрээгээр хүлээсэн үүргийнхээ дагуу Гүйцэтгэгч ажлыг дуусгасан огноог заасан гүйцэтгэлийн акт гаргахаас өмнө Гүйцэтгэгчийн ажлыг бүрэн дууссан гэж үзэхгүй. Инженер нь баталгаат засварын хугацаа дууссанаас хойш эсхүл Гүйцэтгэгч гарсан доголдлыг бүрэн зассан, ажлыг дуусгах үеийн бүх туршилтуудыг хийсэн, Гүйцэтгэгчийн бүх баримт бичгүүдийг бүрдүүлж дууссанаас хойш 28 хоногийн дотор гүйцэтгэлийн акт гаргана. Гүйцэтгэлийн актын нэг хувийг Захиалагчид гаргасан байна.

Гүйцэтгэлийн акт зөвхөн гэрээт ажлыг хүлээн зөвшөөрснөөр баталгаажуулна.

### 11.10. Үүргээ бүрэн биелүүлээгүй байдал

Гүйцэтгэлийн акт гарсны дараа Гэрээний тал тус бүр цаг тухайд нь биелүүлээгүй гэрээгээр хүлээсэн үүрэг, хариуцлагаа бүрэн биелүүлэх үүрэг үлдэнэ. Гэрээгээр биелүүлээгүй үүрэг хариуцлагын хир хэмжээ, шинж чанарыг тодорхойлох зорилгоор тухайн гэрээг хүчинтэй хэвээр гэж үзнэ.

### 11.11. Талбайг цэвэрлэх

Гүйцэтгэлийн актыг хүлээн авмагц Гүйцэтгэгч нь Гүйцэтгэгчийн талбай дээр үлдсэн техник хэрэгсэл, илүүдэл материал, эвдэрхий зүйл, хог новш болон түр ажлыг талбайгаас зайлуулна.

## 12. Хэмжилт ба үнэлгээ

### 12.1. Хэмжилт хийх ажил

Гэрээний энэ заалтын дагуу төлбөр хийгдэх ажлуудад хэмжилт хийж, үнэлгээ өгнө. Гүйцэтгэгч нь Гэрээний 14.3 (Явц дундын төлбөр авах хүсэлт), 14.7 (Ажил дууссан үеийн тайлан, мэдээ), 14.8 (Эцсийн төлбөр авах хүсэлт)-д тус тус заасны дагуу гаргах өргөдөл, хүсэлт бүрт ажлын тоо, хэмжээ, Гэрээний дагуу хүсэх ёстой нарийвчилсан дүнг харуулсан байна

Инженер нь ямар ч үед дараах үүргийг гүйцэтгэх Гүйцэтгэгчийн төлөөлөгчид ажлын аль нэг хэсгийг хэмжих шаардлагатай тухай мэдэгдлийг өгч болно.

- a) тэр даруй хэмжилт хийх Инженерт туслах зорилгоор хэмжилтэд оролцох эсхүл чадварлаг төлөөлөгчийг явуулах;
- b) Инженерээс хүссэн ямар нэгэн тодорхой тайлаг гаргах.

Хэрэв Гүйцэтгэгч нь хэмжилтэд биеэр оролцох эсхүл өөрийн төлөөлөгчөө явуулаагүй бол Инженерийн хийсэн хэмжилтийг зөв гэж үзэж зөвшөөрнө.

Гэрээнд өөрөөр заагаагүй бол ямар ч нөхцөлд баримт мэдээг тулгуурлан байнга хийгдэж буй ажлын тоо хэмжээг хэмжих бөгөөд үүнийг Инженер гүйцэтгэсэн байна. Гүйцэтгэгч нь хүссэн үедээ Инженерээс гаргасан хэмжилтийг шалгах болон зөвшөөрөх ба зөвшөөрсөн үедээ баримтыг баталгаажуулж гарын үсэг зурсан байна. Хэрэв Гүйцэтгэгч нь хэмжилтэд биеэр оролцоогүй бол хийгдсэн хэмжилтийг зөвшөөрсөн гэж үзнэ.

Хэрэв Гүйцэтгэгч нь хийгдсэн хэмжилтийн дүнг шалгаж үзээд зөвшөөрөөгүй, эсхүл гарын үсэг зураагүй бол тэрхүү хэмжилтийн дүнг алдаатай гэдгийг нотолж Инженерт энэ тухай мэдэгдэл өгсөн байна. Энэхүү мэдэгдлийг хүлээн авсаны дараа Инженер нь баримт мэдээг нягтлан үзэж, баталгаажуулах эсхүл өөрчлөхийн аль нэгэнд нь шийдвэр гаргаж маргаангүй талд төлбөрийг гэрчилж өгнө. Хэрэв Гүйцэтгэгч нь хэмжилтийн дүнг шалгахыг хүссэнээс хойш 4 хоногийн дотор Инженерт мэдэгдэл гаргаагүй бол тэрхүү хэмжилтийн дүнг зөв гэж хүлээн зөвшөөрнө.

ИЛ БОЛСОН

**12.2. Хэмжилт хийх аргачлал**

Гэрээнд өөрөөр заагаагүй бол.

а/ Байнга гүйцэтгэж буй ажлын төрөл тус бүрээр бодит ажлын тоо, хэмжээг нягтлан шалгаж хэмжих;

б/ Хэмжилт хийхдээ Гэрээнд заасан ажлын тоо, хэмжээ болон бусад холбогдох хуваарийг үндэслэл болгох.

**13. Өөрчлөлт болон тохируулга****13.1. Ажилд өөрчлөлт оруулах эрх**

Ажилд орох өөрчлөлтийн талаарх саналыг ажлыг хүлээн авах гүйцэтгэлийн акт гаргах, Гүйцэтгэгчийн зүгээс санал танилцуулах хүсэлт, эсхүл зааварчилгааны аль нэгийг гарахаас өмнө Инженер хүлээн авч болно.

Гүйцэтгэгч нь 1) өөрчлөлтөд шаардлагатай материалыг шуурхай олж чадаагүй, 2) ажлын явц, дараалалд гарах бодит өөрчлөлт үүссэнийг заасан мэдэгдлийг тэр даруй Инженерт өгөөгүйгээс бусад тохиолдолд өөрчлөлтийг өөрөө хариуцна. Энэхүү мэдэгдлийг хүлээн авсан даруйдаа Инженер нь зааварчилгааг хүчингүй болгох, баталгаажуулах, эсхүл өөрчлөх арга хэмжээ авна.

Өөрчлөлт оруулах санал тус бүр нь дараах зүйлийг багтаасан байна.

гэрээт ямар ажлын тоо, хэмжээнд оруулах өөрчлөлт;

ажлын чанар болон бусад шинж чанарт оруулах өөрчлөлт

ажлын ямар төрлийн хэмжилтийн түвшин, байршил, хэмжээнд орсон өөрчлөлт;

Гэрээнд тусгагдаагүй ажил эсэх;

ямар нэгэн нэмэлт ажил, байнгын ажилд шаардлагатай материал, үйлчилгээ болон туршилт, судалгааны ажил;

ажлыг гүйцэтгэх дараалал болон хугацаанд орох өөрчлөлт;

Гүйцэтгэгч нь Инженер зааварчилсан эсхүл өөрчлөлтийг зөвшөөрөх хүртэл ямар нэгэн өөрчлөлт хийж болохгүй.

**13.2. Инженерийн үнэлгээ**

Гүйцэтгэгч нь ямар ч үед 1) ажлыг хурдавчлах, 2) ажлыг гүйцэтгэх, дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагаа явуулах Захиалагчийн зардлыг бууруулах, 3) дуусгасан ажлын үр ашиг, үнэлгээг сайжруулах, 4) Захиалагчид ашигтай байна гэдэг саналыг зөвшөөрүүлэх үүднээс холбогдох саналыг Инженерт бичгээр танилцуулна.

Саналыг Гүйцэтгэгчийн зардлаар бэлтгэх ба Гэрээний 13.3 (Өөрчлөлт болон тохируулга)-т заасан асуудлыг оруулсан байна.

Хэрэв саналыг Захиалагч зөвшөөрсөн бол байнгын ажлын тодорхой хэсгийн зурагт орох өөрчлөлтийг оруулж дараа нь хоёр Тал дараах зүйлийг зөвшөөрсөн байна. Үүнд:

- a. Аль тал тухайн өөрчлөлт орж буй хэсгийн зургийг гаргах;
- b. Гэрээний 4.1 (Гүйцэтгэгчийн ерөнхий үүрэг)-ийн (a), (b) хэсгийг мөрдөх;
- c. Энэхүү өөрчлөлт хийснээр энэ хэсгийн Гэрээний үнэлгээг бууруулах



бол Инженер нь Гэрээний 3.5 (Шийдвэр)-д заасны дагуу холбогдох төлбөрийг Гэрээний үнэд оруулах асуудлыг тодорхойлох эсхүл зөвшөөрөх арга хэмжээ авна. Энэхүү төлбөр нь дараах дүнгийн хоорондох зөрүүний 50% байна.

- (1) үнэлгээнд орох өөрчлөлт нь Гэрээний 13.8 (Зардлын өөрчлөлтийг тохируулах), Гэрээний болон 13.7 (Хууль, эрх зүйн орчинд орох өөрчлөлтийг тохируулах)-д заасан хүрээнд хийгдэх тохируулгыг оруулахгүйгээр гарсан өөрчлөлтийн үр дүнд байх;
- (2) Өөрчлөгдсөн ажлын үнэлгээнд орох өөрчлөлтөд үйл ажиллагааны бүтээмж, чанарт орсон ямар нэгэн өөрчлөлтийг харгалзан үзэх;

Гэхдээ хэрэв 1)-д заасан дүн нь 2)-т заасан дүнгээс бага бол ямар нэгэн төлбөр байхгүй.

### 13.3. Өөрчлөлт хийх журам

Хэрэв Инженер нь өөрчлөлт хийхийг зааварчлахаас өмнө санал ирүүлэхийг хүсвэл Гүйцэтгэгч нь аль болох хурдан хугацаанд бичгээр хариу өгөх ба яагаад дагаж мөрдөхгүй (хэрэв мөрдөхгүй байх тохиолдол байгаа бол) шалтгааныг заах ба дараах зүйлийг танилцуулна. Үүнд:

- a. Гүйцэтгэхээр санал болгож буй ажлын тодорхойлолт болон гүйцэтгэх төлөвлөгөө;
- b. Гэрээний 8.3 (Ажлын хуваарь)-т заасны дагуу танилцуулах төлөвлөгөө болон ажлыг дуусгах хугацаанд оруулах шаардлагатай өөрчлөлтүүдийн талаарх Гүйцэтгэгчийн санал;
- c. Өөрчлөлтийн үнэлгээнд зориулсан Гүйцэтгэгчийн санал;

Инженер нь Гэрээний 13.2 (Инженерийн үнэлгээ)-т заасны дагуу танилцуулагдах саналыг хүлээн авсаны дараа аль болох хурдан хугацаанд саналыг зөвшөөрсөн эс зөвшөөрсөн хариугаа өгнө. Гүйцэтгэгч нь Инженерийн хариуг хүлээх хооронд ямар нэгэн ажлыг хойшлуулж болохгүй.

Зардлыг тооцоход шаардлагатай тайлан, мэдээг багтаасан өөрчлөлт хийх заавар бүрийг Инженер нь Гүйцэтгэгчийн зүгээс үүнийг батлах этгээдэд гаргаж өгнө.

Энэ заалтын дагуу Инженер нь өөрчлөлт тус бүрийг зааварчилж зөвшөөрөхөөс бусад тохиолдолд Гэрээний 12 (Хэмжилт ба үнэлгээ)-т зааснаар үнэлнэ.

### 13.4. Хэрэглэж болох валютаар хийгдэх төлбөр

Төлбөрийг төгрөгөөр хийнэ.

### 13.5. Түр тооцсон дүн

Түр тооцсон дүн тус бүрийг Инженерийн зааварчилгааны дагуу бүхэлд нь эсхүл хэсэгчлэн ашиглах ба гэрээний үнийг тохируулна. Гүйцэтгэгчид төлөх нийт дүнд түр тооцсон дүнд хамаатай зөвхөн ажил, ханган нийлүүлэлт болон үйлчилгээнд зориулсан дүнг оруулах ба үүнийг Инженерээс зааварчилсан байна. Түр тооцсон дүн тус бүрийн хувьд, Инженер нь дараах зүйлийг зааварчилж болно.

- a. Гэрээний 13.3 (Өөрчлөлт хийх журам)-т заасны дагуу үнэлэгдсэн болон материал, үйлчилгээг багтаасан Гүйцэтгэгчийн гүйцэтгэх ажил;
- b. Гэрээний 5 дугаар зүйл (Албан ёсоор томилогдсон туслан гүйцэтгэгч)-д заасан туслан Гүйцэтгэгчээс худалдан авах Гүйцэтгэгчийн материал,

**ИЛ БОЛСОН**

үйчилгээ болон Гэрээний үнэд оруулах дараах дүн. Үүнд:

- (1) Гүйцэтгэгчийн төлөх бодит дүн;
- (2) Хуваарьт заасан холбогдох хувь хэмжээг ашиглан эдгээр бодит дүнгийн хувиар тооцсон нэмэлт зардал болон ашгийн дүн. Хэрэв ямар нэгэн хувь хэмжээ байхгүй бол Гэрээний нөхцөлд заасан хувь хэмжээг ашиглана.

Инженерээс шаардсан үед Гүйцэтгэгч нь үндэслэл, нэхэмжлэх, батлан даалт, холбогдох тооцоо болон хүлээн авсан баримтыг гаргаж өгнө.

**13.6. Ажил-өдөр**

Ажил-өдрийн хуваарьт орсон ямар нэгэн төрөлд төлбөр хийх шаардлагагүй гэснээс бусад тохиолдолд Гүйцэтгэгч нь урд өдөр нь гүйцэтгэх ажилд ашигласан дараах зүйлийг багтаасан холбогдох баримт бичгийн хуулбарыг өдөр бүр Инженерт хүргүүлнэ. Үүнд:

- (а) Гүйцэтгэгчийн ажилтны нэр, мэргэжил, ажилласан хугацаа;
- (б) Гүйцэтгэгчийн түр ажил, техник хэрэгслийн тодорхойлолт, төрөл, ажилласан хугацаа;
- (в) Ашиглагдах материалын тоо, хэмжээ, төрөл;

Хэрэв Инженер нь зөв гэж үзсэн, зөвшөөрсөн, гарын үсэг зурсан бол баримт бичиг тус бүрийн нэг хувийг Гүйцэтгэгчид буцааж өгнө. Дараа нь Гүйцэтгэгч Гэрээний 14.3 (*Явц дундын төлбөр авах, хүсэлт*)-д заасны дагуу дараагийн баримт бичигт оруулахаас өмнө эдгээр зүйлүүдийн үнэтэй холбоотой баримт бичгийг Инженерт танилцуулсан байна.

**13.7. Хууль, эрх зүйн орчинд орох өөрчлөлтийг тохируулах**

Үндсэн хугацаанаас хойш хуульд өөрчлөлт орсоноос болж зардал буурах, өсөхийг харгалзан үзэж Гэрээний үнийг тохируулах, эсхүл Гэрээнд заасан Гүйцэтгэгчийн үүрэгт нөлөөлөхөөр бол эрх зүйн орчинд өөрчлөлт оруулах ба шинэ эсхүл хүчингүй болсон, өөрчлөлт орсон хуулийн танилцуулга, тэрхүү хуулийн албан ёсны орчуулгыг холбогдох баримт бичигт хавсаргана.

Хэрэв үндсэн хугацаанаас хойш хуульд эдгээр өөрчлөлт орсоноос болж нэмэлт зардал гарч эсхүл тарах гэж байгаа, гэрээт ажил хугацаа алдахад хүрч Гүйцэтгэгч эрсдэлд орвол Инженерт мэдэгдэл өгч Гэрээний 20.1 (*Гүйцэтгэгчийн нэхэмжлэл*) -д заасны дагуу дараах зүйлийг нэхэмжлэх эрхтэй. Үүнд:

- a. дээрх шалтгааны улмаас ажил хугацаандаа дуусах боломжгүй болж хугацааг сунгахад хүрсэн бол Гэрээний 8.4 (*Ажил дуусах хугацааг сунгах*)-т заасны дагуу гэрээт хугацааг сунгах;
- b. үүнтэй холбоотой гарах нэмэлт зардлыг Гэрээний үнэд багтаах (үүнд түр зогсолттой холбоотой аливаа зардал орохгүй);
- c. энэхүү мэдэгдлийг хүлээн авсаны дараа Инженер нь эдгээр асуудлыг шийдвэрлэх болон зөвшилцөх үүднээс Гэрээний 3.5 (*Шийдвэр*)-д заасны дагуу арга хэмжээ авна.

Урьд нь болсоныг үл тооцон хэрэв өмнө нь гарсан хугацааг сунгах шийдвэрээр хэдийнээ хугацаа хоцорсон, эсхүл үүнтэй холбоотой зардлыг тус тусад нь төлөөгүй, түүнчлэн Гэрээний 13.8 (*Зардлын өөрчлөлтийг тохируулах*)-д заасан нөхцөлийн дагуу тохируулгын өгөгдлийн хүснэгтэд орсон өгөгдлийн индексг харгалзан үзсэнтэй ижил арга хэмжээг хэдийнээ авсан бол Гүйцэтгэгч хугацааг сунгах эрхгүй.

**13.8. Зардлын өөрчлөлтийг тохируулах****ИЛ БОЛСОН**

Энэ заалтад “тохируулгын өгөгдлийн хүснэгт” гэдгийг төлбөрийн хуваарьт дотоод, гадаадын валютаар илэрхийлсэн тохируулгын өгөгдлийн бөглөгдсөн хүснэгтийг хэлнэ. Хэрэв тийм тохируулгын өгөгдлийн хүснэгт байхгүй бол энэ заалтыг мөрдөхгүй.

Талууд тохируулгын өгөгдлийн хүснэгт хэрэглэхгүй.

**14. Гэрээний үнэ, төлбөр****14.1. Гэрээний үнэ**

- 14.1.1. Гүйцэтгэгчийн Гэрээний дагуу хийж гүйцэтгэтгэсэн ажлын нийт хөлс (цаашид “Гэрээний үнэ” гэх) нь Гэрээний хавсралт 10 (Ажлын төсөвт өртгийн товчоо)-т заасан нийт хяналтын төсөвт үнийн нийлбэр дүнгээр тодорхойлогдоно.

Гэрээний үнэд Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 414 км орчим төмөр замын шугамын доод бүтцийн газар, шороо (далан) болон хоолойн ажлыг нийт уртаар нь Ажлын техникийн даалгаварт заасны дагуу зохих ёсоор хийж гүйцэтгэн Захиалагчид бүрэн хүлээлгэн өгөхөд шаардагдах бүх бараа, ажил, үйлчилгээ, холбогдон гарах бүх зардал, татвар, хураамж багтсан. Үүнд: гүйцэтгэлийн зураг төсөл, гүйцэтгэлийн тайлан, судалгаа, бүх төрлийн техник хэрэгсэл, тэдгээрийн ашиглалтын зардал, удирдлагын болон үйл ажиллагааны зардал, цалин хөлс, гүйцэтгэгчийн болон захиалагчийн хяналтын зардал, бараа материалын зардал, тээврийн зардал, ажлын гүйцэтгэлийн болон лабораторийн туршилт, байгаль орчны нөхөн сэргээлт, шинжилгээний зардал, түр хугацааны ажил, талбайд нэвтрэх зам, агуулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагааны зардал, түр зогсолт, баталгаат хугацааны зардал, ажилчдын хээрийн нэмэгдэл, ажиллагсдын болон техник хэрэгслийн даатгал, түрээсийн болон магадлашгүй ажлын зардал, нүүлгэн шилжүүлэх зардал, хамгаалалтын мэдэгдэл зарласан үеийн хамгаалалтыг сайжруулах, зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл, хяналт шалгалтын төлбөр, татвар, хураамж, шимтгэл, нийтлэг эрсдлийг бүхэлд нь тооцож хуульд заасан төлбөр, хариуцлага болон үүрэг зэрэг шууд нэрлэн заасан болон нэрлээгүй нийт өртгийг багтаан ойлгоно.

- 14.1.2. Төмөр замын шугамын доод бүтцийн эхний 10 км барилгын ажлын төсөвт үнэ 6,703,999,917.0 (зургаан тэрбум долоон зуун гурван сая есөн зуун ерэн есөн мянга есөн зуун арван долоо) төгрөг байна.
- 14.1.3. Захиалагч нь хоолойн ажлын зураг, төсвийг бусдаар гүйцэтгүүлэх бөгөөд магадлагдсан ажлын зураг, төсвийн дагуу Гүйцэтгэгчээр ажлыг гүйцэтгүүлнэ.
- 14.1.4. Захиалагч нь Гүйцэтгэгчийн ирүүлсэн ажлын гүйцэтгэлд үндэслэн Гэрээнд заасан нөхцөлөөр явцын төлбөрийг төлнө. Гэрээний үнийг зөвхөн Ажлын төсөвт өртгийн товчоонд заасан агуулгын хүрээнд Гэрээний 13.7 ба 13.8-д заасан үндэслэлээр өөрчилж болно.
- 14.1.5. Түүнчлэн Гэрээнд заасан нөхцөл ёсоор харилцан суутгах болон бусад төлбөр тооцоог суутгах, түр хойшлуулах зэрэг арга хэмжээг авч болох бөгөөд уг харилцааг Гэрээний хавсралт-11 (Ажлын гүйцэтгэлийг санхүүжүүлэх нөхцөл)-д нарийвчлан журамлана.

**14.2. Урьдчилгаа төлбөр**

Захиалагч нь Гүйцэтгэгчид дэмжлэг үзүүлэх зорилгоор дор дурдсан зориулалтаар хүүгүй, зээл хэлбэрээр Урьдчилгаа төлбөр олгоно. Үүнд:

- a) Барилгын ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай техник хэрэгслийг худалдан авах, эсхүл түрээс, санхүүгийн түрээсээр ашиглахад;
- b) Барилгын ажлыг эхлүүлэхэд шаардагдах бусад бэлтгэл ажлыг хангах.

**ИЛ БОЛСОН**

Гэрээ байгуулагдахаас өмнө буюу Талуудын хооронд 2019 оны 05 дугаар сарын 16-ны өдөр байгуулсан Төслийн барилгын ажлын урьдчилгаа санхүүжилт олгох гэрээний дагуу олгосон 8,900,000.0 төгрөгийг урьдчилгаа төлбөрт оруулан тооцно.

Гүйцэтгэгч нь явц дундын төлбөрөөс хувь тэнцүү хэмжээгээр суутгуулах замаар урьдчилгаа төлбөрийг Захиалагчид эргүүлэн төлнө. Гэрээний нийт үнийн 80 хувь төлөгдөж дуусахаас өмнө урьдчилгаа төлбөр бүрэн төлөгдсөн байх ёстой. Сар бүрийн гүйцэтгэлийн төлбөрийн 15 хувиар урьдчилгаа төлбөрийн суутгалыг тооцно.

Барилгын ажлын явц дунд урьдчилгаа төлбөр олгохгүй.

Хэрэв урьдчилгаа төлбөр гэрээт ажлыг бүрэн хүлээн авсан тухай Гэрээнд заасан баримт үйлдэгдэхээс өмнө, эсхүл Гэрээний 15 дугаар зүйл (Захиалагч гэрээг цуцлах үндэслэл), 16 дугаар зүйл (Гүйцэтгэгч гэрээг түр зогсоох, цуцлах), 19 дүгээр зүйл (Давагдашгүй хүчин зүйл)-д заасны дагуу гэрээ цуцлагдах буюу дуусгавар болгохоос өмнө эргэн төлөгдөөгүй тохиолдолд ийнхүү төлөгдөөгүй урьдчилгаа төлбөрийн үлдэгдэл нь Гүйцэтгэгчээс Захиалагчид төлөх ёстой төлбөрт тооцогдоно.

#### 14.3. Явц дундын төлбөр авах хүсэлт

Гүйцэтгэгч нь Гэрээний 4.20 (Ажлын явцын тайлан)-д заасны дагуу зөвшөөрөгдсөн маягтын дагуу үйлдсэн явц дундын төлбөрийн хүсэлтийг ажлын холбогдох тайланг багтаасан анхан шатны баримтуудын хамт сар дууссаны дараа тогтоосон хугацааны дотор тухай бүр Захиалагчид хүргүүлнэ.

Энэ хэсэгт дурдсан хүсэлтэд дараах зүйлийг дор дурдсан дарааллаар оруулсан байна.

- (a) Ажлын гүйцэтгэлийн сарын тайлан, холбогдох баримт бичиг, ажлын гүйцэтгэлд төлөгдөх үнэ, холбогдох баримт бичгүүдэд оруулсан өөрчлөлт буюу тохиргоо;
- (b) Гэрээний 13.7 (Хууль, эрх зүйн орчинд оруулах өөрчлөлтийг тохируулах), 13.8 (Зардлын өөрчлөлтийг тохируулах)-д заасны дагуу нэмэгдэх болон хасагдах дүн;
- (c) Гэрээний 14.2 (Урьдчилгаа төлбөр)-т заасны дагуу урьдчилгаа төлбөрийн суутгасан дүн;
- (d) Гэрээний 14.6 (Барьцаа хөрөнгө, түүнийг чөлөөлөх)-д заасны дагуу барьцаа хөрөнгөд суутгасан дүн;
- (e) Гэрээний 14.5 (Төлбөр төлөх хугацаа)-д заасны дагуу дараа сарын төлөвлөгөөт ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай барилгын материал (хайрцган ба дугуй хэлбэрийн хоолой гэх мэт)-ыг худалдан авах нэмэлт зардлын дүн;
- (f) холбогдох орон нутгийн байгаль орчин хариуцсан мэргэжилтнээр баталгаажуулсан тухайн сарын ус ашиглалтын тайлан, мэдээ;
- (g) Гэрээний 20 (Нэхэмжлэл, маргаан болон шүүхийн ажиллагаа)-д заасан бусад нэмэгдэх буюу хасагдах дүн;

өмнөх явц дундын төлбөрөөр төлөгдсөн хасагдах дүн.

#### 14.4. Явц дундын төлбөр төлөх

Захиалагч явц дундын төлбөрийн хүсэлтийг хүлээн авсаны дараа арван дөрвөн (14) хоногийн дотор түүнийг хянан баталгаажуулж, уг хүсэлтийг хүлээн

зөвшөөрч байгаа эсэхийг Гүйцэтгэгчид бичгээр мэдэгдэнэ. Дор дурдсан нөхцөл байдал тогтоогдвол:

- (a) Гүйцэтгэгчийн хийсэн ажил, бэлтгэн нийлүүлсэн аливаа зүйл нь Гэрээнд нийцээгүй, ажлын зөрчил, доголдлыг илэрсэн бөгөөд түүнийг арилгаагүй тохиолдолд засч залруулах, орлуулж солих арга хэмжээг авч дуусах хүртэл эдгээр арга хэмжээтэй дүйцэх хэмжээний зардлыг;
- (b) Гүйцэтгэгч нь Гэрээгээр хүлээсэн ажил, үүргээ бүхэлд нь буюу хэсэгчлэн биелүүлж чадаагүй бол ажил, үүргийг зохих ёсоор биелүүлж дуустал холбогдох зардал, үнийг тус тус суутгахаар холбогдох тооцооллыг хийж мэдэгдэлд дурьдана.

Талууд тохиролцсон нь:

- (a) Энэхүү 14 дүгээр зүйлд шаардсан анхан шатны баримт бичиг байхгүй, бүрэн бус, эсхүл үнэн зөв болох нь эргэлзээтэй бөгөөд холбогдох баримтаар нотлогдоогүй төлбөрийн хүсэлтийг Захиалагч хангалтгүй гэх үндэслэлээр буцааж, Гүйцэтгэгчийн зүгээс алдааг залруулсан үндэслэл бүхий хүсэлтийг дахин ирүүлэх хүртэл баталгаажуулалтыг түдгэлзүүлж, төлбөр төлөхийг хойшлуулах эрхтэй.
- (b) Захиалагч нь зөвхөн Гэрээнд заасны дагуу зохих ёсоор хянан баталгаажигдсан ажлын гүйцэтгэлийн төлбөрийг төлнө.

Захиалагч нь Гэрээний төлбөрөөс энэ Гэрээнд заасны дагуу урьдчилгаа төлбөр, барьцаа хөрөнгийг суутгасан дүнгээр төлнө.

Гэрээний үнэ, төсөв, Талуудын хооронд хийгдэх гүйлгээ зөвхөн төгрөгөөр илэрхийлэгдэнэ.

Захиалагч нь ямар ч төлбөрийг ашиглаж өмнө тооцсон байсан аливаа дүнг зохих ёсоор гүйцэтгэх, гүйцэтгүүлэхийн тулд залруулга, өөрчлөлт шинэчлэлт хийж болно. Ийнхүү гүйцэтгэсэн төлбөр нь Захиалагчийн зүгээс хүлээн зөвшөөрч, баталж, зөвшөөрч, шаардлага хангасан гэж үзсэнд тооцогдохгүй бөгөөд мөн Гүйцэтгэгч нь Гэрээний дагуу аливаа үүрэг хариуцлага, эсхүл аливаа зураг төсөл, ажил, материалаа гүйцэтгэсэн гэж үзэх баталгаа нотолгоо болохгүй.

#### 14.5. Төлбөр төлөх хугацаа

Захиалагч нь явц дундын болон эцсийн төлбөрийн хүсэлтийг хүлээн зөвшөөрсөн гүйцэтгэлийн актыг Гүйцэтгэгчид хүргүүлсэн өдрөөс хойш 28 (хорин найм) хоногийн дотор төлнө.

энэ хэсэгт заасан сүүлчийн өдөр амралтын өдөр таарсан бол төлбөр төлөх сүүлчийн хоногийг ажлын дараагийн өдөрт шилжүүлэн тооцно.

#### 14.6. Барьцаа хөрөнгө, түүнийг чөлөөлөх

Барьцаа хөрөнгө Гэрээний үнийн дүнгийн 5 хувьтай тэнцүү хэмжээтэй байх бөгөөд Захиалагч нь ажлын гүйцэтгэлийн төлбөр бүрээс энэ хувь хэмжээгээр суутган үлдээнэ.

Гэрээт ажил бүрэн дууссан тухай Гүйцэтгэгчийн мэдэгдлийг үндэслэн энэ хэсэгт заасны дагуу суутгасан үнийн дүнгийн 50 хувийг Гүйцэтгэгчид төлөх бөгөөд үлдсэн хэсгийг чанарын баталгаат хугацаа дууссаны дараа тэр хугацаанд гарсан бүх зөрчил, гологдлыг Гүйцэтгэгч арилгасан тухай Захиалагчийн томилсон Инженерийн мэдэгдлийг үндэслэн төлнө.

Хэрэв гүйцэтгэх аливаа ажил үлдсэн тохиолдолд Захиалагч нь тухайн ажлыг гүйцэтгэх хүртэл ажилд хамааралтай тооцсон төлбөрийг саатуулах эрхтэй.

**14.7. Ажил дууссан үеийн тайлан, мэдээ**

Гэрээний 10 дугаар зүйлд заасны дагуу нийт ажлын гүйцэтгэлийг хянан баталгаажуулсан гүйцэтгэлийн акт үйлдсэн өдрөөс хойш 84 (наян дөрөв) хоногийн дотор Гүйцэтгэгч энэ зүйлийн 14.3-т заасан явц дундын төлбөрийн хүсэлтийн дагуу доорх тооцоог харуулсан анхан шатны баримт бичгүүдтэй хамт ажил дуусгасан тухай мэдэгдлийн гурван хэвлэмэл хувь, нэг электрон хувийг Захиалагчд илгээнэ.

- (a) Гэрээний дагуух ажлын гүйцэтгэлийн үнийн дүн;
- (b) Захиалагчаас Гүйцэтгэгчид төлөх ёстой үнийн дүн;
- (c) Гүйцэтгэгчийн зүгээс Захиалагчийг Гэрээнд заасны дагуу төлөх ёстой гэж тооцсон бусад төлбөрийн дүн. Тооцоолсон дүнгүүдийг Ажил дуусгасан тухай мэдэгдэлд тус бүрээр харуулна.

**14.8. Эцсийн төлбөр авах хүсэлт**

Гүйцэтгэгч нь Ажлын гүйцэтгэлийг хүлээлцсэн баримт бичгийг хүлээн авсан өдрөөс хойш 28 (хорин найм) хоногийн дотор Захиалагчаас баталсан маягтын дагуу эцсийн төлбөр авах хүсэлтийг 3 хувь үйлдэж Захиалагчид бичгээр ирүүлнэ.

- (a) Гэрээний дагуу хийсэн бүх ажлын үнэлгээ,
- (b) Гэрээний дагуу, Захиалагчаас авах ёстой гэж үзсэн бусад тооцоо.

Захиалагч эцсийн төлбөр авах хүсэлтийн аль нэг хэсгийг хүлээн зөвшөөрөхгүй, баталгаажуулах үндэслэлгүй гэж үзсэн бол Гүйцэтгэгч нь Захиалагчийн нэмэлтээр шаардсан үндэслэл бүхий баримт, мэдээллийг ийнхүү шаардсан өдрөөс хойш 28 хоногийн дотор танилцуулах бөгөөд хоёр тал харилцан хүлээн зөвшөөрсөн өөрчлөлтийг төлбөр хүлээн авах хүсэлтэд оруулах буюу Гүйцэтгэгч нь ийнхүү өөрчлөлт оруулсан байдлаар эцсийн төлбөр авах хүсэлтийг дахин гаргана. Энэхүү тохиролцсон мэдэгдлийг Гэрээнд заасан "Эцсийн мэдэгдэл" гэж үзэх бөгөөд Захиалагч нь хүлээн авсан даруй Эцсийн төлбөрийн баталгааг гаргана.

Талууд Гүйцэтгэгчийн анх ирүүлсэн эцсийн төлбөр авах хүсэлт буюу мэдэгдлийг Захиалагчид ирүүлсэн өдрөөс хойш 45 (дөчин тав) хоногийн дотор тохиролцож чадаагүй бол Захиалагч нь энэ зүйлийн 14.5-д заасны дагуу эцсийн төлбөр авах хүсэлтийн зөвшөөрсөн хэсгийн дүнгээр төлбөрийг төлөх бөгөөд маргаантай асуудлыг Гэрээний 20 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.

Маргааныг шийдвэрлэсний дараа Гүйцэтгэгч нь Эцсийн мэдэгдлийг бэлтгэж, Захиалагчид илгээх бөгөөд үүний дараа Захиалагч нь Эцсийн төлбөрийн баталгааг нэн даруй гаргана.

**14.9. Эцсийн төлбөр**

Энэ зүйлийн 14.5-д заасны дагуу Захиалагчийн суутган тооцох суутгалууд, өмнө төлөгдсөн нийт төлбөрийг хасч баталгаажуулсан үлдэгдэл дүнгээр Гүйцэтгэгчид эцсийн төлбөрийг төлнө.

**14.10. Захиалагчийн хариуцлагын хязгаарлалт**

Захиалагч нь ажлын гүйцэтгэл, эсхүл Гэрээний хэрэгжилттэй холбоотой аливаа асуудлаар Гүйцэтгэгчийн өмнө хариуцлага хүлээхгүй. Гэхдээ энэ талаар Гүйцэтгэгч нь дараах мэдэгдлүүдэд тусгайлан хариуцлагын төлбөрийг тусгаж оруулсан тохиолдолд хариуцлага хүлээнэ.

- (a) Эцсийн мэдэгдэлд;

(b) Энэ зүйлийн 14.8-д заасан ажил дуусгасан тухай мэдэгдэл.

Энэхүү заалт нь Захиалагч хууран мэхэлсэн, үүргээ биелүүлэхээс санаатай зайлсхийсэн илтэд буруутай, гэмт хэргийн шинжтэй хууль бус үйлдэл, эс үйлдэхүй гаргасны улмаас Гүйцэтгэгчид учруулсан хохирлыг барагдуулах үүрэг хариуцлагаас түүнийг чөлөөлөх үндэслэл болохгүй.

## 15. Захиалагчийн зүгээс гэрээг цуцлах

### 15.1. Зөрчил, доголдлыг засах

Хэрэв Гүйцэтгэгч нь Гэрээний дагуу хүлээсэн ажил, үүргээ биелүүлээгүй, зөрчсөн, алдаа, дутагдал гаргасан, нуун дарагдуулсан, хууран мэхэлсэн болон зөрчил, дутагдлыг засах хугацааг хэтрүүлсэн тохиолдолд Захиалагч, түүний төлөөлөгч, инженер нь Гүйцэтгэгчид мэдэгдэл өгч гаргасан зөрчил, доголдлыг тогтоосон хугацаанд арилгах, засч залруулах, үүргээ биелүүлэхийг шаардана.

Гүйцэтгэгч шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд Захиалагчийн санаачилгаар Гэрээг цуцлах ба өөрт болон бусад этгээдэд учирсан хохирлоо нөхөн төлүүлэх эрхтэй.

### 15.2. Захиалагчийн зүгээс гэрээг цуцлах

Хэрэв Гүйцэтгэгч нь дор дурдсан нөхцөл байдлыг үүсгэсэн бол Захиалагч гэрээг цуцлах эрхтэй. Үүнд:

- (a) Гэрээний 15.1 (Зөрчил, доголдлыг засах)-д заасны дагуу мэдэгдэл авч доголдлыг арилгаагүй;
- (b) Гэрээнд заасан ажил, үүргийгүргэлжлүүлэн гүйцэтгэхгүй буюу гүйцэтгэхээс татгалзаж байгаага бичгээр илэрхийлсэн;
- (c) Тодорхой шалтгаангүйгээр дор дурдсаныг биелүүлээгүй:
  - (i) Гэрээний 8 (Ажил эхлүүлэх, хойшлуулах, түр зогсоох) дугаар зүйлд заасны дагуу ажлаа гүйцэтгэхийг;
  - (ii) Гэрээний 7.6 (Засаж залруулах ажил), 7.5 (Ажлыг хүлээн авахаас татгалзах)-д заасны дагуу мэдэгдлийг хүлээн авсанаас хойш 28 хоногийн дотор дагаж мөрдөх;
  - (iii) зохих зөвшөөрөлгүйгээр туслан Гүйцэтгэгчээр бүх ажлаа гүйцэтгүүлсэн буюу гэрээг хэрэгжүүлсэн;
  - (iv) санхүүгийн чадавхгүй болж дампуурсан, зээлдүүлэгчтэй нэгдмэл сонирхолтой болсон, хүлээн авагч тал нь бизнесийн үйл ажиллагааг явуулж байгаа, зээлдүүлэгчийн ашгийн төлөө үйлчилж байгаа, холбогдох хуулийн дагуу шийдвэр гарсан болон гарах гэж байгаа.

Дараах зорилгоор хэн нэгэнд шан харамж, урамшуулал хэлбэрээр авлига, хээл хахууль, бэлэг, үнэт зүйл өгсөн, өгөхөөр завдсан, авсан, авахаар завдсан. Үүнд:

- (i) Гэрээтэй холбоотой ямар нэгэн хууль бус зүйлийг хийлгэх зорилгоор;
- (ii) Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хэн нэгэнд давуу байдал олгохоор найр тавьсан, өөрт ашиг хонжоо, ашигтай байдал бий болгох зорилгоор.

Эсхүл Гүйцэтгэгчийн хэн нэгэн ажилтан, төлөөлөгч болон туслан Гүйцэтгэгчийн ажилтан дээр дурдсан (e)-д заасан шан харамж, урамшуулалыг хэн нэгэнд шууд болон шууд бусаар өгсөн, өгөхөөр завдсан, авсан, авахыг завдсан. Гэхдээ хууль ёсны урамшуулал, шан харамж нь гэрээг цуцлах үндэслэл болохгүй.

Хэрэв дээр дурдсан нөхцөл байдлаас аль нэг нь үүссэн бол Захиалагч нь Гүйцэтгэгчид мэдэгдэл өгч 14 хоногийн дараа гэрээг цуцалж, Гүйцэтгэгчийг ажлын талбайгаас гаргана.

Гэрээг цуцлах тухай Захиалагчийн санал нь Гэрээний дагуу хүлээсэн Захиалагчийн бусад эрх, мэдлийн хэмжээнд урьдчилан төлөвлөсөн байж болохгүй.

Гэрээг цуцалсны дараа, Гүйцэтгэгч нь ажлын талбайг чөлөөлж, шаардлагатай бараа, материал, Гүйцэтгэгчийн бүх баримт бичиг, өөрийн боловсруулсан зураг төслийн бусад баримт бичгийг Инженерт хүргүүлнэ. Гүйцэтгэгч нь 1) туслан гүйцэтгэгчийн гэрээг шилжүүлэх, 2) ажлыг гүйцэтгэхэд холбогдуулан аюулгүй байдал, өмч хөрөнгө, байгаль орчин, эрүүл ахуйг хамгаалахтай холбоотой мэдэгдэлд дурдсан зааварчилгааг мөрдөнө.

Гэрээг цуцалсны дараа, Захиалагч нь ажлыг дуусгах болон хэн нэгэн этгээдээр ажлыг гүйцээж хийлгэх арга хэмжээ авна. Захиалагч болон бусад этгээд нь Гүйцэтгэгчийн бараа, материал, баримт бичгийг ашиглаж болно.

Захиалагч ажлын талбай болон түүний ойролцоо байрлах Гүйцэтгэгчийн техник хэрэгсэл, байнгын ажлыг чөлөөлөх мэдэгдлийг Гүйцэтгэгчид өгнө. Гүйцэтгэгч нь тэр даруй өөрийн эрсдэл, зардлаар тэдгээрийг зайлуулах арга хэмжээ авна. Гэхдээ, энэ хугацаанд Гүйцэтгэгчийн зүгээс Захиалагчид төлөх ёстой төлбөрүүд хийгдээгүй бол, өөрийн төлбөрийг олж авах үүднээс эдгээр хөрөнгийг зарж, борлуулж болно. Хэрэв үлдэгдэл төлбөр байвал Гүйцэтгэгч нь уг үлдэгдэл төлбөрийг Захиалагчид бүрэн төлнө.

### 15.3. Гэрээг цуцлах өдөр гаргах үнэлгээ

Гэрээний 15.2 (Захиалагчийн зүгээс гэрээг цуцлах)-т заасны дагуу гэрээг цуцлах мэдэгдлийг хүлээн авсан даруй Гүйцэтгэгч нь мэдэгдэлд дурдсан шаардлагыг шуурхай биелүүлэх бөгөөд Инженер нь Гэрээний 3.5 (Шийдвэр)-д заасны дагуу Гүйцэтгэгчид ажлын төлбөр, үлдсэн ажил, бараа, материал, Гүйцэтгэгчийн баримт бичгийн үнэлгээг хийж, холбогдох шийдвэрийг гаргана.

### 15.4. Гэрээг цуцалсаны дараах төлбөр

Гэрээний 15.2 (Захиалагчийн зүгээс гэрээг цуцлах)-д заасны дагуу гэрээг цуцлах мэдэгдлийн дараа Захиалагч нь дараах арга хэмжээг авна. Үүнд:

- (a) Гэрээний 2.5 (Захиалагчийн нэхэмжлэх)-д заасны дагуу арга хэмжээ авах
- (b) Гүйцэтгэгчтэй холбоотой ажлыг дуусгах хугацаа хоцроосны алданги, торгууль, илэрсэн зөрчил, эвдрэл, гэмтлийг зассан, эсхүл ажлыг гүйцэтгэсэн зардал болон Захиалагчийг эрсдэлд оруулах бусад бүх зардлыг тогтоох хүртэл дараагийн төлбөрийг Гүйцэтгэгчид олгохгүй байх
- (c) Гэрээний 15.3 (Гэрээг цуцлах өдөр гаргах үнэлгээ)-д заасан хүрээнд гүйцэтгэгчид төлөх ёстой ямар нэгэн төлбөрийг зөвшөөрсөний дараа, ажлыг гүйцэтгэсэн шууд зардал болон Захиалагчийг эрсдэлд оруулах хохирлыг Гүйцэтгэгчээр нөхөн төлүүлэх. Эдгээр шууд зардал, хохирол, алдагдлыг нөхөн төлсөний дараа Захиалагч нь тооцоо нийлж хэрэв үлдэгдэл гарвал тэрхүү үлдэгдэл төлбөрийг Гүйцэтгэгчид төлнө.

### 15.5. Гэрээг цуцлах Захиалагчийн эрх

Захиалагч нь өөрийн шийдвэрээр энэхүү Гэрээг цуцлах эрхтэй бөгөөд энэ тухай Гүйцэтгэгчид мэдэгдэл өгнө. Гүйцэтгэгч мэдэгдлийг хүлээж авсанаас хойш долоо (7) хоногийн дотор Гэрээг дуусгавар болсон гэж үзнэ.



Ийнхүү дуусгавар болгосны дараа Гүйцэтгэгч нь 16.3 (Гүйцэтгэгчийн техник хэрэгслийг гаргах болон Ажлыг зогсоох)-т заасны дагуу ажиллаж, 19.6 (Цуцлах хувилбар, төлбөр ба чөлөөлөлт)-д заасны дагуу төлбөрийг гүйцэтгэнэ.

Энэхүү 15 дугаар зүйл (Захиалагчийн санаачлагаар дуусгавар болгох) болон 19 дүгээр зүйл (Давагдашгүй хүчин зүйл) нь Гэрээг дуусгавар болгохтой холбоотой Талуудын онцгой эрх, авч хэрэгжүүлэх арга хэмжээ болон Ажил эхлэх өдрийн дараа Захиалагчийн зүгээс Гэрээг цуцалж,

дуусгавар болгох онцгой эрхийг тодорхойлно. Захиалагч нь гэрээнд зааснаас бусад шалтгаанаар Гэрээг цуцлахгүй.

## 16. Гүйцэтгэгч гэрээг түр зогсоох болон цуцлах

### 16.1. Ажлыг түр зогсоох Гүйцэтгэгчийн эрх

Хэрвээ Захиалагч нь хоёр (2) сар дараалан төлбөрийн нийт дүнтэй тэнцэх хэмжээний үнийн дүнг зохих хугацаанд нь төлөөгүй, дээрх хоёр тохиолдлын аль нэг нь түрүүлж үүссэн, 14.5 [Төлбөрийн хугацаа тогтоох]-д заасны дагуу Гүйцэтгэгчид төлбөр төлөх болсон, маргаанд үл хамаарсан, түүнчлэн дээрх төлбөр төлөөгүй байдал нь энэхүү 16.1 дүгээр заалтад тусгайлан заасанчлан Захиалагчид мэдэгдэл өгсөнөөс хойш хорин найм (28) хоногийн турш зөрчлөө засч залруулаагүй зэрэг нь Гүйцэтгэгчийг ажлыг түр зогсоох саналд хүргэж, улмаар Гүйцэтгэгч нь мэдэгдэлд дурдсан төлбөрийг хүлээж авах хүртлээ ажлыг түр зогсоож (эсхүл ажлын хувь хэмжээг бууруулж) болно.

Гүйцэтгэгчийн эдгээр үйлдэл нь 14.6 [Төлбөрийн саатал ба баталгаа]-д дурдсан санхүүжилтийн үүрэг болон 16.2 [Гүйцэтгэгчийн санаачлагаар дуусгавар болгох]-д заасан Гэрээг цуцлах эрхүүдэд нөлөөлөхгүй болно.

Гүйцэтгэгч нь Гэрээг дуусгавар болгосон талаарх мэдэгдлийг өгөхийн өмнө (дээрх мэдэгдэлд тодорхойлсон) төлбөрийг хүлээн авсан тохиолдолд Гүйцэтгэгч үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлнэ.

Хэрвээ Гүйцэтгэгч нь энэхүү заалтын дагуу ажлыг түр зогсоосны улмаас нэмэлт зардал гарсан, ажил саатсан (эсхүл ажлын хувь хэмжээг бууруулсан) бол Захиалагчид мэдэгдэл өгч, Гэрээний 20.1 (Гүйцэтгэгчийн нэхэмжлэх)-д заасны дагуу дор дурдсаныг нэхэмжлэх эрхтэй.

- (a) Гэрээний 8.4 [Хугацааг сунгах]-т заасны дагуу ажил гүйцэтгэх хугацааг сунгах;
- (b) ийнхүү ажил түр зогсоны улмаас гарсан нэмэлт зардлыг гэрээний төлбөрт тооцуулах.

Захиалагч дээрх мэдэгдлийг хүлээж авсан даруй Гүйцэтгэгчтэй тохиролцож, зөвшилцөх үүднээс 3.5 [Шийдвэр]-д заасан арга хэмжээг авна.

### 16.2. Гүйцэтгэгч гэрээг дуусгавар болгох

Гүйцэтгэгч нь дараах тохиолдолд Гэрээг дуусгавар болгох эрхтэй. Үүнд:

- (a) Хэрвээ Захиалагч нь гурван (3) сар дараалан төлбөрийн нийт дүнтэй тэнцэх хэмжээний үнийн дүнг зохих хугацаанд нь төлөөгүй, дээрх хоёр тохиолдлын аль нэг нь түрүүлж үүссэн, 14.5 [Төлбөрийн хугацаа тогтоох]-ын дагуу Гүйцэтгэгчид төлбөр төлөх болсон, маргаанд үл хамаарсан, түүнчлэн дээрх төлбөр төлөөгүй байдал нь энэхүү 16.2-д тусгайлан заасанчлан Захиалагчид мэдэгдэл өгсөнөөс хойш хорин найм (28) хоногийн турш зөрчлөө засч залруулаагүй зэрэг нь Гүйцэтгэгчийн зүгээс Гэрээг дуусгавар болгох зорилгод хүргэнэ,

- (b) Захиалагч нь дампуурсан, төлбөрийн чадваргүй болсон, татан буугдсан, зээлдүүлэгч нарын нэхэмжлэлийн дагуу захиргааны шийдвэр гарч, тус шийдвэрийг хүлээлгэн өгсөн, зээлдүүлэгч нарын хохирлыг барагдуулахын тулд хариуцагч, итгэмжлэгдэгч буюу менежер томилогдон бизнесийн үйл ажиллагааг хяналтандаа авсан, (холбогдох хуулийн дагуу) дээр дурдсан үйлдэл, арга хэмжээтэй ижил төстэй шинж чанар бүхий бусад тохиолдлууд бий болсон.

#### Дээрх

- (a) дугаар дэд заалтын хувьд Гүйцэтгэгч нь арван дөрвөн (14) хоногийн дотор Гэрээний зөрчлийг засч залруулахыг шаардаж Захиалагчид мэдэгдэл өгч болох бөгөөд Захиалагч нь тухайн зөрчлийг засч залруулж чадаагүй тохиолдолд Гэрээг дуусгавар болгоно [эсхүл Гүйцэтгэгчийн зүгээс хүлээн зөвшөөрөх түвшинд хүртэл зөрчлийг засч залруулах бүхий л бодитой, боломжит арга хэмжээнүүдийг авна].
- (b) дүгээр дэд заалтын хувьд Гүйцэтгэгч нь Гэрээг нэн даруй дуусгавар болгох мэдэгдэл өгч болно. Гэрээний болон бусад нөхцлийн дагуу Гэрээг дуусгавар болгох Гүйцэтгэгчийн сонголт нь Гүйцэтгэгчийн бусад аливаа эрхэнд сөрөг нөлөө үзүүлэхгүй.

### 16.3. Гүйцэтгэгчийн техник хэрэгслийн ашиглалт болон ажлыг зогсоох

Гэрээний 15.2 [Захиалагчийн санаачилгаар дуусгавар болгох], 15.5 (Гэрээг цуцлах Захиалагчийн эрх), 16.2 (Гүйцэтгэгчийн санаачилгаар дуусгавар болгох), 19.6 (Цуцлах хувилбар, төлбөр ба чөлөөлөлт)-д заасны дагуу Гэрээг дуусгавар болгох тухай мэдэгдэл хүчин төгөлдөр болсоны дараа Гүйцэтгэгч дараах арга хэмжээг нэн даруй авна. Үүнд:

- (a) ажлын талбайн аюулгүй байдал, бусдын эд хөрөнгө, амь нас, эрүүл мэндийг хамгаалах зорилгоор Захиалагчийн зүгээс үргэлжлүүлэх, үлдээхийг хүссэнээс бусад бүх ажлыг зогсоох;
- (b) Гэрээг дуусгавар болгох тухай мэдэгдэлд Захиалагч өөрөөр заагаагүй бол талбайгаас Гүйцэтгэгчийн бүх техник, хэрэгсэл, Гүйцэтгэгчийн ажилтныг буцаан татаж, ажлын талбайн хог, хаягдлыг бүхэлд нь цэвэрлэж талбайг чөлөөлөх ба аюулгүй нөхцөлд үлдээх;
- (c) Гүйцэтгэгч нь Гэрээг дуусгавар болгох хүртэл хийсэн ажлын гүйцэтгэл, санхүүгийн тооцоог нийлж, төлбөр нь төлөгдсөн бүх ажлын үр дүнг Захиалагчид өгнө;

### 16.4. Цуцлах үед төлөх төлбөр

Гэрээний 16.2 (Гүйцэтгэгчийн санаачлагаар дуусгавар болгох)-д заасны дагуу Гэрээг цуцлах тухай мэдэгдэл хүчин төгөлдөр болсоны дараа Захиалагч нь Гэрээний 19.6 (Цуцлах хувилбар, төлбөр ба чөлөөлөлт)-д заасныг баримтлан Гүйцэтгэгчид зохих төлбөрийг төлнө.

## 17. Эрсдэл ба хариуцлага

### 17.1. Хохирлыг арилгах баталгаа

Гүйцэтгэгч нь дараах тохиолдолд Захиалагчийн төлөөлөгч, ажилтан, албан тушаалтан болон бусад этгээдэд учруулсан хохирлыг барагдуулж, нөхөн төлнө:

- (a) Ажил гүйцэтгэхтэй холбоотой ажиллагаа, алдаа, доголдлыг засч залруулахтай холбоотойгоор хүний амь нас, эрүүл мэндэд гэмтэл учруулсан, үүний улмаас өвдсөн эсхүл амь нас эрсдсэн;
- (b) Ажил гүйцэтгэхтэй холбоотой ажиллагаа, алдаа, доголдлыг засч залруулах, мөн урьдчилсан хүлээн авах хугацаа өнгөрсний дараа

Гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн бусад ажилтай холбоотойгоор бусдын эд хөрөнгөд эвдрэл, гэмтэл учруулсан бол.

Захиалагч нь Гүйцэтгэгч, түүний төлөөлөгч, ажиллах хүчинд Захиалагчийн төлөөлөгч, холбогдох ажилтан, албан тушаалтны хайхрамжгүй болон санаатай үйлдэл эсхүл Гэрээний зөрчлийн улмаас

(1) эрүүл мэндэд гэмтэл учруулсан, өвчлүүлсэн эсхүл амь нас нь эрсдсэнтэй холбоотой аливаа хохирол, гарсан зардлыг барагдуулж, хохиролгүй болгох бөгөөд

(2) Захиалагч нь аливаа газарт Байнгын ажлыг гүйцэтгүүлэх, мөн тухайн газрыг Байнгын ажил гүйцэтгүүлэхэд ашиглах эрхтэй байна.

Хэрэв 17.1.1-д заасны дагуу хохирлыг арилгуулах эрхтэй этгээдийн гаргасан нэхэмжлэлийн дагуу шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагаа явагдах бол хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй Талд энэ тухай мэдэгдэл өгнө.

Хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй Тал шүүх ажиллагаа болон нөгөө талын шүүх ажиллагааны өмгөөлөл, нэхэмжлэлийг шүүхээр хянан шийдвэрлэхэд гарах зардлыг хариуцна. Хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй тал мэдэгдэл хүлээн авснаас хорин найм (28) хоногийн дотор нөгөө талд тухайн шүүх ажиллагаа эсхүл нэхэмжлэлд өмгөөлөгч авах тухайгаа мэдэгдээгүй бол, нөгөө Тал өөрийгөө өмгөөлүүлэх боломжтой байна.

Хохирлыг нөхөн төлөх Тал хорин найм (28) хоногийн хугацааны дотор ийнхүү мэдэгдээгүй бол, нөгөө Тал тухайн шүүх ажиллагаа эсхүл нэхэмжлэлд өөрийгөө өмгөөлөх зөвшөөрөл өгөхгүй. Нөгөө Тал хохирлыг нөхөн төлөх Талын хүсэлтээр тухайн талд нэхэмжлэл эсхүл шүүх ажиллагааг явуулах боломжтой бүх тусалцааг үзүүлэх бөгөөд хохирлыг нөхөн төлөх Талаас үүнд гарсан бүх зардлыг нөхөн төлүүлнэ.

## **17.2. Ажилд Гүйцэтгэгч хариуцлагатай хандах**

Гүйцэтгэгч нь ажил эхлэх өдрөөс ажлыг хүлээн авах акт олгох хүртэл эсхүл энэхүү Гэрээний дагуу Гүйцэтгэгчийн гүйцэтгэх үүргийг цуцалж, үүргийг Захиалагчид шилжүүлэх хүртэл Ажил болон Бараа материалд хариуцлагатай хандах үүрэг хүлээнэ. Хэрэв Ажлын тодорхой хэсгийг хүлээн авч ажил хүлээн авах акт олгосон (эсхүл олгосон гэж үзсэн) бол тухайн Ажилд хариуцлагатай хандах үүрэг Захиалагчид шилжинэ.

Хариуцлагатай хандах үүрэг Захиалагчид шилжсэний дараа, Гүйцэтгэгч ажил хүлээн авах актад заасан хугацаанд үлдсэн ажилд хариуцлагатай хандах үүргийг ажил хүлээн авах акт олгосны дараа тухайн үлдсэн ажлыг гүйцэтгэж дуусах (үүнд доголдлыг засах ажил багтана) хүртэл хүлээнэ.

Гүйцэтгэгчийн ажилд хариуцлагатай хандах үүрэг хүлээсэн хугацаанд Ажил, Бараа материал эсхүл Гүйцэтгэгчийн бичиг баримтад 17.3 [Захиалагчийн эрсдэл] зааснаас бусад шалтгааны улмаас алдагдал, хохирол учирсан бол Гүйцэтгэгч өөрийн зардлаар эрсдлийг хүлээж алдагдал, хохирлыг барагдуулан Ажил, Бараа материал болон Гүйцэтгэгчийн бичиг баримтыг Гэрээнд нийцүүлнэ.

Гүйцэтгэгч ажил хүлээн авах акт олгосны дараа Гүйцэтгэгчийн эсхүл түүний Туслан Гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн аливаа ажиллагааны улмаас учирсан алдагдал, хохиролд хариуцлага хүлээнэ. Гүйцэтгэгч ажил хүлээн авах акт олгосны дараа Гүйцэтгэгчийн хариуцах ёстой өмнөх ажиллагаанаас үүдсэн аливаа алдагдал, хохирлыг мөн хариуцна.

Энэхүү 17.2 дугаар зүйлийн бусад заалтын дагуу Гүйцэтгэгчийн хариуцлага хүлээхгүй Ажил, Бараа материал эсхүл Гүйцэтгэгчийн бичиг баримтад

Урьдчилсан байдлаар ажил хүлээн авах акт олгосны дараа аливаа алдагдал эсхүл хохирол учирсан бол 17.2.2 дугаар зүйлийг үл харгалзан Захиалагч Гүйцэтгэгчийг тухайн Ажил, Бараа материал болон Гүйцэтгэгчийн бичиг баримтыг Гэрээний шаардлагад бүрэн нийцүүлэн алдагдал, хохирлыг арилгаж засахыг шаардах бөгөөд хэрэв тухайн алдагдал эсхүл хохирол нь Захиалагчийн эрсдлийн дүнд гарсан бол 17.4 дүгээр зүйлд заасныг хүсэлт гаргахдаа дагаж мөрдөнө.

### 17.3. Захиалагчийн эрсдэл

Захиалагчийн эрсдлүүд:

- (a) Дайн, (дайн зарлах эсхүл зарлахгүй байх эсэх) дайсагнасан нөхцөл байдал, халдлага, гадны дайснуудын ажиллагаа;
- (b) Бослого, терроризмын ажиллагаа, хувьсгал, үймээн самуун, цэргийн эсхүл засгийн эрхийг булаасан хүчин, улс оронд гарсан иргэний дайн;
- (c) Гүйцэтгэгчийн боловсон хүчин болон Туслан Гүйцэтгэгчийн ажилтнуудаас бусад этгээдийн улс орон дотор гаргасан бослого, үймээн эсхүл эмх замбараагүй явдал;
- (d) Гүйцэтгэгчийн ашиглахаас бусад дайны зэр зэвсэг, тэсэрч дэлбэрэх материал, ионжуулсан цацраг эсхүл радио идэвхит хог хаягдал;
- (e) Дууны хурд эсхүл түүнээс дээш хурдаар нисч буй агаарын хөлөг болон агаарын төхөөрөмжийн учруулсан даралтат долгион;
- (f) Гэрээнд заасан эсхүл зөвшөөрснөөс бусад тохиолдолд ажил хүлээн авах акт олгохоос өмнө Ажлын аль нэг хэсгийг Захиалагч ашигласан эсхүл авсан.

### 17.4. Захиалагчийн эрсдлийн үр дагавар

Дээрх 17.3-т нэрлэн заасан эрсдлийн улмаас ажил, бараа материал эсхүл Гүйцэтгэгчийн бичиг баримтад алдагдал, хохирол учирсан бол, Гүйцэтгэгч тухайн алдагдал, хохирлын талаар зохих ёсоор Захиалагчид бичгээр мэдэгдэл өгнө.

Захиалагч Гүйцэтгэгчид зарчмын хувьд тухайн алдагдал эсхүл хохирол нь Гүйцэтгэгчид төлөх алдагдал эсхүл хохирол мөн эсэхийг мэдээлнэ.

Хэрэв Захиалагч ийнхүү мэдэгдэл өгсөн бол Гүйцэтгэгч Захиалагчид тухайн алдагдал, хохирлыг засах саналаа түүнийг хэрэгжүүлэх арга болон ажлыг гүйцэтгэхэд гарах урьдчилан тооцсон зардлын хамт (Гүйцэтгэгч зардал, тооцоондоо аливаа нэмэгдэл зардал болон ашиг оруулах эрхгүй Өөрчлөлт оруулах замаар хийхийг заасан ажлыг гүйцэтгэх шаардлагатай бол 13 дугаар зүйлд заасны дагуу тооцоолж, тодорхойлох бөгөөд тухайн нэмэгдэл зардал болон ашгийг алдагдал, хохирлыг төлөх үнэд нэмж оруулна) бичгээр мэдэгдэнэ.

Захиалагч тухайн мэдээллийг авснаас хорин найм (28) хоногийн дотор Гүйцэтгэгчид тухайн ажлыг гүйцэтгэх шаардлагатай эсэхийг мэдэгдэх ба энэ тохиолдолд Гүйцэтгэгч тухайн алдагдал, хохирлыг тохирсон эсхүл тогтоосон үнээр Захиалагчийн зардлаар засч гүйцэтгэнэ.

Хэрэв Гүйцэтгэгч 17.3-т нэрлэн заасан эрсдлээс үүдэн ажил, бараа материал эсхүл Гүйцэтгэгчийн бичиг баримтад учирсан алдагдал, хохирлыг засч, арилгахыг хойшлуулснаас хохирол учирч байгаа бол, Гүйцэтгэгч Захиалагчид энэ тухай мэдэгдэл өгөх бөгөөд хэрэв 8.4 [Ажил дуусгах хугацааг сунгах]-т заасан шалтгаанаар гүйцэтгэл хойшилсон бол 20.1 [Гүйцэтгэгчийн нэхэмжлэл]-д заасны дагуу Гүйцэтгэгч тухайн хойшилж буй хугацаагаар ажлын

**МЛ БОЛСОН**

гүйцэтгэлийн хугацааг сунгах эрхтэй байна. Энэ мэдэгдлийг хүлээн авсны дараа, Захиалагч эдгээр асуудлыг хүлээн зөвшөөрөх эсхүл шийдвэрлэхдээ 3.5 [Шийдвэр]-д заасны дагуу арга хэмжээ авна.

**17.5. Оюуны болон үйлдвэрлэлийн өмчийн эрх**

Гүйцэтгэгч дараах зүйлд холбогдох Оюуны өмчийн эрхийн зөрчил, хууль бусаар эзэмших эсхүл буруугаар ашигласан нь бодитоор тогтоогдсон эсхүл буруутгагдсан бол үүнтэй холбоотой аливаа алдагдал, зардал эсхүл нэхэмжлэлээс Захиалагчийг хохиролгүй болгож, ангид байлгана:

- (a) Гүйцэтгэгчийн зураг төсөл, Инженер, худалдан авалт, барилга, Ажлыг шалгах эсхүл ашиглалтад хүлээн авах;
- (b) Гүйцэтгэгчийн техник хэрэгслийг ашиглах;
- (c) Ажлын зохистой ашиглалт, хэрэглээ.

Хэрэв Захиалагч нэхэмжлэлтэй холбоотойгоор 17.5-д заасны дагуу хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй бол, Гүйцэтгэгч (өөрийн зардлаар) үүнтэй холбоотой үүдэн гарсан Нэхэмжлэл, мөн аливаа маргаан эсхүл шүүхийн асуудлыг шийдвэрлэх хэлэлцээ явуулна. Захиалагч хүсэлт гарган, Гүйцэтгэгчийн зардлаар Нэхэмжлэлийг няцаахад тусална. Гүйцэтгэгч нэхэмжлэлтэй холбоотой хэлэлцүүлэг, маргаан эсхүл шүүхийн ажиллагаа явуулаагүйгээс Захиалагч хүсэлт гаргаснаас бусад тохиолдолд Захиалагч (болон түүний ажилтан) Гүйцэтгэгчийн нэхэмжлэлтэй холбоотойгоор шүүхийн өмнө аливаа үүрэг хүлээхгүй болно.

Хэрэв Захиалагч, түүний боловсон хүчин, салбар эсхүл хууль ёсны залгамжлагчийн эсрэг 17.5-д дурдсан асуудлаас үүдэн нэхэмжлэл гаргасан, мөн байнгын ажлын аль нэг хэсгийг саатуулсан эсхүл Гүйцэтгэгч тухайн ажил болон түүний ашиглалт зөрчилтэй байгааг хүлээн зөвшөөрсөн бол, Гүйцэтгэгч өөрийн зардлаар Захиалагчийн байнгын ажлыг ашиглах эсхүл үргэлжлүүлэн ашиглах эрхийг нэн даруй өгөх, ингэхдээ Гүйцэтгэгч тухайн эрхийг авч чадахгүй бол Гүйцэтгэгч өөрийн зардлаар, мөн Захиалагчийн үзэмжээр дараах арга хэмжээг авна:

- (a) байнгын ажлын тухайн хэсгийг нөхөж хийх эсхүл дүйцэх зөрчилгүй материалаар орлуулах;
- (b) байнгын ажлыг өөрчлөн гүйцэтгэж гүйцэтгэлийн алдагдалгүйгээр Зөрчилгүй болгоно.

Тухайн орлуулсан хэсэг эсхүл өөрчилсөн байнгын ажилд энэхүү Гэрээний анхны байнгын ажилд хамаарах заалтуудыг авч хэрэглэнэ.

**17.6. Хариуцлагын хязгаарлалт**

Энэхүү Гэрээтэй холбоотой (гэхдээ үүнд Гэрээний зөрчил, мөн түүнчлэн хохирлыг барагдуулах, хуульд заасан үүрэг, эрх эсхүл бусад эрх зүйн онолыг зөрчсөн иргэний эрхийн зөрчил багтана) аливаа асуудалд Захиалагчийн өмнө хүлээх Гүйцэтгэгчийн нийт хариуцлага Захиалагчийн хариуцлагын хязгаарлалтаас хэтрэхгүй байна. Гэрээний хариуцлагын хязгаарлалтад Гэрээний дагуу төлбөл зохих Татан буугдсаны хохирлыг багтаасан.

Гэрээний хариуцлагын хязгаарлалт нь дараах зүйлд хэрэглэгдэхгүй бөгөөд дараах хэмжээгээр мөн хорогдохгүй болно (хариуцлагыг тооцоход дараах асуудалд хариуцлага хүлээхгүй):

- (a) Гүйцэтгэгчийн нөхөн төлсөн эсхүл даатгагчаар нөхөн төлүүлэх хариуцлага (үүнд Захиалагч эсхүл Санхүүжүүлэгчээс шууд бус хэлбэрээр хүлээн авсан хөрөнгө багтана);

- (b) Гүйцэтгэгчээс аливаа даатгагчаар төлүүлэх, гэхдээ Гүйцэтгэгч өөрөө даатгалыг хүчин төгөлдөр байлгаж, хадгалах Гэрээнд заасан үүргээ зөрчсөнтэй холбоотой хүлээх хариуцлага;
- (c) Луйвар, залилангийн үйлдэл, санаатай зүй бус үйлдэл эсхүл санаатай зөрчил, Хориглосон үйлдэл эсхүл холбогдох хууль тогтоомжийн зөчрилтэй холбоотой хариуцлага;
- (d) Гүйцэтгэгчийн 1.13, 4.13, 4.15.2, 7.9.3, 17.1, 17.5 болон 18.9 дүгээр заалтуудад заасан хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбоотой хариуцлага;
- (e) Гүйцэтгэгчийн эсрэг эрхээ хэрэгжүүлэхэд гарах Захиалагчийн зардал;
- (f) Гэрээг цуцлах эсхүл Гүйцэтгэгчийн Гэрээний дагуу хүлээсэн үүргийг цуцлахаас өмнө Гэрээнд заасан Ажлыг явуулах болон үүргээ хэрэгжүүлэхэд зарцуулах ёстой зардал;

Гэрээний аливаа заалтад нийцсэн эсэхийг үл харгалзан аль ч Тал нөгөө Талд Гэрээний зөрчилөөс үүдсэн хохирол, хуульд заасан үүрэг, эрх эсхүл бусад эрх зүйн онолыг зөрчсөн иргэний эрхийн зөрчил, Эдийн засгийн алдагдалд ямар нэг хариуцлага хүлээхгүй бөгөөд 17.6.3 дугаар зүйлд дараах хариуцлагыг урьдчилан сэргийлж, хязгаарлаж эсхүл оруулаагүй болно:

- (a) Гэрээнд Татан буугдсаны хохирлын хэмжээг тогтоох зорилгоор урьдчилсан байдлаар гаргасан алдагдлын хэмжээнд хамаарч байгаа Эдийн засгийн алдагдалд хүлээх хариуцлага;
- (b) Гэрээний хариуцлагын хязгаарлалтад хамаарахгүй 17.6.2 дугаар зүйлд дурдсан хариуцлага, зардал, алдагдал эсхүл хохирлын тодорхой хэсэг болж байгаа Эдийн засгийн алдагдалд хүлээх хариуцлага;
- (c) Гэрээний 15.4 эсхүл 15.5 дугаар заалтуудын дагуу Гэрээг цуцласнаас үүдсэн Эдийн засгийн алдагдалд хүлээх хариуцлага (Гүйцэтгэгчийн эдийн засгийн алдагдалд хүлээх хариуцлага нь 17.6.4 дүгээр заалтын Татан буугдсаны хохиролд хамаарах хязгаарлалтаар хязгаарлагдах бөгөөд Гэрээний дагуу Захиалагчид төлөх бүх Татан буугдсаны хохирлоос бага байна);
- (d) Гэрээнд зөвшөөрсөн 11.4(b) дүгээр заалтын дагуу Эдийн засгийн алдагдлыг нөхөн төлөх.

Гүйцэтгэгчийн Захиалагчийн өмнө хүлээх Татан буугдсаны хохирлыг барагдуулах хариуцлага нь Гэрээний үнийн арван (10) хувиас хэтрэхгүй байна.

## 18. Даатгал

### 18.1. Даатгал

Гүйцэтгэгч нь холбогдох хууль тогтоомжийн дагуу ажиллагсад, техник, хэрэгсэл, бараа, материалыг даатгалд хамруулсан байна. Үүнд: ажиллагсдыг эрүүл мэндийн, нийгмийн даатгал ба нөхөн олговор, үндсэн ба туслах техник хэрэгсэл, гуравдагч этгээдийн өмнө хүлээх тээврийн хэрэгслийн хариуцлагын даатгал, мэргэжлийн хариуцлагын даатгал.

Ийнхүү даатгуулаагүйгээс гарах аливаа үр дагаврыг Захиалагч болон гуравдагч этгээдийн өмнө Гүйцэтгэгч хариуцна.

Гүйцэтгэгч нь холбогдох хууль, дүрэм, журамд заасан барилгын ажил гүйцэтгэхтэй холбоотой аливаа даатгал, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал, холбогдон гарах зардлыг бүрэн хариуцна.

Барилгын ажил гүйцэтгэх, гүйцэтгүүлэх явцад гарсан үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг тогтоох, судлан бүртгэхэд холбогдох журмыг баримтална.

## 19. Давагдашгүй хүчин зүйл

### 19.1. Давагдашгүй хүчин зүйл

Давагдашгүй хүчин зүйл гэж талуудын гэм буруутай болон болгоомжгүй үйл ажиллагаанаас шалтгаалаагүй, тэдгээрийн хүсэл зориг, хяналтаас гадуур бий болсон, урьдчилан харах боломжгүй буюу зохих арга хэмжээг авсан ч сэргийлэх боломжгүй байсан, үүний улмаас Талуудын үүргийн гүйцэтгэлд саад учруулсан нөхцөл байдлыг хэлнэ. Үүнд:

- a) ионжуулах цацраг буюу бохирдол, химийн бохирдол, цөмийн түлш, эсвэл цөмийн тэсрэлтээс үүдэлтэй цөмийн хог хаягдлаас үүсэх цацраг идэвхит үйл ажиллагаа, тэсэрч дэлбэрэх болон цөмийн бүрдэл бүхий цацраг идэвхит хортой тэсрэх болон бусад аюултай эд зүйлс;
- b) байгалийн гамшиг (ган, газар хөдлөлт, үер, гал түймэр, галт уулын дэлбэрэлт, хөрсний нуралт гулгалт, салхи шуурга, аянга цахилгаан болон байгалийн бусад аюултай үзэгдэл);
- c) голомтот халдвар болон тахал;
- d) гэнэтийн осол, дэлбэрэлт;
- e) нисэх болон усан онгоцны сүйрэл, галт тэрэгний осол, том хэмжээний тээврийн саатал, зогсолт, онгоцны болон агаарын бусад хөлгөөс, эсхүл дуу авианы цохилтын улмаас эд зүйл нурах;
- f) дайн (дайн зарласан эсэхээс үл хамааран) болох, халдан довтлох, зэвсэгт мөргөлдөөн;
- g) үймээн самуун, бослого, иргэний дайн, хувьсгал, хорлон сүйтгэх, терроризм, иргэний мөргөлдөөн;
- h) Монгол Улсын эсрэг тогтоосон хориг, албадан авах арга хэмжээ;
- i) гадаад улсын төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр хил хаасан, төмөр замын харилцааг эхлүүлээгүй буюу зогсоосон, импорт, экспортын хориг, хязгаарлалт тавих;
- j) уул уурхайн үйл ажиллагаа болон төслийн бусад үйл ажиллагаанд өөрчлөлт оруулах хэмжээний нөлөөтэй, өмнө нь мэдэгдээгүй газар орчны нөхцөл байдал, археологийн олдвор болон байгалийн түүхийн эд өлгий шинээр илрүүлсэн;
- k) дээрхтэй адил төрлийн аливаа үйлдэл, тохиолдол, үйл явдал болон нөхцөл байдал;
- l) Засгийн газрын 2019 оны 135 дугаар тогтоолд заасан төслийн санхүүжилттэй холбоотой шийдвэрүүд зохих ёсоор хэрэгжээгүйн улмаас Захиалагч Гэрээний үүргээ биелүүлэх, барилгын ажлыг үргэлжлүүлэх боломжгүй болсон
- m) Захиалагчийн төсөл хэрэгжүүлэх эрхийг өөр этгээдэд шилжүүлсэн, эсхүл төслийн үйл ажиллагаа болон барилгын ажлыг зогсооход хүргэсэн бусад асуудлаар Монгол улсын эрх бүхий байгууллагын шийдвэр гарсан. Үүнд: Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Улсын Их Хурал, Засгийн газар, төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, орон нутгийн байгууллагаас гарсан тогтоол, захирамж, зөвлөмж, бусад шийдвэр хамаарна.

Давагдашгүй хүчин зүйлд дараах үйл явдал нөхцөл байдал хамаарахгүй. Үүнд:

- (a) Давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалаагүй Туслан Гүйцэтгэгчийн үйлдэл, эс үйлдэхүй, алдаа;
- (b) Давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалаагүй Туслан Гүйцэтгэгч, ажиллах хүч, бараа, материалын дутагдал;
- (c) Давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалаагүй аль нэг Талын өмчийн, эсхүл түүний ажиллуулж буй техник хэрэгсэл, эсхүл үйлдвэрийн механик эсхүл цахилгааны гэмтэл, доголдлыг;
- (d) Гүйцэтгэгчийн Талбай болон Туслан Гүйцэтгэгчийн ажилтнуудад хамаарах, эсхүл улс орон дахь бусад бизнесийн байгууллагуудын ажилтнуудад материаллаг байдлаар нөлөөлөхгүй үйлдвэрийн маргааны нэг хэсэг болохооргүй ажил хаялт, локаут болон бусад үйлдвэрийн саатал;
- (e) Давагдашгүй хүчин зүйлд өртөөгүй байсан ч тухайн Талд зайлшгүй гарах байсан эрсдэл.

#### 19.2. Давагдашгүй хүчин зүйлийн мэдэгдэл

Давагдашгүй хүчин зүйл тохиолдсон бол Хамтын ажиллагааны гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлж чадаагүй буюу боломжгүй болсон Тал нь нөгөө Талдаа давагдашгүй хүчин зүйл, үүргээ биелүүлэх боломжгүй болсон үндэслэлийн талаар нэн даруй мэдэгдэнэ.

#### 19.3. Давагдашгүй хүчин зүйлийн үр дагавар

Хэрэв Гүйцэтгэгч давагдашгүй хүчин зүйлийн нөлөөгөөр Гэрээнд заасан үүргээ биелүүлэхэд саад учирч, энэ тухай 19.2 (Давагдашгүй хүчин зүйлийн талаарх мэдэгдэл)-т заасны дагуу мэдээлсэн бөгөөд тухайн давагдашгүй хүчин зүйлийн улмаас саатал гарсан бол, Гүйцэтгэгч 20.1 (Гүйцэтгэгчийн нэхэмжлэл)-д заасны дагуу тухайн саатлын хугацаагаар ажил гүйцэтгэх хугацааг сунгах эрхтэй.

Мэдэгдэл авсны дараа Захиалагч эдгээр асуудлыг хүлээн зөвшөөрч, тогтооход 3.5 (Шийдвэрүүд)-д заасны дагуу арга хэмжээ авна.

Эргэлзээг арилгах үүднээс тодруулахад, хэрэв давагдашгүй хүчин зүйлийн улмаас Гүйцэтгэгчийн 17.2 (Ажилд Гүйцэтгэгч хариуцлагатай хандах)-д заасны дагуу хариуцлагатай хандах ёстой байсан хугацаанд ажил, бараа, материал, эсхүл Гүйцэтгэгчийн баримт бичигт алдагдал, хохирол учирсан бол тухайн давагдашгүй хүчин зүйл нь 17.3 (Захиалагчийн эрсдэл)-т заасан Захиалагчийн эрсдэл эсэхийг үл харгалзан Гүйцэтгэгч 17.2 (Ажилд Гүйцэтгэгч хариуцлагатай хандах)-т заасны дагуу өөрийн эрсдэл болон зардлаар засч сайжруулах арга хэмжээ авах үүрэгтэй.

Давагдашгүй хүчин зүйлийн улмаас Захиалагч төлбөр төлөх үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний үүргийн биелэлтийг уг саадыг арилгах хүртэл хугацаагаар сунгагдсанд тооцно.

#### 19.4. Хүнд нөхцөл байдал

Дор дурдсаныг хүнд нөхцөл байдалд тооцно. Үүнд:

- (a) Засгийн газрын 2019 оны 135 дугаар тогтоол зохих ёсоор хэрэгжээгүйн улмаас уг тогтоолд заасан Төслийн бүтээн байгуулалтад зарцуулах хөрөнгийн эх үүсвэр төвлөрөөгүй, үүнтэй холбоотойгоор барилгын ажил зогссон, гүйцэтгэсэн ажлын төлбөрийг төлөх боломжгүй болсон;



- (b) Гэрээ байгуулах үед хучин төлөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэрт өөрчлөлт орсон, эсхүл шинээр гарсан нь Төслийн бүтээн байгуулалтын ажил саатах буюу зогсох үндэслэл болсон;

**19.5. Хүнд нөхцөл байдлын үр дагавар**

Хүнд нөхцөл байдал тохиолдсон бол Гэрээний 19.3-т заасан үр дагавар нэгэн адил хамаарна.

**20. Нэхэмжлэл, маргаан болон шүүхийн ажиллагаа**

**20.1. Гүйцэтгэгчийн нэхэмжлэл**

Хэрэв Гүйцэтгэгч нь Гэрээнд заасан нөхцөлөөр гэрээний хугацааг сунгах болон нэмэлт төлбөр авах эрхтэй бол нэхэмжлэх гаргах буюу нөхцөл байдлыг тодорхойлсон мэдэгдлийг Захиалагчид хүргүүлнэ. Гүйцэтгэгч тухайн нөхцөл байдал, ажиллагааг мэдсэн буюу мэдсэн байх ёстой хугацаанаас хойш 28 (хорин найм) хоногийн дотор уг мэдэгдлийг Захиалагчид хүргүүлсэн байх ёстой.

Хэрэв Гүйцэтгэгч 28 (хорин найм) хоногийн хугацаанд нэхэмжлэх гаргаагүй буюу мэдэгдэл өгөөгүй бол, нэмэлт хугацаа олгохгүй бөгөөд Гүйцэтгэгч нэмэлт төлбөр авах эрхгүй болж, Захиалагч нэхэмжлэхтэй холбоотой бүх хариуцлагаас чөлөөлөгдөнө.

Гүйцэтгэгч нь үндэслэлээ хангалттай нотолсон нэхэмжлэхийн дүнгээрх төлбөрийг явц дундын гүйцэтгэлийн төлбөрийн хамт авах эрхтэй.

Захиалагч нь Гэрээний 3.5 [Шийдвэрүүд]-д заасны дагуу арга хэмжээ авч дараах асуудлыг шийдвэрлэнэ:

- (a) Гэрээний хугацааг сунгах
- (b) Гэрээний дагуу Гүйцэтгэгчид нэмэлт төлбөр төлөх эсэх.

**20.2. Маргааныг эвлэрлийн журмаар шийдвэрлэх**

Талуудын хооронд үүссэн аливаа маргаантай асуудлыг шийдвэрлэх талаар аль нэг Талаас нөгөө Талд бичгээр мэдэгдэл хүргүүлж, мэдэгдлийн дагуу Талууд зөвшилцөлд хүрэх арга замыг бүх талаар эрэлхийлнэ.

**20.3. Төрийн захиргааны байгууллага**

Талууд зөвшилцөлд хүрч чадаагүй тохиолдолд өөр, өөрийн харъяалах төрийн захиргааны төв байгууллагад асуудлыг уламжилж, дээд түвшинд шийдвэрлүүлэх арга хэмээ авна.

**20.4. Шинжээчээр шийдвэрлүүлэх**

Аль нэг Талын хүсэлтээр үүссэн маргааныг шийдвэрлүүлэхээр хэдийд ч хөндлөнгийн Шинжээчид хэдийд ч хандаж болно. Ийнхүү шинжээчид хандсан тал шинжээчийн зардлыг хариуцна.

Шинжээч нь өмнө ба одоо аль нэг Талд ажиллаж байсан түүхгүй, ашиг сонирхлын зөрчилгүй, холбогдох маргааны зүйлийг шинжлэн дүгнэлт гаргах мэдлэг, ур чадвартай, Талуудад хүлээн зөвшөөрөгдөхүйц мэргэжлийн бөгөөд мэргэшсэн хүн, хуулийн этгээд байна.

**20.5. Шүүхээр шийдвэрлүүлэх**

Энэ зүйлийн 20.2, 20.3, 20.4-т заасны дагуу маргааныг шийдвэрлэж чадаагүй бол харъяаллын шүүхэд хандах Талуудын эрх нээлттэй.

**ИЛ БОЛСОН**  
**ГЭРЭЭНД НЭМЭЛТ**  
**ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

2020 оны 03 сарын 04 өдөр

Дугаар АТГ-Н/1901-01

Улаанбаатар хот

**НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

“Монголын төмөр зам” ТӨХК болон Зэвсэгт хүчний Жанжин штабын хооронд 2019 оны 06 дугаар сарын 12-ны өдөр байгуулагдсан АГГ-Н/1901, Н/387 дугаартай гэрээ, түүний хавсралтад талууд дараах нөхцөлүүдийг харилцан тохиролцож, Гэрээний нөхцөлийн 1.2 дахь хэсгийг үндэслэн, нэмэлт өөрчлөлт оруулав.

**ХОЁР. ГЭРЭЭНД ОРУУЛАХ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ**

2.1. Гэрээний 1 дэх заалтад “...энэхүү Гэрээний хавсралт-6 /Ажлын техникийн даалгавар ба Захиалагчийн шаардлага/-д заасан ажлыг гүйцэтгэхтэй холбоотой...” гэснийг “...энэхүү Гэрээний хавсралт-6, 14-д заасан ажлыг гүйцэтгэхтэй холбоотой ...” гэж өөрчлөв;

2.2. Гэрээний 3 дугаар зүйлд “Гүйцэтгэгч нь Гэрээний хавсралт-6 /Ажлын техникийн даалгавар ба Захиалагчийн шаардлага/-д заасан ажлыг...” гэснийг “Гүйцэтгэгч нь Гэрээний хавсралт-6, 14-д заасан ажлыг...” гэж өөрчлөв.

2.2. Гэрээний 9 дүгээр зүйлд “...Хавсралт-6 Ажлын техникийн даалгавар ба Захиалагчийн шаардлага...” гэснийг “...Хавсралт-6 Ажлын даалгавар” гэж өөрчлөв;

2.3. Гэрээний 9 дүгээр зүйлд “...Хавсралт-13: Төслийн барилгын үйл ажиллагаанд баримтлах норм, нормативын баримт бичгийн нэгдсэн жагсаалт;” гэсний дараа “Хавсралт-14: Доод бүтцийн хоолойн ажлын зураг төсөл, ажлын даалгавар, техникийн шаардлага, төсөв ...” гэж нэмэв.

**ГУРАВ: ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛД ОРУУЛАХ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ**

3.1. Гэрээний нөхцөлийн дор дурдсан зүйл заалтуудад өөрчлөлт оруулав. Үүнд;  
3.1.1 Гэрээний нөхцөлийн 1.1.2 дахь заалтын (d)-д “Инженер” гэж ажлын талбайд Захиалагчийг төлөөлөх эрх бүхий Захиалагчийн томилсон этгээд, эсхүл Захиалагч тодорхой хугацаагаар томилсон болон Гэрээний 3.4 (Инженерийг солих)-т заасны дагуу Гүйцэтгэгчид мэдэгдсэн этгээдийг;” гэснийг “Инженер” гэж Гүйцэтгэгч энэхүү гэрээнд заасан ажлыг батлагдсан зураг төсөв, норм норматив, техникийн баримт бичгийн дагуу хийж байгаа эсэхэд хяналт тавих, зөвлөгөө өгөх, ажлын гүйцэтгэлийг баталгаажуулах ажиллагааг гэрээний үндсэн дээр Захиалагчийг төлөөлөн хэрэгжүүлэх этгээдийг” гэж;

3.1.1. Гэрээний нөхцөлийн 1.1.2 дахь заалтын (h)-т “Туслан Гүйцэтгэгч” гэдэг нь Гэрээнд туслан гүйцэтгэгч гэж заагдсан аливаа этгээд, эсхүл ажлын нэг хэсгийг гүйцэтгэхээр Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан хуулийн этгээд байна.” гэснийг “Туслан гүйцэтгэгч” гэж Гүйцэтгэгчийн үүргийн тодорхой хэсгийг Гэрээний үндсэн дээр гүйцэтгэж буй гуравдагч этгээдийг;” гэж;

3.1.2. Гэрээний нөхцөлийн 1.1.2 дахь заалтын (f)-т “Захиалагчийн ажилтан” гэж Гэрээний 3.2 /Инженерийн төлөөлөгч/-т заасны дагуу ажиллах Захиалагчийн

томилсон Инженер, Захиалагч болон Инженерийн зүгээс ажиллуулж байгаа бүх Зөвлөх, ажилтан, мөн Захиалагч, Инженерийн зүгээс Гүйцэтгэгчид мэдэгдсэн бусад ажилтнууд байна.” гэснийг “Захиалагчийн ажилтан” гэж Гүйцэтгэгч болон Инженер, Туслан гүйцэтгэгч тэдгээрийн төлөөлөгч нарт хяналт тавих чиг үүрэг бүхий Захиалагчтай хөдөлмөрийн болон хөлсөөр ажиллах гэрээ байгуулсан инженер, мэргэжилтэнг хэлнэ.” гэж;

- 3.1.3. Гэрээний нөхцөлийн 1.8 дахь заалтад “Талууд харилцан тохиролцсоноор, Гүйцэтгэгч нь өөрийн боловсруулсан оюуны өмч болох баримт бичгүүд, мөн Гүйцэтгэгчийн гаргасан техникийн зураг, бусад баримт бичгүүдийг өөртөө хадгална.” гэснийг “Талууд харилцан тохиролцсоноор, Гүйцэтгэгч нь өөрийн боловсруулсан оюуны өмч болох баримт бичгүүд, мөн Гүйцэтгэгчийн гаргасан ажлын зураг, бусад баримт бичгүүдийг өөртөө хадгална.” гэж;
- 3.1.4. Гэрээний нөхцөлийн 1.9 дэх заалтад “...Захиалагч нь өөрийн боловсруулсан техникийн шаардлага, ажлын болон техникийн зураг, бусад оюуны өмч болох баримт бичгүүдийг өөртөө хадгална.” гэснийг “...Захиалагч нь өөрийн боловсруулсан техникийн шаардлага, ажлын болон ажлын зураг, бусад оюуны өмч болох баримт бичгүүдийг өөртөө хадгална.” гэж;
- 3.1.5. Гэрээний нөхцөлийн 7.3-г “Захиалагчийн ажилтан дараах эрхтэй...” гэснийг “Инженер, Инженерийн төлөөлөгч дараах эрхтэй...” гэж, “...Гүйцэтгэгч нь бэлэн болсон ажил, ажлыг далдлахаас өмнө, материалыг баглаж хадгалах, тээвэрлэхдээ тухай бүр Инженерт мэдэгдэл өгнө” гэснийг “...Гүйцэтгэгч нь бэлэн болсон ажил, ажлыг далдлахаас өмнө, материалыг баглаж хадгалах, тээвэрлэхдээ тухай бүр Захиалагчийн ажилтанд мэдэгдэл өгнө” гэж тус тус өөрчлөв.
- 3.1.6. Гэрээний нөхцөлийн 4.4 дэх заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулав.
- Гүйцэтгэгч гэрээт ажлын тодорхой хэсгийг гуравдагч этгээдээр ажил гүйцэтгэх гэрээ байгуулан гүйцэтгүүлж болох бөгөөд гэрээ байгуулах зөвшөөрлийг захиалагчаас бичгээр авна. Захиалагчийн бичгээр олгосон зөвшөөрөл гэж Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 315 дугаар тушаалаар томилогдсон “Дэд ажлын хэсэг”-ийн зөвлөмжийг ойлгох бөгөөд дэд ажлын хэсгийн зөвлөмжөөр хуулийн этгээдтэй гэрээ байгуулахыг зөвшөөрсөн нөхцөлд уг хуулийн этгээдийг тухайн ажлыг гүйцэтгэх бүрэн чадамжтай гэж үзнэ. Гүйцэтгэгч нь дэд ажлын хэсгээс гэрээ байгуулахыг зөвшөөрсөн хуулийн этгээдтэй гэрээ байгуулаагүй нөхцөлд дэд ажлын хэсэг нь өөр хуулийн этгээдийг дахин судалж зөвшөөрөл олгоно. Ийнхүү гүйцэтгүүлэх тохиолдолд Захиалагч гуравдагч этгээдтэй санхүүжилтийн гэрээ байгуулж, Гүйцэтгэгчийн хүсэлтээр төлбөрийг олгоно.
  - Гуравдагч этгээдийн ажлын гүйцэтгэлийг Инженер хянан, баталгаажуулж, төлбөрийн хүсэлтийг Гүйцэтгэгч хянан, баталгаажуулж, зөвшөөрөл олгосныг тус тус үндэслэн Захиалагч гуравдагч этгээдэд төлбөрийг төлнө.
  - Гуравдагч этгээдэд төлбөр төлөх үүргээ хугацаанд нь биелүүлээгүйтэй холбоотой гүйцэтгэгч болон гуравдагч этгээдэд учирсан аливаа хохирол, эцсийн хариуцлагыг Захиалагч хүлээнэ.
  - Захиалагчийн зүгээс энэхүү гэрээнд заасан аливаа хугацаа /зураг төсөл хүлээлгэн өгөх, санхүүжилт олгох, гэрээ байгуулах зөвшөөрөл олгох болон цаг үеийн шинжтэй шуурхай шийдвэрлэх бусад асуудал/-г хэтрүүлснээс

үүссэн аливаа хохирол, хариуцлагыг гүйцэтгэгч хариуцахгүй. Энэхүү хэсэг нь гэрээний бусад нөхцөлтэй зөрчилдсөн бол энэхүү хэсгийг дагаж мөрдөнө.

- Гүйцэтгэгч гэрээт ажлыг бүхэлд нь гуравдагч этгээдээр гүйцэтгүүлж үл болно.
- Гүйцэтгэгч гуравдагч этгээдийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын хүрээнд бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалт, мэргэжил, арга зүйгээр хангах, хяналт тавих үүрэг бүхий Дэд ажлын хэсгийн зөвлөмж, чиглэлийг авсан байна.
- Гүйцэтгэгч нь туслан гүйцэтгэгчийн ажлын үр дүн, эрсдэлийг Захиалагчийн өмнө бүрэн хариуцна.
- Туслан гүйцэтгэгчтэй байгуулах гэрээнд Гэрээний 4.5 */Туслан Гүйцэтгэгчийн үүргийг шилжүүлэх/*, Гэрээний 15.2 */Захиалагчийн зүгээс гэрээг цуцлах/ – т заасны дагуу Захиалагч түүнд шаардлага тавих эрхтэй байх нөхцөлийг заавал оруулна.*
- Гүйцэтгэгч нь гэрээний үүргээ 2 буюу түүнээс дээш удаа зөрчсөн бол гэрээг захиалагчийн санаачлагаар цуцалж болно.
- Гүйцэтгэгч нь Гэрээний 1.10 */Нууцлал/*-т заасан шаардлагыг мөрдөх баталгаа гаргах ба туслан гүйцэтгэгч бүр нэгэн адил энэ шаардлагыг мөрдөн хэрэгжүүлэх үүрэгтэй.
- Туслан Гүйцэтгэгч нь хуульд заасан тусгай зөвшөөрөлтэй, тухайн ажлыг гүйцэтгэхэд хүрэлцэхүйц ажиллах хүч, техник хэрэгслийн нөөцтэй, эрсдэл даах санхүүгийн чадавхитай хуулийн этгээд байна. Шаардлагатай тохиолдолд туслан гүйцэтгэгч нь аюулгүй байдлын гэрчилгээтэй этгээд байна.
- Гүйцэтгэгч нь гуравдагч этгээдтэй гэрээ байгуулах тохиолдолд Захиалагчтай санхүүжилтийн гэрээ байгуулахыг үүрэг болгосон заалт тусгана.

3.1.7. Гэрээний нөхцөлийн 4.14 дэх заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулав.

#### **Технологийн зам барих**

Гүйцэтгэгч үндсэн хугацаанд ажлын талбай руу явах шаардлагад нийцсэн технологийн зам барина гэдгийг тооцсон байна. Гүйцэтгэгч ямар нэгэн зам, гүүрийг өөрийн ашиглаж буй тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, эсхүл Гүйцэтгэгчийн ажилтнуудын буруутай үйлдлээс болж эвдрэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна. Энэ арга хэмжээ нь тээврийн хэрэгсэл болон түр замыг ашиглахад шаардлагад нийцсэн байна.

Эдгээр нөхцөлүүдэд өөрөөр заагаагүй бол:

- (a) Гүйцэтгэгч өөрийн ашиглах технологийн замд шаардлагатай ямар нэгэн засвар арчлалтыг хариуцна.
- (b) Гүйцэтгэгч технологийн замын дагууд шаардлагатай тэмдэг тэмдэглэгээгээр хангах ба технологийн зам, тэмдэг тэмдэглэгээг

тавихда холбогдох байгууллагаас зөвшөөрөл авсан байна.

- (с) Захиалагч технологийн замын ашиглалтаас үүдэлтэй ямар нэгэн нэхэмжлэлийг хариуцахгүй.
- (d) Захиалагч технологийн замын шаардлагад нийцсэн эсэхэд баталгаа өгөхгүй.
- (e) Гүйцэтгэгчид шаардлагатай технологийн замд гарах зардлыг Гүйцэтгэгч өөрөө даана.

3.2. Гэрээний нөхцөлд дараах утга, агуулга бүхий хэсэг нэмэхээр тохиролцов. Үүнд

3.2.1. Гэрээний нөхцөлийн 14.2 дахь заалтад “Гүйцэтгэгч ажил гүйцэтгэхэд шаардлагатай бараа материал, ажил, үйлчилгээг НӨАТ төлөгч хуулийн этгээдээс худалдан авах тохиолдолд Захиалагч тухайн этгээдтэй санхүүжилтийн гэрээ байгуулж, Гүйцэтгэгчийн хүсэлтээр төлбөрийг олгоно. Төлбөрийг олгохдоо төлбөрийн хүсэлтэд дурдсан зааврын дагуу удирдлагын зардлын 30 хувийг ЗХЖШ-ЗХББДГ-т шилжүүлэх үүргийг Захиалагч хүлээнэ.” гэж;

3.2.2. Гэрээний нөхцөлийн 12-т “Гэрээнд заагдаагүй бусад барилгын ажлыг гүйцэтгүүлэхээр Гүйцэтгэгчид эрх олгосон тохиолдолд /доод бүтцийн хоолой барих, балласт нийлүүлэх зэрэг/ энэхүү Ажил гүйцэтгэх гэрээний барилга угсралтын ажлын нэг төрөл болгон гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлнэ” гэсэн заалт;

3.2.3. Гэрээний 13.3 дахь заалтад “Гэрээг хэрэгжүүлэх явцад зураг төсөлд алдаа гарч түүнийг захиалагч зассан бол гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч нь хийгдсэн ажлыг буцааж дахин шинэчлэн хийх бөгөөд түүнтэй холбоотой гарсан зардлыг захиалагч бүрэн хариуцна. Энэ тохиолдолд гэрээт ажлын хугацааг харилцан тохиролцож сунгана.” гэсэн хэсгийг тус тус нэмэв.

3.3. Гэрээний нөхцөлөөс дараах заалтыг хасахаар тохиролцов. Үүнд:

3.3.1. Гэрээний 14.1.1 дэх хэсгээс “...бүх төрлийн техник хэрэгсэл,...” гэсэн хэсгийг;

3.3.2. Гэрээний нөхцөлийн 4.5 /Туслан Гүйцэтгэгчийн үүргийг Захиалагчид шилжүүлэхгүй./ дахь заалт;

3.3.3. Гэрээний нөхцөлийн 5.1 /Хүлээн зөвшөөрөгдсөн туслан гүйцэтгэгчийн тодорхойлолт. Энэ нь Захиалагчийн зүгээс Гүйцэтгэгчид туслан гүйцэтгэхийг бичгээр зөвшөөрсөн туслан гүйцэтгэгч байна. Ийнхүү зөвшөөрсөн нь туслан гүйцэтгэгчийн өмнө Захиалагч аливаа үүрэг, хариуцлага хүлээх үндэслэл болохгүй./ дэх заалт;

3.3.4. Гэрээний нөхцөлийн 5.2 /Туслан гүйцэтгүүлэхээс татгалзах. Захиалагч Гүйцэтгэгчийн санал болгосон туслан гүйцэтгэгчийг шаардлага хангаж байгаа эсэхэд үнэлэлт өгч, үндэслэл бүхий шалтгаанаар түүнийг туслан гүйцэтгэгчээр ажиллуулахаас татгалзаж болно./ дахь заалт;

3.3.5. Гэрээний 5.3 /Хүлээн зөвшөөрөгдсөн туслан гүйцэтгэгчид төлөх төлбөр. Гүйцэтгэгч нь Захиалагчийн хүлээн зөвшөөрсөн туслан гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний дагуу төлөх ёстой түүний нэхэмжлэхэд заасан дүнг туслан гүйцэтгэгчид төлнө. Ийнхүү төлөх дүн дээр нэмэгдсэн төлбөр, хураамжийг Гэрээний 5.4 /Төлбөрийг нотлох баримт бичиг/-т зааснаас гадна

13.5 /Тур тооцсон дүн-д заасны дагуу гэрээний дүнд оруулна./ дахь заалтыг тус тус хасав.

3.3.6. Гэрээний 20 дугаар зүйлд "Хэрэв гүйцэтгэгч 28 хоногийн хугацаанд нэхэмжлэх гаргаагүй буюу мэдэгдэл өгөөгүй бол, нэмэлт хугацаа олгохгүй бөгөөд Гүйцэтгэгч нэмэлт төлбөр авах эрхгүй болж, захиалагч нэхэмжлэлтэй холбоотой бүх хариуцлагаас чөлөөлөгдөнө" гэсэн хэсгийг тус тус хасав.

3.4. Талууд энэхүү гэрээнд заасан нэмэлт, өөрчлөлтүүдийг харилцан тохиролцож, хүлээн зөвшөөрснийг тодорхойлов.

### ГУРАВ.БУСАД ЗҮЙЛ

3.1. АГГ-Н/1901, Н/387 тоот гэрээнд энэхүү гэрээгээр нэмэлт, өөрчлөлт оруулсанаас бусад нөхцөл, талуудын үүрэг хариуцлага болон аливаа нөхцөлүүд нь бүхэлдээ хүчин төгөлдөр хэвээр байна.

3.2. Энэхүү гэрээг ижил хүчинтэй 2 хувь үйлдсэн ба эдгээр нь АГГ-Н/1901, Н/387 тоот гэрээний салшгүй хэсэг болно.

### ГЭРЭЭГ БАЙГУУЛСАН:

Захиалагчийн төлөөлж:


"Монголын төмөр зам" ТӨХК-ийн  
Гүйцэтгэх захирал



Р.БАТСҮХ

Гүйцэтгэгчийг төлөөлж:

Зэвсэгт хүчний Жанжин штаб, Бүтээн  
байгуулалт дэмжлэгийн газрын дарга



Д.ЖАРГАЛСАЙХАН

ИЛ БОЛСОН



ТЭВСЭГТ ХҮЧНИЙ  
ЖАРГАЛСАН ШТААЛЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2020 оны 03 сарын 04 өдөр

Хуудал 1/88

Улаанбаатар

Эрх шилжүүлэх тухай

Засгийн газрын агентлагын эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1 дэх заалт, 8.4 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, Иргэний хуулийн 62 дугаар зүйлийн 62.7 дахь хэсэг, Зэвсэгт хүчний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 01 дүгээр зарлигаар батлагдсан "Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, техник хэрэгсэлийг улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцуулах журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Монголын төмөр зам" ТӨХК-тай 2019 оны 06 дугаар сарын 12-ны өдөр байгуулсан АГТ-Н/1901, мн/387 дугаартай ажил гүйцэтгэх гэрээнд хууль, тогтоомжид нийцүүлэн нэмэлт өөрчлөлт оруулах, гэрээ байгуулах эрхийг Зэвсэгт хүчний Бүтээн байгуулалтын дэмжлэгийн газар /Д.Жаргалсайхан/-т олгосугай.

2. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулснаас үүсэх эрх зүйн үр дагаварыг харигуцан ажиллахыг Зэвсэгт хүчний Бүтээн байгуулалтын дэмжлэгийн газар /Д.Жаргалсайхан/-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Зэвсэгт хүчний Хяналт шалгалт, үнэлгээний газар /даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч хурандаа Д.Ариунболд/-т даалгасугай.

ДАРГА  
ХОШУУЧ ГЕНЕРАЛ



Д.ГАНЗОРИГ



Тыягын-2020

09070033

ИЛ БОЛСОН

МАШ НҮҮЦ

НУУХ

ТАВАНТОЛГОЙ-ЗҮҮНБАЯН ЧИГЛЭЛИЙН ТӨМӨР ЗАМЫН ШУГАМЫН  
ДООД БҮТЦИЙН БАРИЛГЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ АГГ-Н/1901-МН/387 ТООТ  
ГЭРЭЭНД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ГЭРЭЭ

2020 оны 07 дугаар  
сарын 01-ний өдөр

Дугаар АТТ-Н/1901-02

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг Монгол Улсын Иргэний хуулийн 343-358 дугаар зүйл, "МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ" Төрийн өмчит хувьцаат компани болон ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБ хооронд байгуулсан "Төмөр замын шугамын доод бүтцийн барилгын ажил гүйцэтгэх" 2019 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн АГГ-Н/1901-МН/387 тоот гэрээний 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.3 дах заалтууд, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2020 оны А/88 дугаар тушаалыг тус тус үндэслэн:

нэг талаас "МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ" ТӨХК-ийн ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Р.БАТСҮХ

(улсын бүртгэлийн 9012001025, регистрийн 5214203 дугаартай цаашид  
"Захиалагч" гэх);

нөгөө талаас ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН  
ДЭМЖЛЭГИЙН ГАЗРЫН ДАРГА Д. ЖАРГАЛСАЙХАН

(улсын бүртгэлийн 9068001032, регистрийн 8313962 дугаартай цаашид  
"Гүйцэтгэгч" гэх);

нар Зэвсэгт хүчний бүтээн байгуулалт дэмжлэгийн газрын "Гэрээний хугацаанд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" 2020 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 703 тоот албан хүсэлтийг Талууд хүлээн зөвшөөрч дараах нөхцөлийг харилцан тохиролцов.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Төмөр замын шугамын доод бүтцийн барилгын ажил гүйцэтгэх 2019 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн АГГ-Н/1901-МН/387 дугаартай гэрээ (цаашид "Ажил гүйцэтгэх гэрээ" гэх) болон түүний хавсралтад дараах нөхцлийг Талууд харилцан тохиролцож, гэрээний нөхцлийн 1 дүгээр зүйлийн 1.2-д заасныг үндэслэн нэмэлт, өөрчлөлт оруулахаар тогтов.

ХОЁР.ГЭРЭЭНД ОРУУЛАХ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ

2.1. Ажил гүйцэтгэх гэрээний 9 дүгээр зүйлд заасан Хавсралт №7-Барилгын ажил гүйцэтгэх календарьчилсан төлөвлөгөөг шинэчилж баталгаажуулна.

2.2. Энэ зүйлийн 2.1-д шинэчлэн баталсан календарьчилсан төлөвлөгөө нь АГГ-Н/1901-МН/387 дугаартай Ажил гүйцэтгэх гэрээний хавсралт-түүний



**ИЛ БОЛСОН**

салшгүй хэсэг гэж үзэх ба гэрээний багц баримт бичгийн бүрэлдэхүүн хэсэг байна.

2.3 Энэхүү нэмэлт өөрчлөлт оруулах гэрээнд Талуудын эрх бүхий албан тушаалтан нар гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулсанаар хүчин төгөлдөр болно.

2.4 Энэхүү нэмэлт өөрчлөлт оруулсанаас бусад Ажил гүйцэтгэх АГГ-Н/1901-МН/387 дугаартай гэрээний өмнөх нөхцөл өөрчлөгдөхгүй, Талуудын эрх, үүрэг, хариуцлага болон аливаа нөхцөл нь бүхэлдээ хүчин төгөлдөр хэвээр байна.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

Гүйцэтгэгчийг төлөөлж:

ЗӨВСЭГТ ХҮЧНИЙ БҮТЭЭН  
БАЙГУУЛАЛТЫН ДЭМЖЛЭГИЙН  
ГАЗРЫН ДАРГА

Д.ЖАРГАЛСАЙХАН

Утас: 7015-2061 119284584  
8313982

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө 51 хаягт байрлах

И-мэйл: bdg\_demjleg@mil.gov.mn

Захиалагчийг төлөөлж:

"МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ"  
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ

Р.БАТСҮХ

Утас: 7000-8622, 7010-6655

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 13 хороолол (14230), Нарны зам-62 юнирн болдинг А блок 7-р давхар

И-мэйл: info@mtz.mn